МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ХҮҮХЭД ҮРЧЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, САНАЛ ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ”

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **БГСТ-24/029**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ А.Батбаатар

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

Нэг. Удиртгал.....1

Хоёр. Монгол Улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт.....2

Гурав. Хүүхэд үрчлэлтийн олон улсын эрх зүйн зохицуулалт.....10

Дөрөв. Гадаадын зарим орны хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа.....22

Тав. Хүүхэд үрчлэлтийн харилцаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам.....62

Зургаа. Дүгнэлт, санал.....85

Долоо. Эх сурвалж.....92

Нэг. Удиртгал

Энэ судалгааны ажлаар хүүхэд үрчлэлтийн Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийг Монгол улсын нэгдэн орсон Олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийн, дотоод болон гадаадын 4 улсын хүүхэд үрчлэлтийн практик, түүний эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, хүүхэд үрчлэлтийн харилцаанд зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт ярилцлага хийх, статистик дүн мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх замаар практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, түүнийг шийдвэрлэх арга замын талаар судалсан болно.

Мөн судалгааны арга зүйн хувьд эхлээд хүүхэд үрчлэлтийн харилцааны мөн чанар, түүний эрх зүйн зохицуулалтын гадаад дотоодын уламжлал, хөгжлийг түүхчлэх аргаар тоймлон авч үзсэн. Түүний дараа Монгол Улсын хүүхэд үрчлэлтийн дотоодын болон Олон улсын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг судлан үзэх замаар зөрчлийг илрүүлэх, нийцлийг хангах зорилгоор хууль зүйн дүн шинжилгээ хийсэн болно. Түүний дараа хүүхэд үрчлэлтийн сайн туршлагыг судлах зорилгоор үрчлэлтийн сайн бодлого, туршлага, процесс, журам бүхий, эрх зүйн сайн зохицуулалттай Хятад, Франц, Герман, Америк улсыг сонгон авч дараах чиглэлээр Монгол улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан болно.Үүнд:

1. Үрчлэлтийн эх сурвалж
2. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг
3. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур
4. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага
5. Үрчлэлтийн дараах хяналт
6. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт
7. Байршуулахын үйл ажиллагааны зохицуулалт
8. Үрчлэлтийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
9. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ зэрэг асуудлын хүрээнд харьцуулан судалсан.

Энэхүү бүтээл нь хүүхэд үрчлэлтийн сайн бодлого, туршлага, эрх зүйн зохицуулалт бүхий гадаад орнуудын хүүхэд үрчлэлтийн практик, эрх зүйн зохицуулалтыг дотоодынхтой харьцуулан судалж, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудын хэрэгжилт, дотоодын хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлэх, хүүхэд үрчлэлтийн харилцаа, үрчлэлтийн процесс, процедурыг цогц байдлаар судалсаны үр дүнд дараах 4 багц асуудлыг илрүүлсэн. Үүнд:

1. Монгол Улсад хүүхэд үрчлэлтийн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, үйл ажиллагаанд баримтлах нэгдсэн журам байхгүй.
2. Монгол Улсын хүүхэд үрчлэлтийн харилцааны эрх зүйн зохицуулалт нь дотоодын болон олон улсын эрх зүйн хэм хэмжээтэйгээ зөрчилдсөн.
3. Хүүхэд үрчлэлтийн бодлого хэрэгжүүлэх, олон талт нарийн төвөгтэй энэ процессыг удирдах нэгдсэн чиг үүргийн байгууллага дутагдалтай.
4. Хүүхэд үрчлэлтийн процесст дэмжлэг үзүүлэх, мэдээлэл өгөх, өргөдөл хүсэлт хүлээн авах, бүртгэх, хянах, тайлагнах нэгдсэн цахим систем дутагдалтай байгааг илрүүлсэн болно.

Хоёр. Монгол Улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт

Монгол улсын гэр бүлийн эрх зүйн эх сурвалж нь үндэсний хууль тогтоомж, Монгол улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенцуудаас бүрдэнэ. Судалгааны ажлын сэдвийн хүрээнд хүүхэд үрчлэлтийн эрх зүйн харилцааг зохицуулж буй үндэсний хууль тогтоомж, олон улсын хэм хэмжээнүүдийг тоймлон судаллаа.

2.1. Үндэсний хууль тогтоомж

Хүүхэд үрчлэлтийн асуудал нь маш эмзэг нарийн ээдрээ төвөгтэй асуудал юм. Хууль зүйн ойлголтоороо нэг талаас хүний язгуур эрхийн асуудлыг хөндөгөл бол нөгөө талаараа гэр бүлийн бат бэх тогтвортой байдалд шууд нөлөөлдөг. Монголчуудын хувьд уламжлалт харилцаанд хүүхэд үрчлэн авах явдал бол эртнээс тогтсон зүйл бөгөөд “хүүхэд өргөж авах” гэж нэрлэх нь ч бий. Энэхүү харилцааны гол зарчим бол нэг талаас хүүхэд үрчилж авах эцэг эх, нөгөө талаас хүүхдийг үрчлүүлэх эцэг эх /асран хамгаалагч/ нь харилцан санаа нийлсэн байх нь чухал байдаг. МУ -ын Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх зарчим, түүнийг хангах баталгааг хуульчлан заасан. Тухайлбал:

1. Хүний үндсэн эрх, эрх чөлөөний жагсаалт;
2. Хүний эрх, эрх чөлөөг хангах;
3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх;
4. Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх;
5. Хүний эрх, эрх чөлөөг бүрэн хангах талаар төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тусгасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр үндсэн зарчмуудыг хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”[1] гэж зааснаар баталгаажуулсан юм. Үрчлэлт нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн асуудал болохынхоо хувьд хүүхдийн эрх, түүний хамгааллын хүрээнд зохицуулагдах асуудлыг багтаасан өргөн хүрээний ойлголт бөгөөд тодруулбал хүүхдийн гэр бүл, эцэг эхийг орлох хэлбэрийн онцгой зохицуулалт болох тул үрчлэлтийн бүхий л процесс хүүхдийн эрхийг хангах хүрээнд маш тодорхой зохицуулагдвал зохих хүний эрхийн асуудал юм. Түүнчлэн гэр бүлийн хуулийн 54-62 дахь зүйлүүдийн хүрээнд хүүхэд үрчлэлтийн системийг тогтоосон. Үүнд үрчлэлтийн систем нь:

- Дотоодын үрчлэлт (Монгол Улсын иргэн хүүхэд үрчлэн авах)
- Улс хоорондын үрчлэлт (Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах, эсвэл гадаадын иргэн дагавар хүүхдээ үрчлэн авах) байхаар тогтоосон.

Хүүхэд үрчлэлтийн харилцаанд оролцогчид нь иргэний харьяаллын хувьд нэг улсад харьяалагдаж байвал “дотоод үрчлэлт”, тэдгээрийн аль нэг нь гадаад улсын харьяат байх тохиолдолд уг харилцаа нь олон улсын хувийн эрх зүйгээр зохицуулагдах бөгөөд “олон улсын үрчлэлт“ буюу “гадаад үрчлэлт“ хэмээн нэрлэдэг.[2] Хүүхдийн эрхийн нэр томьёоны тайлбар тольд “улс хоорондын үрчлэлт" гэдгийг “Үрчлэн авагчийн иргэний харьяаллыг харгалзахгүйгээр хүүхдийн амьдрах улс орныг сольж үрчлэхийг ойлгоно” гэж тодорхойлсон байдаг.[3] Үрчлэлт нь хүүхэд үрчлүүлэх үйл ажиллагааны гол зорилготой

[1] Төрийн мэдээлэл сэтгүүл.1992 №1

[2] “Үрчлэлт ба Хүүхдийн эрх”, ХЭҮК-ийн Хүний эрхийн цуерал нийтлэл, УБ, 2014 75 дахь тал

[3] Хүүхдийн эрхийн нэр томьёоны тайлбар толь, УБ, 2011 дэх тал

хамааралтай бөгөөд хүүхдийн төрсөн эцэг эх элбэрэн халамжилж чадахгүй тохиолдолд түүнийг өөр тогтвортой гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх боломжоор хангахад чиглэгдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүүхдийг үрчлэхэд боломжтой аль аль талын эрх, ашиг сонирхол чухал байдаг. Гэр бүлийн хуулиар хүүхэд үрчлэх харилцаанд дараах нөхцөлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Хүүхэд үрчлэх үед төрүүлсэн эцэг эхийнх нь зөвшөөрлийг авах,
- 7 нас хүрсэн хүүхдээс өөрийнх нь саналыг заавал авах,
- Гэрлэгчид хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ бичгээр хамтран гаргаж баталгаажуулсан байхыг хуулиар шаарддаг.

Хуулийн дээрх зохицуулалт нь үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх бүрэн боломжтой хүн байх[4] шаардлагад тулгуурладаг. Харин зарим тохиолдолд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хүүхэд үрчлэхийг хориглодог. Тухайлбал: 60-аас дээш настай хүн, бусдын асрамжид байгаа хүн, эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, урьд үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаасан, ашиг хонжоо олох зорилгоор үрчилсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ өвчтэй[5], согтууруулах ундаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис байнга хэрэглэдэг зэрэг нөхцөлүүдийг тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл эдгээр нь "...зохих хэмжээнд хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх ямар ч боломжгүй[6] тохиолдлуудыг зааж өгсөн байна.

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн 141 дүгээр зүйлийн 141.1 дэх хэсэгт зааснаар "мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргана" гэж заасныг УДШ-ийн зөвлөмжид дурдсанаар "эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай эсхүл сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүйд тооцох эсэх асуудлыг шүүх шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сонирхогч этгээдийн хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар шинжээч томилж, дүгнэлт гаргуулна" [7] гэж заасан байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд шинжээчийн дүгнэлт гол нотлох баримтуудын нэг болох бөгөөд хавтаст хэрэгт авагдсан баримтаар давхар нотлогдсон байхыг шаарддаг. Харин иргэний эрх зүйн чадамжгүй хүний эрүүл мэнд сайжирсан тохиолдолд эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн уг иргэнийг бүрэн чадамжтай болсон талаар шүүх шийдвэр гарснаар хүүхэд үрчлэн авах эрх нээгдэх зохицуулалттай. Түүнчлэн сум дүүргийн засаг дарга баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт[8] гаргуулах бөгөөд дүгнэлтэд хүүхэд үрчилж авахад харшлах шалтгаан байгаа эсэхийг шалгах, холбогдох бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсний үндсэн дээр шийдвэрийг 20 хоногт багтаан гаргадаг. Хэрэв хуульд заасны дагуу үрчлүүлсэн хүүхдийн эцэг, эх, тэжээн

[4] "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 1999 №48

[5] "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 1999 №48

[6] Ц.Алтанцэцэг, "Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй", УБ, 2007 о 107 дахь тал

[7] Монгол улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын зөвлөмж, УБ, 2007 №5

[8] Төрийн мэдээлэл" сэтгүүл. 2018 №07 Иргэний Улсын бүртгэлийн тухай хууль

тэтгэх үүргээс чөлөөлөгдөх тохиолдолд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхээ алдах зохицуулалттай.

Хүүхэд үрчлэлтийн бас нэг язгуур эрх чөлөөний асуудал бол хувийн болон гэр бүлийн нууцлалын асуудал бөгөөд энэ талаар хуульд "чандлан хадгалах" үүргийг холбогдох албан тушаалтнууд хүлээлгэсэн байдаг. Хуулиар үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан хэлэлцэх бөгөөд дараах тохиолдолд үрчлэлтийг хүчингүйд тооцохоор хуульд тусгасан байдаг. Үүнд:

- Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан,
- Хүүхэдтэй хэрцгий харьцсан,
- Хүүхэд үрчлэн авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлж үрчлэн авах шийдвэр гаргуулсан,
- Хүүхэд үрчлүүлэхийг хуулиар хориглосон этгээд хүүхэд үрчлэн авсан нь илэрсэн зэрэг үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно.

Дээрх тохиолдлуудад хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь буцаах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хэрвээ хүүхдийг хүүхэд асрах байгууллагад шилжүүлэх тохиолдолд зардлыг үрчлэгчээс гаргуулдаг байна. Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133-р зүйлийн 133.4 дэх хэсэгт: "...хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох[9]...", Харьяатын тухай хуулийн 13-р зүйлд: "...үрчлэгдсэн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэх[10]... ", Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2 болон 40 дүгээр зүйлийн 40.1.6 дах хэсэгт: "Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журмыг батлах, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах[11] талаар тус тус зохицуулж өгсөн байна.

Хуулийн дээрх зохицуулалтаас гадна *"Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам"* /ХЗДХ, НХХСайдын 2001 оны 100/32 тоот хамтарсан тушаал/, *"Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам"* /Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын 2010 оны А/396 тоот тушаал/, "*Үрчлэлтийн талаар хяналт тавих гурван талт гэрээ"* зэргээр зохицуулж байна.

"Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам"-аар үрчлэлтийн асуудлыг хэрхэн зохицуулсаныг авч үзье. Үрчлэлтийн өргөдөл гаргах зохицуулалт хувьд нь:

- Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтийг Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын байгууллагаар уламжлан гаргана.
- Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны болон байнга оршин суугаа газрынхаа үрчлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагаар уламжлан Монгол Улсын Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

[9] "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 2002 №20

[10] "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 1995 №13

[11] "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 2010 №17

- Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэн хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ шууд Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх ерөнхий нөхцлийн хувьд:

- Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авсан гадаадын иргэнд эхний хүүхэд үрчлэн авснаас хойш нэг жилийн дотор манай улсын харьяат хүүхдийг дахин үрчлүүлэхгүй. Энэ нь ихэр хүүхэд эсхүл төрсөн ах, эгч дүү нарыг үрчлэн авахад хамаарахгүй.
- Монгол Улсын харьяат хүүхдийг таваас доошгүй жил хамт амьдарсан гэр бүлд, эсхүл ганц бие гадаадын иргэн эмэгтэйд үрчлүүлж болохоор заасан. 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “ганц бие” хүнд хүүхэд үрчлүүлэхгүй байхаар өөрчлөлт оруулсан болно. Гэсэн хэдий ч уг заалт журамд хэвээр үйлчилсээр байгааг цаашид анхаарах шаардлагатай болно.
- 60-аас дээш насны гадаадын иргэн, эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан эсвэл хязгаарлуулж хасуулж байсан, урьд нь үрчилж авсан хүүхдээ өөрийн буруугаас буцааж өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, хорих ял эдэлж байгаа болон ганц бие эрэгтэй гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхгүй.
- Долоо ба түүнээс дээш настай хүүхдийг үрчлүүлэхэд өөрийнх нь зөвшөөрлийг авч энэ тухай тэмдэглэл хөтлөхөөр зохицуулсан байна.

Үрчлэхийг хүсэгч гадаадын иргэн дараах баримт бичгийг бүрдүүлэхээр заасан:

- Хүүхэд үрчлэн авах тухай /гэр бүлтэй бол хамтарч гаргасан/ өргөдөл, түүний албан ёсны орчуулга;
- Иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг болон гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээний хуулбар;
- Өөрийн болон гэр бүлийн хоёр үеийн намтар, зураг, байнга оршин суугаа газрын болон санхүүгийн боломжийн тухай холбогдох байгууллагын тодорхойлолт;
- Энэ журмын 8-д заасан харшлах нөхцөл байхгүй тухай цагдаа, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагын тодорхойлолт;
- Гадаадын харьяат хүүхэд үрчлэхийг болон түүнийг өөрийн улсад нэвтрэн орох, байнга оршин суухыг зөвшөөрсөн үрчлэгчийн харьяалах улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

Дээрх баримт бичгийг үрчлэгчийн харьяалах улсын холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулахаар заасан.

Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд үрчлэн авах тухай материалыг хүлээн авч баримт бичиг хангалттай бүрдсэн гэж үзвэл 30 хоногийн

дотор үрчлэгдэх хүмүүсийг судлан сонгож дор дурдсан материалыг бүрдүүлэн, үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнд холбогдох байгууллагаар дамжуулан хүргүүлнэ. Үүнд:

- Төрсний гэрчилгээ;
- Бүтэн өнчин, эцэг, эх нь тодорхойгүй хүүхэд үрчлэх бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эсвэл асрамжийн газрын зөвшөөрөл, түүнчлэн эцэг эх нь нас барсныг гэрчлэх баримт бичиг;
- Хагас өнчин хүүхэд үрчлэх бол эцэг, эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;
- Хүүхдийн эцэг эх сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, эсхүл эцэг эх байх эрхээ хасуулсан бол энэ тухай шүүхийн шийдвэр болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл /эцэг, эх байх эрхийг хассан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа хүүхдийг үрчлүүлнэ/;
- Эцэг эх нь ахуй амьдралын гачигдлаас шалтгаалж хүүхдээ хэвийн өсгөх боломжгүй бол энэ тухай сум, дүүргийн засаг даргын тодорхойлолт, эцэг эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;
- Хүүхдийн эрүүл мэндийн талаарх эмнэлгийн байгууллагын дүгнэлт.

Дээрх материалыг хүлээн авсан гадаадын иргэнээс хүүхдийг үрчилж авах тухай санал ирүүлсэн тохиолдолд Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрийн санал дүгнэлтээ гаргаж холбогдох материалын хамт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд хүргүүлнэ. Дээрх саналыг үндэслэн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба 30 хоногийн дотор үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж, гаргасан шийдвэрийн талаар гадаад улсын иргэн болон эрх бүхий байгууллагад уламжилна.

Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авагч гадаадын иргэн дараах үүрэг хүлээхээр хуулинд заасан байна. Үүнд:

- Хүүхдийг хэвийн өсч бойжих, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах нөхцөлөөр хангах;
- Хүүхдийн эх орон, шаардлагатай бол эцэг, эхийг мэдүүлэх;
- Үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам монгол улсын гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд монгол улсын эрх бүхий байгууллагаас тухайн хүүхдийн аж байдалтай танилцах, түүнтэй ярилцах боломжоор хангахаар зохицуулсан.

Хүүхэд үрчилснийг бүртгэх талаар дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв үрчлэгдэх хүүхдэд төрсний гэрчилгээ, хүүхдээ үрчлүүлж байгаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхэд үрчилсний гэрчилгээ, хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэнд хүүхдийг үрчлэн авсны гэрчилгээ олгож үрчлэлтийг бүртгэнэ.
- Хүүхэд үрчлэн авсныг бүртгэхэд хүүхэд үрчлэн авч байгаа эцэг эх, эсхүл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч, үрчлүүлж байгаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл тэдгээрийн төлөөлөгчийг байлцуулахаар заасан болно.

Хүүхдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах үүднээс дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч баримт бичиг бүрдүүлэн үрчлэх шийдвэр гаргуулсан тохиолдолд үрчлэлтийг хүчингүй болгох тухай асуудлыг шүүхэд тавьж шийдвэрлүүлэх.
- Үрчлэлтийг хүчингүй болгосноос гарах зардлыг үрчлэн авагч бүрэн хариуцах.
- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь үрчлэгдсэн хүүхдийн талаарх мэдээллийг үрчлэгчийн харьяалах улсад суугаад Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын байгууллагад албан ёсоор мэдэгдэх.
- Үрчлэлтийн асуудалд олон нийтээс тавих хяналтыг Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын итгэмжлэгдсэн этгээд хэрэгжүүлж болохоор заасан.

Дээрх журамд “Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн дагавар хүүхдээ үрчлэн авахад энэ журам үйлчлэхгүй” байхаар заасан. Энэ нь нэг талаар тухайн гадаадын иргэн болон гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх, гадаадын иргэн харьяалалгүй этгээдэд тавигддаг нарийвчилсан шаардлага болох ярилцлага хийх, хяналт шалгалт хийх босгыг багасгах зорилготойгоор хийгдсэн журам гэж үзэж болохоор байна. Ингэснээр хойд эцгийн хувьд засаг даргын зөвшөөрөл олгосон захирамжийг үндэслэж хүүхэд үрчлэн авах эрхтэй болсноор эрх зүйн зохицуулалтын хувьд хялбар болно. Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал дүгнэлт холбогдох материалыг хүлээн авсан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журамд заасны дагуу ярилцлага хийнэ. Ярилцлагын бүрэлдэхүүнд үрчлэгч эцэг, эх, комиссын дарга, гишүүд, /гурваас доошгүй/ нарийн бичгийн дарга байна. Үрчлэгч нь хүсэлтээ харьяалах улсын итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан ирүүлсэн бол тус байгууллагын албан ёсны төлөөлөл багтана.

Ярилцлага хийх дарааллын хувьд:

- Комиссын нарийн бичгийн дарга хүүхэд үрчлэн авч буй эцэг, эх болон тухайн үрчлэлттэй холбогдох мэдээллийг танилцуулна.
- Ярилцлагыг заасан сэдвээр асуулт хариулт, харилцан ярилцах дарааллаар явуулж, Комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлнө.
- Үндсэн асуултыг асууж, хариулт авсны дараа Комиссын гишүүд үрчлэгч эцэг, эх /итгэмжлэгдсэн байгууллагын албан ёсны төлөөлөл/-ээс нэмэлт асуулт асууж хариулт авна.

Ярилцлага хийх сэдвийн хувьд:

- Үрчлэгч эцэг, эхийн санаа, зорилго, хүүхэд үрчлэн авах шалтгаан;
- Үрчлэгч эцэг, эхийн эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт болон санхүүгийн нөхцөл байдал;
- Үрчлэгч эцэг, эхийн үрчлэлтийн талаарх ойлголт;
- Тухайн гэр бүлийн түүх болон ирээдүйн төлөвлөгөө;
- Үрчлэгдэх хүүхдийн эрүүл мэндийн байдал;
- Үрчлэгдэх хүүхдийн онцлог;
- Хүүхдийг ирээдүйд хэрхэн нийгэмшүүлж, боловсрол олгох талаар үрчлэгч эцэг, эхийн хандлага;

- Үрчлэлттэй холбогдох хоёр орны хууль тогтоомж болон бусад асуудлаар ярилцана.
- Үрчлэгч эцэг, эх /харьяалах улсын итгэмжлэгдсэн байгууллагын албан ёсны төлөөлөл/-д үрчлэлтийн дараа хяналт тавих гэрээний заалт бүрийг танилцуулж хэрхэн ойлгох талаар тайлбарлана.

Комиссын гишүүдийн эрх, үүргийн хувьд:

- Ярилцлагыг комиссын дарга удирдан явуулна.
- Үрчлэгч эцэг, эхээс үндсэн болон нэмэлт асуулт асууж, хариулт авах;
- Санал, дүгнэлт гаргах;
- Үрчлэгдэх хүүхдийн нөхцөл байдалтай биечлэн очиж танилцах, асран хамгаалагчаас нь мэдүүлэг авах;
- Ярилцлагад товлосон цагт ирж, идэвхи санаачлагатай, ажил хэрэгч оролцох;
- Монгол улсын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх;
- Өөрийн гаргасан саналын үндэслэлийг тайлбарлана.

Ярилцлагаас дүгнэлт гаргах ажиллагааны хувьд:

- Ярилцлагын дараа Комиссын даргын шийдвэрээр хүүхдийг үрчлүүлэх эсэх талаар санал хураалт явуулна.
- Санал хураалтад оролцсон Комиссын гишүүдийн олонхийн саналаар эцсийн дүгнэлт гаргана.
- Хүүхдийг үрчлүүлэхээс татгалзах саналтай Комиссын гишүүн өөрийн санал, дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хуралдаанд бичгээр танилцуулна.

Комиссын гишүүд ярилцлагыг үндэслэн дараахь тохиолдолд хүүхдийг үрчлүүлэхээс татгалзаж болно. Үүнд:

- үрчлэгч эцэг, эхийн хариултууд нь бүрдүүлж ирүүлсэн материал дахь мэдээлэлтэй зөрж байсан;
- хуурамч баримт бичиг бүрдүүлж ирүүлснийг нь тогтоосон;
- хүүхэд үрчилж авсны дараа гарах асуудлыг шийдвэрлэх арга замыг мэдэхгүй, эргэлзсэн хариултууд өгсөн;
- хүүхэд үрчилж авах шалтгаан, нөхцөл нь тодорхой бус байсан;
- үрчлэгч эцэг болон эхийн санаа, зорилго нийлэхгүй байсан;
- үрчилж авах гэж буй хүүхдийн талаар мэдээлэл аваагүй байсан;

Ярилцлагын дүгнэлтийн талаар Комиссын нарийн бичгийн дарга танилцуулга бэлтгэн Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхээр зохицуулсан бол "*Үрчлэлтийн талаар хяналт тавих гурван талт гэрээ"*-ээр дараах асуудлыг тусгаж өгсөн байна. Үүнд: Үрчлэгдсэн хүүхэд Монгол Улсын хуулийн дагуу 16 насанд хүртлээ Монгол Улсын харьяат байх, 16 насанд хүрмэгц харьяатаа чөлөөтэй сонгох боломжоор хангахыг дээр дурьдсан 3 талт гэрээнд зааж өгдөг байна. Мөн үрчлэгдсэн хүүхдийг тухайн гэр бүлд хэвийн өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах бүх нөхцлөөр хангах, хувцас, хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслээр гачигдуулахгүй, хүүхэдтэй хэрцгий харьцахгүй байх, уугуул эх орон, ёс заншил, түүх соёлын уламжлалыг танин мэдэх боломжоор хангах талаар нарийвчлан гэрээнд тусгана. Үрчлэгч эцэг, эх

үрчлэгдсэн хүүхдийн талаарх мэдээллийг өөрийн улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт жил бүр мэдээлж байх, хүүхдийн өсч бойжиж буй фото зураг, видео бичлэг зэргийг хүүхдийг 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам хийж Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд ирүүлэх зэргээр үрчлэлтийн дараах хяналтыг ч тодорхой тусгасан байна. Түүнчлэн үрчлэгдсэн хүүхэд нь үрчлэгч эцэг, эхийн байнга оршин суугаа улсад ирмэгц зуучлагч, зуучлагч байгууллага нь үрчлэгч эцэг эхтэй нь холбоо тогтоон, нийгмийн ажилтнаа явуулж хүүхдийн байдалтай танилцах арга хэмжээ авах, үрчлэгч эцэг, эх оршин сууж буй газраа өөрчилсөн бол тухай бүр хаягийн өөрчлөлт хийсэн тухай өөрийн орны эрх бүхий байгууллагад болон Монгол Улсаас тус улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт даруй мэдэгдэх үүрэгтэй байхаар чиг үүргийг нь хуулиар тусгайлан зааж өгсөн байна.

Гурав. Хүүхэд үрчлэлтийн олон улсын эрх зүйн зохицуулалт

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх эрх зүйн харилцааг зохицуулж буй гадаад эх сурвалж, хэм хэмжээний хувьд авч үзье.

Хүүхдийн эрхийн тухай конвенц. Хүүхдийн эрхийн тухай конвенцод Монгол улс нь 1990 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зуран, 1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр уг конвенцод нэгдэн орсон.[12] Энэ үеэс эхлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу уг конвенцыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Хүүхдийн эрхийн тухай конвенцод өнөөгийн байдлаар дэлхийн 140 орон гарын үсэг зурж, 196 орон нэгдэн орсон[13] байдаг бөгөөд ийнхүү конвенц нь дэлхийн хамгийн өргөн хүрээнд соёрхон баталсан чухал хүүхдийн эрхийн гэрээ бөгөөд хүүхдийн иргэний эрх болон нийгэм эдийн засгийн эрх аль алиныг нь хамгаалдгаараа онцлог болно. Хүүхэд үрчлэлтийн харилцаанд хамаарах асуудлыг Хүүхдийн эрхийн тухай конвенцоор зохицуулсан бөгөөд үүнд:

- "үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүний хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина.”
- "хэрэв хүүхдийн хүмүүжил буюу үрчлэлтийг хангаж чадахуйц гэр бүлд байлгах буюу хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, эсхүл тухайн хүүхдийн төрсөн оронд зохих ёсоор нь асрамжлах боломжгүй бөгөөд өөр оронд үрчлүүлэх нь хүүхдийг асарч хамгаалах боломжтой арга хэмээн хүүхдийг асран хамгаалалтад түр шилжүүлэх, тохирох гэр бүлд үрчлүүлэх, эсхүл эх оронд нь зохих ёсоор асран халамжлах боломжгүй бол үндэстэн дамнан үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрнө”[14]

хэмээн зааснаар хүүхдийг эхлээд улс орны хүрээнд хамгаалж, дараагаар нь хүүхдийн дээд ашиг сонирхлын үүднээс улс хооронд хүүхэд үрчлэхийг хүлээн зөвшөөрсөн байна. Иймд оролцогч улсууд хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж, үндэснийхээ хүрээнд хүүхдийн эрхийг хэрхэн хангаж байгааг хэлэлцэж, санал дүгнэлт гарган, зөвлөгөө өгөх үүргийг Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороо хариуцдаг бөгөөд[15] тус хорооноос гаргасан ерөнхий зөвлөмжүүд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын хүрээнд баталгаажсан эрхийг тайлбарлах албан ёсны тайлбар болдог[16] ажээ. Хүүхдийн эрхийн хороо нь Хүүхдийн эрхийн тухай конвенц болон түүний нэмэлт протоколуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хүүхдийн эрхтэй холбоотой нөхцөл байдлын талаарх оролцогч улсуудаас тогтмол хугацаанд тайланг авч хэлэлцэж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргадаг[17] бөгөөд оролцогч улсууд нь конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор, үүнээс хойш 6 жил тутамд тайлан илгээх ёстой байдаг.[18] Өнөө үед Хүүхдийн эрхийн хороо нь хүүхдийн эрхийн талаар мэргэшсэн 18 ажилтнаас бүрдэж байгаа бөгөөд Монгол улсын

---

[12] Хүний эрх, үр нөлөөтэй удирдлага сурвалж бичиг, УБ, 2011 192 дахь тал

[13] United Nations Treaty Collection Conversion on the Rights of the Chald status, accessed April 14, 2018 https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=IND&mtdsgno=IV-11&chapter=4lang=en

[14] Хүүхдийн эрхийн тухай конвенцын 21 дүгээр зүйл, 1990 он

[15] Хүүхдийн эрхийн тухай конвенцын 43 дугаар зүйл, 1990 он

[16] Ч.Алтангэрэл орчуулга, "Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх-Ерөнхий зөвлөмж" Хүний эрх сэтгүүл, Дугаар №2 (2014), 2-67 дахь тал

[17] Committee on the Rights ofChild, accessed April 14, 2018, http://www.ohch.org/EN/HRBodies/CRC/Page/CRVInderasy

[18] Хүүхдийн эрхийн тухай конвенцын 44 дүгээр зүйл, 1990 он

хувьд Хүүхдийн эрхийн хороонд 1994 оноос хойш нийт 4 удаагийн 5 тайлан илгээсэн байна. Хүүхдийн эрхийн хорооноос 2013 оны 5 дугаар сарын 29-ны өдөр гаргасан "Хүүхдийн дээд ашиг сонирхол нь нэн тэргүүнд анхаарах зүйл" болох тухай Ерөнхий зөвлөмж № 14-д "Хүүхдийн дээд ашиг сонирхлыг бие даасан эрх, хуулийн үндсэн зарчим, процедурын журам гэх гурван түвшинд тайлбарласан.[19] Хүүхдийн дээд ашиг сонирхлын талаар судлаач А.Тайван Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын асуудал сэдвийн хүрээнд өөрийн бакалаврын ажлын хүрээнд тодорхой хэмжээнд судалж үзсэн байна.[20]

Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенц. Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцод улс бүр хүүхдийг өөрийн төрөлх гэр бүлийн асрамжид байх боломжийг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээг тэргүүн зэрэгт тавьж ажиллах шаардлагатайг онцлон тодорхойлж, харин өөрийн төрөлх улс оронд тохиромжтой гэр бүл олдохгүй байгаа нөхцөлд хүүхдийг байнгын гэр бүлийн давуутай талыг олгох боломжийн үүднээс улс хооронд үрчлэх үрчлэлтийн систем байж болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Улс хооронд үрчлэх системийн гол зорилго[21] нь:

- Үрчлэлтийг хүүхдийн дээд ашиг сонирхлын дагуу олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн түүний үндсэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэрэгжүүлэх баталгааг бий болгох,
- Хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдагдахаас сэргийлэх хууль зүйн баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох,
- Хүүхэд үрчлэлт нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдах боловч хүүхдийн эрхэм эрх ашгийг онцгой харгалзан үзэж, үүнд санхүүгийн ашиг хонжоо олохыг хориглосон байх.

Дээрх зохицуулалт нь хүүхдийн эрхийг хангах, тэдний эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хамгаалах үүднээс бүхий л үйл явц хуулиар зайлшгүй зохицуулагдах ёстой болохыг хүлээн зөвшөөрсөн хэрэг билээ.

Иймд үрчлэлтийн процессыг бүхэлд нь хамарсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Үрчлэх, үрчлүүлэх үйл ажиллагааг урьдчилан тогтоох үе шат,
2. Үрчлэх, үрчлүүлэх үе шат,
3. Үрчлэгдсэн хүүхдийг үрчлэн авсан эцэг эх болон тухайн улс оронд шилжүүлэх үе шат
4. Үрчлэлтийн дараах хяналтын үе шат зэрэг болно.[22]

---

[19] General Comment No. 14 (2013) on the right of the child to have his or her best interests taken as a primary consideration (art 3, para 1). p-8. Http://www2.ohchr.org/English/bodies/cro/docs/GG/CRCCGC14ENG.pdf

[20] Гэр бүлийн тухай хууль Төрийн мэдээлэл №2 1993

[21] Хүүхдийг хамгаалах болон Улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцын 1, 32 дугаар зүйл, 1993 он

[22] Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах конвенцод /1993.05.26 Гааг/

Эдгээр үе шат бүр нь хууль зүйн тодорхой шаардлагуудын хүрээнд зохицуулагдах ёстой болохыг тусгасан. ХЭҮК-ийн 2009 онд гаргасан Хүний эрх сэтгүүлд “Гадаадад хүүхэд үрчлүүлэхэд тавигдах гол шаардлага нь үрчлэлт нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэж байгаа эсэх, хүүхэд худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас сэргийлэх хянах (үрчлүүлэх болон үрчилсний дараа) явдал юм. Иймээс хүүхдийг үрчлүүлсний дараах хяналтыг сайтар тавих шаардлагатай” гэснээс үзвэл улс хоорондын үрчлэлтэд юун түрүүнд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахыг эрмэлздэг байна.

Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхэд үрчлүүлж байгаа тоон судалгааг авч үзвэл 1999-2022 оны хооронд гадаадад 274 хүүхэд үрчлэгдсэн байна. 2003 онд 35 буюу хамгийн их хүүхэд үрчлэгдсэн бол 2021 онд 0 буюу огт үрчлэлт хийгдээгүй байна. Дээрх тоон мэдээллээс дүгнэж үзэхэд жил ирэх тусам гадаадын иргэдээс МУ-ын харьяат хүүхэд үрчлэн авах нь багассаар, зарим жилд огт үрчлэлт хийгдээгүй байна. Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн хурлын сайтад[23] Гаагийн конвенцод нэгдэн орсон гишүүн улсуудаас жил бүр хэчнээн тооны хүүхэд үрчлэгдэж байгаа талаарх мэдээлэл нээлттэй байхад Монгол Улсын Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны сайтад[24] болон Гадаадын иргэн, харьяатын газрын сайтад[25] гадаад улс руу үрчлэгдсэн хүүхдүүдийн талаарх тоон мэдээлэл байршаагүй байгаа нь гадаад үрчлэлтийн хувьд Монгол Улсын бодлого хаалттай хэвээр үргэлжилсээр байгааг анхаарах цаг болсныг илтгэж байна.

Олон улсын гэрээ, конвенц

Монгол улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд[26], Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцод 1998 онд тус тус нэгдэн орсон.[27] байна. Конвенцын энэхүү заалтад нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” [28] гэж хуульчлан баталгаажуулсан байдаг.

Түүнчлэн Олон улсын гэрээний тухай хуулийн 3.1.5 дах хэсэгт заасны дагуу Монгол Улс тухайн гэрээгээр хүлээн зөвшөөрсөн аргыг энэ хуульд заасны дагуу заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрсний үндсэн дээр гэрээнд нэгдэн орж, Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг[29] баталснаар конвенцыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 21 дүгээр зүйлд үүхэд үрчлэлтийн харилцаанд хамаарах асуудлыг бүхэлд зохицуулсан бөгөөд үүнд "үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, хэрэв хүүхдийн хүмүүжил буюу үрчлэлтийг хангаж чадахуйц гэр бүлд байлгах буюу хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, эсхүл тухайн хүүхдийн төрсөн оронд

[23] https://www.hcch.net/?fbclid=IwAR0aG0oAGepYUkpcvc-QTEJ0kzdkF72FPos0tSdkbeNg3ReWYsquwui5wro

[24] info@mlsp.gov.mn

[25] https://immigration.gov.mn/

[26] Монгол улсын олон улсын гэрээ Хүүхдийн эрхийн тухай конвенц

[27] Хүний эрх, үр нөлөөтэй удирдлага сурвалж бичиг, УБ ., 2011 192 дахь тал

[28] “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2018 №18,

[29] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 64-65 дахь тал

зохих ёсоор нь асрамжлах боломжгүй бөгөөд өөр оронд үрчлүүлэх нь хүүхдийг асарч хамгаалах боломжтой арга хэмээн хүүхдийг асран хамгаалалтад түр шилжүүлэх, тохирох гэр бүлд үрчлүүлэх болон эх оронд нь зохих ёсоор асран халамжлах боломжгүй байх тохиолдолд үндэстэн дамнан үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрнө"[30] хэмээн заасан нь хүүхдийг улс орны хүрээнд хамгаалах эсвэл хүүхдийн дээд ашиг сонирхлын үүднээс улс хооронд хүүхэд үрчлэх боломжийг олгоход чиглэгдсэн зохицуулалт юм.

Харин оролцогч улсууд хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж, үндэснийхээ хүрээнд хүүхдийн эрхийг хэрхэн хангаж байгааг хэлэлцэж, санал дүгнэлт гарган, зөвлөгөө өгөх үүргийг Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороо[31]-нд хариуцуулсан нь тус хорооноос гаргасан зөвлөмжүүд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын хүрээнд баталгаажсан эрхийг тайлбарлах албан ёсны тайлбар[32] болох учир НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо 2009, 2010 онуудад Монгол Улсын гурав болон дөрөв дэх удаагийн илтгэлийг хэлэлцээд 2010, 2017 онд дүгнэлт, зөвлөмж өгсөн байдаг. Тухайлбал НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо 2010 оны 1 дүгээр сард дараах дүгнэлт, зөвлөмжийг[33] ирүүлсэн. Үүнд:

- Хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, үрчлэлтийн дараах хяналтын механизмыг бүрдүүлэх.
- Мөн үрчлэлтийг бүртгэхээс бусад бүх үе шат хуулийн зохицуулалтгүй хэвээр байна. Дотоод үрчлэлтийн механизм, үрчлэн авагч эцэг эхэд тавигдах шалгуур, үрчлэгчийн гэр бүлд судалгаа хийх, хараат бус дүгнэлт гаргах нийгмийн ажлын үйлчилгээ, үрчлэгчдийг сургалтад хамруулах, үрчлэгдсэн хүүхдийн байдалд хяналт тавьж үнэлгээ хийх зэрэг үе шатууд огт шийдвэрлэгдээгүйд харамсаж байгаагаа илэрхийлсэн.
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос зөвлөмжүүдийг удаа дараа биелүүлэхгүй байгаа тохиолдолд Гаагийн конвенцоос хасах хүртэл арга хэмжээ авч болохыг сануулсан байдаг.

Мөн Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжид хүүхэд үрчлэлтийн практикт хангалттай дэвшил гараагүй талаар дурдаж өмнө өгсөн зөвлөмжүүдийг биелүүлэх, хүүхдийг үрчлүүлэхэд үрчилж авч байгаа эцэг эхийн талаар үнэлгээ хийхдээ тогтоосон журмыг баримтлах, үрчлэлтийн бүхий л үйл явцад ил тод байдлыг хангах шаардлагуудыг тавьсан [34] байдаг. Учир нь Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцод өнөөгийн байдлаар 105 орон[35] нэгдэн орсноор конвенцын хэрэгжилтийг хангахад чухал алхам болсон юм.

Улс хооронд хүүхэд үрчлэх системийн гол зорилго нь:

- Үрчлэлтийг хүүхдийн дээд ашиг сонирхлын дагуу олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн түүний үндсэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэрэгжүүлэх баталгааг бий болгох

[30] "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн тусгай дугаар 1-р боть 2004 он

[31] Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайт

[32] Ч.Алтангэрэл орчуулга."Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх-Ерөнхий зөвлөмж"Хүний эрх сэтгүүл, Дугаар №2 2014 2-67 дахь тал

[33] United Nations Committee on the Rights of the Child Fifty-third session 11-29 January 2010, p-9

[34] НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо, Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт зөвлөмж, УБ хот, 2017 8 дахь тал

[35] Statute of the Hague Conference on Private International Law https://www.hcch.net/en/instruments/conventions/status-table/

- Хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдахаас сэргийлэх хууль зүйн баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох
- Хэлэлцэгч улсууд хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзэж дээрх нөхцөлөөр хүүхэд үрчлэхийг зөвшөөрөх нөхцөлийг хангахад чиглэгдэх юм.

Энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрхийг хангах тэдний эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хамгаалах үүднээс бүхий л үйл явц хуулиар зайлшгүй зохицуулагдах ёстой болохыг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан явдал юм. Иймд үрчлэлтийн процессыг бүхэлд нь хамарсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болдог. Учир нь үрчлэх, үрчлүүлэх процессыг урьдчилан тогтоож үрчлүүлэх, үрчлэгдсэн хүүхдийг үрчлэн авсан эцэг эх болон тухайн улс оронд шилжүүлэх, үрчлэлтийн дараах хяналтыг хэрэгжүүлэх процесс[36] зэрэг үе шат бүрт хууль зүйн тодорхой шаардлагуудыг хангахыг шаарддаг.

Монгол Улс Гаагийн конвенцод нэгдэн орсон учир хүүхэд үрчлэлттэй холбоотой бүхий л хууль, журмууд конвенцын заалтад нийцсэн байх зүй ёсны шаардлага тавигддаг. Гаагийн конвенцын зорилгод “Улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол, түүний үндсэн эрх, олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх” гэж заасны дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн заалтууд Гаагийн конвенцод хэрхэн нийцэж байгаа талаар судлан үзлээ.

Гэр бүлийн тухай хуулийг Гаагийн конвенцод нийцсэн эсэхэд харьцуулсан судалгаа хийсэн болно.

1. Гаагийн конвенцын зорилгод “Улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол, түүний үндсэн эрх, олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх” гэж заасны дагуу Монгол Улсын хувьд хүүхдийн дээд ашиг сонирхлын талаар зохицуулсан байдал нь Гаагийн конвенцод нийцэж байгаа эсэх талаар судлан авч үзлээ. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ”[37] гэж заасан хэдий ч “дээд ашиг сонирхол” гэсэн үг, ойлголт, зүйл заалт Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиудад огт тусгаагүй байна. Уг асуудлаар Монголд Хүүхдийн дээд ашиг сонирхлыг ХЭҮК-н 2012 оны Хүний эрхийн цуврал нийтлэлд "Хүүхдийн дээд ашиг сонирхлыг тодорхойлохын тулд хүүхэд бүрд тухайн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж буйг нарийн авч үзэх ёстой. Энэ нь бүхий л хугацаанд хүүхдэд ээлтэй үйлчилгээ, хүүхдийн асуудалд мэдрэмжтэй практикийг хүүхдийн төлөө үзүүлэх үйлчилгээндээ нэвтрүүлэх зэргийг ойлгоно. Энэ зарчмыг аливаа хуулиар өөрөөр тайлбарлах, эсвэл Хүүхдийн эрхийн тухай конвенцод дурдсан бусад эрхийг хэрэгжүүлэхэд саад болохоор ашиглах ёсгүй” гэж тус тус тайлбарласан байна. Одоо дагаж мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулиар “хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлэх” гэж хэт ерөнхий байдлаар тусгасан нь Гаагийн конвенцод тусгагдсан “үрчлэлтийг хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэх” гэсэн нэр томьёотой агуулгын хувьд нэлээдгүй өөр

[36] Хүүхдийг хамгаалах болон улсын хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц, 1993 https://legalinfo.mn/mn/detail/1273

[37] “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 1999 №12 Гэр бүлийн тухай хууль

байна. Өөрөөр хэлбэл Гаагийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хуульдаа энэхүү ойлголтыг тусгах шаардлагатай байна.

2. Гаагийн конвенцын 4 дүгээр зүйлийн С хэсэгт: "Хүүхэд үрчлэлтэд шаардагдах хувь этгээд, албан газар, эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үр дагаврын тухай, түүнчлэн хүүхэд болон түүний төрсөн гэр бүлийн хоорондын эрх зүйн харилцаа дуусгавар болох эсэх талаар мэдээлэл авах эрхтэй[38]" гэж зохицуулсан бол Гэр бүлийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дах хэсэгт "Үрчлэгдсэн хүүхэд нь үрчлүүлсэн эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхээ алдана[39]" гэж зохицуулсан нь агуулгын хувьд нийцээгүй болно. Төрсөн гэр бүлийн хоорондын эрх зүйн харилцаа дуусгавар болох эсэх талаар мэдээлэл авах асуудлыг зохицуулсан зохицуулалт үгүй хэдий ч хуулийн зохицуулалтыг нөхөн зохицуулахын тулд гаргасан Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат Хүүхдийг үрчлүүлэх журмын 12 дугаар зүйлд дараах байдлаар нарийвчилсан зохицуулалтууд орсон байна. Үүнд:
    - Бүтэн өнчин, эцэг, эх нь тодорхойгүй хүүхэд үрчлэх бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эсвэл асрамжийн газрын зөвшөөрөл;
    - Хагас өнчин хүүхэд үрчлэх бол эцэг, эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;
    - Хүүхдийн эцэг эх сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, эсхүл эцэг эх байх эрхээ хасуулсан бол энэ тухай шүүхийн шийдвэр болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;
    - Эцэг эх нь ахуй амьдралын гачигдлаас шалтгаалж хүүхдээ хэвийн өсгөх боломжгүй бол энэ тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, эцэг эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл[40] зэрэг нь төрсөн гэр бүлийн хоорондын эрх зүйн харилцаа дуусгавар болох эсэх талаар мэдээллийг агуулсан зохицуулалт мөн болно. Дээрх зохицуулалтын хувьд Монгол Улсыг Гаагийн Конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж дүгнэж болохоор байна.
3. Гаагийн конвенцын 4 дүгээр зүйлийн D хэсэгт хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан доорх зүйлийг хангасан байна гэж заасан. Үүнд: "Хүүхдэд зөвлөгөө өгсөн болон үрчлэх талаар түүнд зохих мэдээлэл өгсөн бөгөөд хэрэв шаардлагатай бол үрчлэн авах тухай түүнээс зөвшөөрөл авах[41]" гэж заасан бол Монгол Улсын хувьд хүүхдээс саналыг нь авах тохиолдолд үрчлэгдэх хүүхдэд зөвлөгөө өгөх асуудлыг орхигдуулсан болно. Тухайлбал: Гэр бүлийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т "Долоо нас хүрсэн хүүхдээс өөрийнх нь зөвшөөрлийг авна[42]" гэж заасны дагуу хүүхдээс үрчлэгдэх эсэх талаар зөвхөн саналыг авсан болж, саналыг нь харгалзан үзэж байгаа нь үрчлэлтийн талаарх зохих мэдээлэл, суурь ойлголт зөвлөгөө өгсөн

[38] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 91 дахь тал

[39] "Төрийн мэдээлэл" сэтгүүл 1999 №12 Гэр бүлийн тухай хууль

[40] "Төрийн мэдээлэл" сэтгүүл 1999 №12 Гэр бүлийн тухай хууль

[41] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 91 дахь тал

[42] "Төрийн мэдээлэл" сэтгүүл. 1999 №12 Гэр бүлийн тухай хууль

байх өмнөх үүргийг орхигдуулсан гэж үзэж байна. Энэ нь Гаагийн конвенцын 4 дүгээр зүйлийн D.1 дэх хэсгийн агуулгад бүрэн нийцээгүй бөгөөд хүүхдийн эрх ашгийг хамгаалаагүй орхигдуулсан энэхүү зохицуулалт нь гэр бүлийн хуулиар өнөөг хүртэл хэрэгжсээр байгааг анхаарах шаардлагатай юм. Дээрх зохицуулалтын хувьд Монгол Улсыг Гаагийн Конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж дүгнэн үзэж болохоор байна.

4. Гаагийн конвенцын 5 дугаар зүйлийн В хэсэгт "Үрчлэн авах гэж буй эцэг эхэд шаардлагатай зөвлөгөө өгсөн байх"[43] гэж заасан бол Гэр бүлийн тухай хууль болон журмаар зөвлөгөө өгөх тухай огт тусгагдаагүй болно. Уг асуудлыг гадаад үрчлэлт гэлтгүй мөн дотоод үрлэлтийн зохицуулалтад ч тусгаж өгвөл ач холбогдолтой гэж миний бие үзэж байна. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, мөн итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдийг үүнд ашиглах боломжтой юм.
5. Гаагийн конвенцын 29 дүгээр зүйлд "Хүүхдийг түүний гэр бүлийн дотор үрчлүүлээгүй буюу хүүхдийн төрөлх улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу холбоо харилцаа тогтоогоогүй бол үрчлэн авагч эцэг эх болон хүүхдийн эцэг эх буюу асран хамгаалагч бусад этгээд 4 дүгээр зүйлийн (А)-аас (С) хүртэлх дэд хэсэг, мөн 5 дугаар зүйлийн (А) дэд хэсэгт заасан шаардлага хангагдах хүртэл харилцаатай байх ёсгүй" гэж заасан. Уг конвенцын 4 дүгээр зүйлд "Конвенцын хамрах хүрээний дагуу хүүхдийг үрчлэхэд төрөлх улсын эрх бүхий байгууллага нь (А) "хүүхдийг үрчлүүлж болохыг тогтоох ёстой"[44] гэж заажээ. Уг заалтыг хэрэглэх дараах урьдчилсан нөхцөлүүдтэй болно. Үүнд:
    - Хүн худалдаалах болон бусад төрлийн үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үрчлэлтийн талуудын хооронд холбоо тогтоохыг хориглосон нь хүүхэд бол бараа биш болно гэсэн үзэл баримтлалтай холбоотой.
    - Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, түүний үндсэн эрхийг хүндэтгэх шаардлагатай.
    - Хүүхэд үрчлэлтийн зөвшөөрлийг зүй бусаар төлөх, нөхөн олговор олгох зэрэг хууль бус практик тогтохоос урьдчилан сэргийлэх зорилготой.
    - Эрх зүйн болон нийгэм сэтгэл зүйн хувьд үрчлэгдэх боломжтойг тогтоох.
    - Хүүхдийн зөвшөөрөл байгаа эсэхийг тогтоох.
    - Эцэг, эхэд зөвлөгөө өгөх зөвшөөрлийг нь авах.
    - Төрөл төрөгсөд үрчлэгдсэн тохиолдолд холбоо барихаас зайлсхийх боломжгүйг анхаарах хэрэгтэй байна.

    Харин хүүхдийн хувьд дараах тайланг бэлдсэн байх ёстой. Үүнд:
    - Хүүхэд хамгаллын тогтолцоонд орж ирсэн цагаас нь эхлэн хүүхдийн талаарх бүхий л мэдээлэл
    - Мэдээллийг тогтмол шинэчлэх, эмх цэгцтэй байх
    - Шуурхай байх, шалтгаангүй хойшлуулахгүй байх
    - Бүртгэл гэх мэт болно.

[43] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 91 дахь тал

[44] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 91 дахь тал

Монгол улсад энэ талаарх зохицуулалт байхгүйн улмаас үрчлэгч, үрчлүүлэгчид хоорондоо сошиал орчин, танил тал, холбоо сүлбээгээрээ дажуулан холбоо тогтоож, хүүхэд үрчлэн авч байгаа нь конвенцын хүрээнд тайлбарласан урьдчилсан нөхцөлүүд огт хангагдахгүй байгааг харуулж байна.

6. Гаагийн конвенцын 5 дугаар зүйлд Конвенцын хамрах хүрээний дагуу хүүхдийг үрчлүүлэхэд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага нь (А) үрчлэн авах гэж буй эцэг эхийг үрчлэх эрхтэй буюу боломжтой гэж тогтоох ёстой. Уг зохицуулалтыг хэрэглэх урьдчилсан нөхцөл нь үрчлэгч эцэг, эхийн өргөдөл холбогдох баримтуудын хамт эрх бүхий байгууллагад хандах үүрэгтэй болно. Дараах нөхцөлийг хангасан байхыг шаардана.

   Үрчлэгч эцэг, эхэд зөвшөөрөл өгөх:

   - Шаардлага хангасан байх – эрх зүйн шаардлагууд
   - Нийцэмжтэй эсэх – нийгэм сэтгэл зүйн шаардлагууд
   - Сургалтын үнэлгээ

   Үрчлэгч эцэг, эхийг бэлтгэх:

   - Сургалт – зөвлөгөө өгөх
   - Үрчлэгч эцэг, эхэд хүүхэд өсгөх болон бусад бэрхшээлтэй асуудлыг даван туулахад туслах

   Үрчлэгч эцэг, эхийн талаарх тайланг бэлдэх[45]

   Эцэст нь хүүхэд болон эцэг эхийн талаарх тайланд үндэслэж, хамгийн сайн нөхцөлтэй эцэг эхийн тайлан дундаас сонголт хийж, хүүхдийн тайланг тохируулж, тохирлын шийдэл гаргана. Эндээс харахад маш олон нөхцөл шаардлагыг хангасан ёстой байх нь.

   Гэтэл дээрх бүх үйл явцыг алгасаж сошиал орчин болон төрөх эмнэлэг, хорооны нийгмийн ажилтнуудаас мэдээлэл авч, хүүхэд үрчилж авахдаа тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, төрөхөөс нь өмнөх амьдрах зардал болон эрүүл мэндийн хяналт шинжилгээ гэх мэт хүүхэд эрүүл байлгахтай холбоотой бүхий л зардлыг хариуцахаар гэрээ байгуулсан тохиолдлууд байгаа нь хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн хууль бус үйлдэл болно. Уг асуудлыг хуульд тусгаж өгөөгүйн улмаас хууль бус гэдгийг мэдэхгүй байгаа бөгөөд хүүхэд үрчлэлтийн нэгдсэн систем, үрчлэлтийн өмнөх зөвлөгөө мэдээлэл өгөх үе шат байхгүйтэй холбоотой болно. Үрчлүүлэгчдийн хувьд эдийн засаг, мөнгөний сонирхолтойгоор хүүхэд үрчлүүлж байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил, хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр мөн болно.

7. Гаагийн конвенцын 9 дүгээр зүйлийн С хэсэгт “Өөрийн улсад үрчлэлттэй холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх болон үрчилж авсны дараах үйлчилгээг өргөжүүлнэ”[46] гэж заасан хэдий ч Гэр бүлийн тухай хууль болон хүүхэд үрчлүүлэх журамд зөвлөгөө өгөх төвүүд эсхүл мэргэжилтнүүд мөн үрчлэлтийн дараах үйлчилгээний асуудал огт зохицуулалтгүй байгаа нь конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй 20 гаран жилийн хугацаа өнгөрснийг илтгэж байна. Цаашлаад ХНХЯ-ны үрчлэлтийн зөвлөл гэх байгууллага эсхүл ГИХАЭА дарга, нарийн бичиг гэсэн

[45] HCCH MEMBERS https://www.hcch.net/en/states/hcch-members

[46] “Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл”, УБ, 2020, 92 дахь тал

хоёр байгууллагын эрх, үүрэг зохицуулалтыг эргэн харж, зохих өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна. Энэ нь зөвхөн гадаад үрчлэлт гэлтгүй дотоод үрчлэлтийн асуудалд зөвлөгөө туслалцаа үзүүлэх, сургалтын байгууллага бий болгох эсхүл итгэмжлэгдсэн байгууллага нь уг асуудлыг шийддэг байхаар зохицуулалт оруулж өгвөл ач холбогдолтой нь зэрэгцээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх үр дүнд нь үрчлэгдэх хүүхдийн эрх ашиг сонирхлыг бүрэн хамгаалж чадах онцлог зохицуулалттай болно.

8. Гаагийн конвенцын 9 дүгээр зүйлийн Е-д “Бусад эрх бүхий төв байгууллагууд, төрийн байгууллагуудаас тодорхой нэг үрчлэлттэй холбоотой асуудлаар мэдээлэл авахаар үндэслэлтэй хүсэлт гаргавал өөрийн улсын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд хариулт өгөх итгэл хүлээлгэсэн үүрэг, даалгаврыг зохистой гүйцэтгэх чадвар бүхий байгууллагад итгэмжлэл олгон ажиллуулна” гэж заасан. Холбогдох хууль болон журмаар гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхэд итгэл хүлээлгэсэн үүрэг, даалгаврыг зохистой гүйцэтгэх чадвар бүхий байгууллагад итгэмжлэл олгохтой холбоотой зохицуулалт байхгүй байна.
9. Гаагийн конвенцын 11 дүгээр зүйлийн В-д “Улс хооронд хүүхэд үрчлүүлэх ажлын туршлагатай, ёс суртахуун болон сургалтын шалгуурыг хангасан хүмүүсээр удирдуулан ажиллуулах[47] гэсэн 3 шалгуур үзүүлэлт тогтоосон хэдий ч Гэр бүлийн тухай хууль болон журмаар уг асуудлыг зохицуулж өгөөгүй байна.
10. Гаагийн конвенцын 13 дугаар зүйлд “Хэлэлцэн тохирогч улс эрх бүхий төв байгууллагуудыг томилсон тухай, түүнчлэн тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ болон итгэмжлэгдсэн байгууллагын нэр, хаягийг олон улсын хувийн эрх зүйн асуудлаар байгуулагдсан Гаагийн бага хурлын байнгын товчоонд мэдэгдэнэ” гэж зохицуулсан бол Гэр бүлийн тухай хууль болон журмаар итгэмжлэгдсэн байгууллагын талаар тусгаж өгөөгүй тул холбогдох бусад зохицуулалт байхгүй байна.
11. Гаагийн конвенцын 16 дугаар зүйлд “Хэрэв хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллага уг хүүхдийг үрчлэх бүрэн боломжтой гэж үзвэл дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд: (а) Хүүхдийн хувийн шинж, үрчлүүлэх боломж, намтар, нийгмийн байдал, гэр бүлийн түүх, өөрийн буюу гэр бүлийн эрүүл мэнд, өвчний түүх болон хүүхдийн онцгой хэрэгцээний талаарх мэдээллийг агуулсан тайлан бэлтгэнэ” гэж заасан. Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн талаарх дэлгэрэнгүй тайлан бэлтгэх талаар зохицуулалт байхгүй болно. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат Хүүхдийг үрчлүүлэх журмын 12 дугаар зүйлийн ж-д “Хүүхдийн эрүүл мэндийн талаарх эмнэлгийн байгууллагын дүгнэлт хавсаргана” [48] гэж зохицуулсан. ХНХЯ-ын сайдын тушаалаар батлагдсан Үрчлэлтийн зөвлөл хүүхдийн талаарх мэдээллийг бэлтгэн хүргэдэг ч холбогдох журамд тайлангийн бүтцийн талаар заасан зохицуулалтгүй болно.
12. Гаагийн конвенцын 20 дугаар зүйлд “Хэрэв туршилтын хугацаа шаардлагатай бол эрх бүхий төв байгууллагууд үрчлэлтийн явцыг эцэслэн дуусгахаар авсан арга

[47] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 92 дахь тал

[48] Гадаадын иргэнд монгол улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх журам

хэмжээ, шилжүүлэн суурьшуулах явцын талаар бие биедээ мэдээлнэ”[49] гэж заасан бол Гэр бүлийн тухай хууль болон Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журамд хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой туршилтын хугацааг огт тогтоогоогүй байна. Гэхдээ туршилтын хугацааны хувьд заавал байх ёстой зохицуулалт биш учир олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

13. Гаагийн конвенцын 21 дугаар зүйлийн 1-д “Хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлсний дараа түүнийг үрчлэн авах эцэг эхийн хамт цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэдгийг эрх бүхий төв байгууллагад мэдэгдвэл тухайн байгууллага хүүхдийг хамгаалах дараах арга хэмжээг авна”. Үүнд:
    - Үрчлэн авах хүсэлт гаргасан эцэг эхээс хүүхдийг буцаан авч, түр асрамжид өгөх
    - Хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагатай зөвшилцөн, хүүхдийг үрчлүүлэх үүднээс цаг алдалгүй шинээр шилжүүлэн суурьшуулах бөгөөд хэрэв энэ арга хэмжээ тохиромжгүй бол урт хугацааны асрамжид өгнө. Хүүхдийн төрсөн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах шинэ эцэг эхийн талаар бүрэн мэдээлэл авах хүртэл хүүхдийг үрчлүүлэхгүй.
    - Хүүхдийн ашиг сонирхол шаардвал эцэст нь түүнийг буцаах арга хэмжээ авна[50] гэж заасан бол Монгол Улсын гэр бүлийн тухай хуулиар үрчлэгдсэн хүүхдэд тавих дотоод болон гадаад хяналттай холбоотой зохицуулалт огт байхгүй. Энэ нь гадаад улс оронд үрчлэгдэж байгаа хүүхэд болон үрчлэгч эцэг, эхэд ямар нэгэн асуудал тулгарч хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирсон тохиолдолд /үрчлэн авагч эцэг эх нь нас барсан, сураггүй алга болсон, эрүүгийн хэрэгт ял шийтгүүлж хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй болсон, хүүхдийг хүчирхийлсэн, гэмт хэрэг эрх зүйн зөрчилд татан оролцуулсан зэрэг/ хүүхдийг эх оронд нь буцаах, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах асуудлыг зохицуулж өгөөгүй байгаа нь гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг сонирхлыг зөнд орхиж байгаагийн илрэл мөн гэж үзэж байна.

14. Гаагийн конвенцын 35 дугаар зүйлд “Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд үрчлэлтийг шуурхай явуулна[51]” гэж заасан хэдий ч Гэр бүлийн тухай хууль болон журамд гадаадын иргэнээс хүүхэд үрчлэх хүсэлт гаргаснаас хойш яг ямар хугацаанд хүүхэд үрчлэх талаарх зохицуулалт үгүй болно. Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхдээ: ХНХЯ-ны дэргэдэх Үрчлэлтийн зөвлөлөөр хэлэлцэж, гаргасан дүгнэлтийн дагуу иргэний харьяалал шилжих хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх Зөвлөл шийдвэр гаргадаг бөгөөд энэ нь хүүхэд үрчлэлтийн асуудлаар ажиллах бүтэц, тогтолцооны хувьд олон шат дамжлага дамжиж, маш их цаг хугацаа авдаг байна. Тухайлбал: Олон улсын сайтууд болон Монгол Улсаас хийсэн албан ёсны судалгаагаар гадаадын иргэд Монгол Улсаас хүүхэд үрчлэх

[49] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 94 дахь тал

[50] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 94-95 дахь тал

[51] Монгол улсын нэгдэн орсон конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний эмхэтгэл. УБ, 2020 97 дахь тал

хүсэлтээ албан ёсоор гаргаснаас хойш 2-3 жил болж сунжирч хугацаа алддаг[52] талаар дурдсанаас үзвэл үрчлэх үйл явцыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй, тодорхой хугацаа заагаагүйгээс шалтгаалан иргэдэд маш их чирэгдэл хохирол учруулдаг нь харагдаж байна. Хүсэлт тавьсан иргэний хувьд тэвчээрийг шаардсан, хөрөнгө, цагийг нь үнэгүйдүүлсэн, сэтгэл зүйн хувьд эрсдэлтэй алхамд хөтөлж байгаа шалтгаан нь үрчлэлтийн үе шат бүрд тодорхой хугацаа зааж өгөөгүйтэй холбоотой болно. Мөн уг асуудлыг хариуцсан мэргэжилтэн болон үрчлэлтийн зөвлөлийн хариуцлагагүй байдлаас болж Монгол Улсын нэр хүнд олон улсын давцанд унасаар байгаа нь гадаад үрчлэлт багасаж байгаа нэг томоохон шалтгаан болно. Иймд үрчлэлтийн үе шат бүрд тодорхой хугацаа зааж хуульчлах шаардлагатай байна. Гэр бүлийн хуульд үе шат бүрд тохирсон зохицуулалт хийснээр үрчлэлт шуурхай явагдах, Гаагийн конвенцтой гэр бүлийн хууль нийцэх, улмаар үрчлэгдэх хүүхдийн эрх, ашиг сонирхол хангагдаж, олон улсын давцанд Монгол Улсын нэр хүнд ахин сэргэх зэрэг чухал ач холбогдолтой болно.

Дээрхээс дүгнэн үзвэл, Монгол улсын хүүхэд үрчлэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудтай олон талаар зөрчилдөж байгаагаас шалтгаалан Гэр бүлийн тухай хууль болон Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журмыг өөрчлөх, шинэчлэн найруулах шаардлага үүссэнийг харуулж байна.

Иргэн болон гэр бүлийн хэргийн талаар хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх гэрээ

Дэлхийн улс гүрнүүдийн хамтын ажиллагаа улам бэхжиж байгаа өнөө үед олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг судлах, түүний дагуу дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийцүүлэн хэрэгжүүлэх нь Монгол улсын нийгэм эдийн засаг, эрх зүйт засаглалын хөгжилд чухал нөлөөтэй юм. Иймд судалгааны ажлын сэдвийн хүрээнд Монгол Улсаас бусад улс орнуудтай байгуулсан “Иргэний ба гэр бүлийн хэргийн талаар хамтран ажиллах харилцан туслалцаа үзүүлэх гэрээ” -ний зохицуулалтыг судлан үзсэн болно. Монгол Улс 1968-2024 оны хооронд нийт 23 улстай 36 хоёр талт олон улсын гэрээ байгуулсан[53] байна. Үүнээс 16 улс нь иргэний хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээтэй байна. Дээрх 16 улсаас 7 улстай байгуулсан гэрээнд хүүхэд үрчлэлтийн асуудлаар холбогдох зохицуулалт оруулсан байдаг. Үүнд:

1. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс
2. Бүгд Найрамдах Куба Улс
3. Бүгд Найрамдах Польш Улс
4. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
5. Бүгд Найрамдах Унгар ард Улс
6. Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс
7. Бүгд Найрамдах Болгар Ард Улс

[52] Хүүхэд хамгааллын тайлан, 2017 УБ, 44 дэх тал
[53] Мөн тэнд

Тодруулбал: Болгар улстай байгуулсан гэрээний “үрчлэлтийн зохицуулалт нь хүүхэд үрчлэхэд үрчлэгчийн харьяалал, талуудын баримтлах хууль тогтоомж” зэрэг асуудлыг авч үзсэн бол Югослав улстай байгуулсан гэрээний хүрээнд “хүүхэд үрчлэхэд үрчлэгч талуудын харьяаллын асуудлын хүрээ”-нд л баримтлах зохицуулалтыг тусгасан байна. Харин Солонгос улстай байгуулсан гэрээний хувьд үрчлэлтийн харьяалал болон зөвшөөрөл авах шаардлагыг тусгасан бол Куба улстай байгуулсан гэрээний хүрээнд хүүхэд үрчлэх, түүнийг хүчингүй болгохдоо баримтлах хууль тогтоомжийг зааж өгсөн байна. Дээрх бусад улсуудтай байгуулсан гэрээнээс үзэхэд үрчлэлт хийлгэх болон хүчингүй болгоход баримтлах хууль тогтоомжийн хүрээнд үрчлэлтийн асуудлыг хэт ерөнхий байдлаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл үрчлэлтийн явцад болон үрчлэгдсэний дараа хүүхдийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хүүхдийг хэрхэн хамгаалахтай холбогдсон зохицуулалт байхгүй ба үрчлэн авсан тал хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлэх, хүүхдийг буцаах талаар зааж өгөөгүй нь учир дутагдалтай юм. Түүнчлэн нэгдэн нэгдэн орсон гэрээнээс харахад ихэнх нь хуучин социалист орнуудтай байгуулсан гэрээ байх бөгөөд Монгол Улсын иргэдийн сурч, ажиллаж, амьдарч, гэр бүл болж буй голлох улс орнуудтай хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах нь зүйтэй байна. Мөн хүүхэд үрчлэлтийг хамгийн ихээр хийдэг АНУ, Герман, Франц, Итали зэрэг улсуудтай шинээр гэрээ байгуулах, мөн зарим оронтой хийсэн гэрээгээ шинэчлэх шаардлагатай байна. Учир нь улс хоорондын харилцаа нь гэрээ байгуулах төдийхнөөр бус гэрээний дагуух хамтын ажиллагаа, үр дүнг илтгэх тайлан мэдээг тогтмол солилцох, хүүхэд үрчлэлтийн харилцаанд тулгамдаж буй асуудал болон эрх зүйн хүрээнд шинэчлэлт, өөрчлөлтийг хийх шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна. Монгол Улсын гадаад улсуудтай байгуулсан Иргэний болон Гэр бүлийн хэргийн талаар хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд дараах асуудлуудыг тусгах зайлшгүй шаардлагатай:[54] байна. Тухайлбал, гэрээт улсуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, үрчлэлтийн дараах хяналтын тогтолцоог бий болгох, зуучлагч байгууллагуудын оролцоо, ажиллагааг тайлан мэдээнд тусгах, ил тод байлгах, итгэмжлэгдсэн байгууллагыг улс хоорондын ажиллуулах, үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авах, цаашлаад эх оронд нь буцаах хүртэл арга хэмжээг зохион байгуулах талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгах нь зүйтэй юм. Энэ нь улс хоорондын байгуулагдсан Иргэний болон Гэр бүлийн хэргийн талаарх хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд тусгаснаар улс хоорондын үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт боловсронгуй болгох, үрчлэгдсэн хүүхдүүдийн эрх, ашиг сонирхол хангагдахад чухал ач холбогдолтой.

[54] Монгол Улсын олон нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц https://mfa.gov.mn/documentation/55669

Дөрөв. Гадаадын зарим орны хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Судалгаанаас үзэхэд гадаадад хамгийн олон хүүхэд үрчлүүлсэн улсуудын жагсаалтыг Хятад, ОХУ, Этиоп зэрэг улс орнууд тэргүүлж байна. Харин Монгол Улсын хувьд Америк, Герман, Франц улс руу хамгийн их үрчлэлт хийсэн байна. Иймд судалгааны ажлын сэдвийн хүрээнд Хятад, Франц, Герман, Америк зэрэг улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг дараах эрх зүйн чиг үүргээр харьцуулан судалсан. Үүнд:

10. Үрчлэлтийн эх сурвалж
11. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг
12. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур
13. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага
14. Үрчлэлтийн дараах хяналт
15. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт
16. Байршуулахын үйл ажиллагааны зохицуулалт
17. Үрчлэлтийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
18. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

1. Хятад улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт

I. Үрчлэлтийн эх сурвалж

Хятад улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1992 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр, нэгдэн орж 2005 оны 09 дүгээр сарын 16-нд соёрхон батлсан. Гаагийн конвенцод 2005 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр нэгдэн орж[55], 2006 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс соёрхон батлсан. Хятад улсын хувьд хүүхэд үрчлэлтийн харилцаанд дараах хууль, журмыг баримталдаг байна.[56]

- 1992 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр “Хүүхэд үрчлэх тухай” хууль баталж 1998 онд шинэчлэн найруулсан, 2007, 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон.
- 1993 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан ‘Гадаадын иргэн үрчилж авсан хүүхдээ БНХАУ-д бүртгүүлэх журам” 2007, 2011, 2015 шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой болгосон.
- 1999 онд БНХАУ-д Хүүхэд үрчлэхийг бүртгэх арга, хэмжээ
- 2001 онд Хүн ам гэр бүл төлөвлөлтийн тухай хууль
- 2011 онд Үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрчимтэй хамгаалах арга хэмжээгээр баталгаажуулах тухай хууль
- 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан (өөрчлөн баталсан) “Үрчлэгч гадаадын иргэн, үрчлүүлэгчид тавигдах шаардлага”
- 2017 оны 7 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Гадаадын иргэн Хятад улсаас хүүхэд үрчлэх тухай хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг”
- 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Хятад улсад улс хооронд үрчлэх эрх бүхий үрчлэлтийн агентлагт тавигдах шаардлага**”**

[55] United Nations, Convention on the Rights of the Child, New York, 20 November 1989

[56] 儿童保护政策法规查询库

II. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг[57]

1996 оны 6-р сарын 24-нд БНХАУ-ын Иргэний хэргийн яамнаас Хятад үрчлэлтийн асуудал эрхэлсэн төв (China Center of Adoption Affairs) нэртэйгээр байгуулагдсан энэхүү агентлаг нь дараах 8 хэлтсээс бүрдэж байв. Үүнд:

- Захиргааны алба;
- Хүүхэд үрчилж авах эрхийг шалгах хэлтэс;
- Хүүхдийг улс хоорондын байршуулах хэлтэс;
- Дотоодын үрчлэлтийн хэлтэс;
- Хүүхэд хүмүүжүүлэх хэлтэс;
- Архивын удирдлагын хэлтэс;
- Мэдээлэл, технологийн хэлтэс;
- Санхүүгийн хэлтэс;
- Ерөнхий хэрэг эрхлэх газар.

2005 оноос эхлэн асран хүмүүжүүлэх, дотоодын үрчлэлт болон улс хоорондын үрчлэлтийн практикт хяналт тавих үүрэгтэй болсон. 2011 онд CCAA нь хүүхдийн халамжийн хөгжлийн хэрэгцээг хангахын тулд CCCWA – Хятадын хүүхдийн халамж үрчлэлтийн төв (china center for children's welfare and adoption) болж өөрчлөн байгуулагдаж, холбогдох чиг үүргийг нэмэгдүүлсэн. Өөрийн цахим хуудаснаа тайлбарласнаар CCCWA нь гадаадын хүүхэд үрчлэн авах, хүүхдийн хамгаалалтай холбоотой үүрэг даалгаврыг хариуцах нийт 12 хэлтэстэй чиг үүргийн гол байгууллага юм.[58] Улс хоорондын хүүхэд үрчлэлтийг хариуцдаг төв байгууллагын хувьд өөрт бүртгэлтэй үрчлэлтийн агентлагаар дамжуулан шаардлагатай бүх өргөдлийг хянан шийдвэрлэдэг. CCCWA 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Гаагийн конвенцод нийцүүлэн улс хоорондүрчлэлтийн зохицуулалтаа шинэчлэн баталж “Бүхнийг хүүхдийн сайн сайхны төлөө" (everything for the children) байх зарчмын хүрээнд дараах чиг үүрэгтэй болсон:

- Улс хоорондын үрчлэлтэд хяналт тавих, зохицуулах, Хятад улсад Гаагийн конвенцыг хэрэгжилтийг хангах;
- Улс хоорондын үрчлэлтээр холбогдох хүүхдийн талаар мэдээллээр хангах:
- Улс хооронд үрчлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад эрх олгох;
- “Баталгаа гаргах албан бичиг” болон “Хятад улсаас хүүхэд үрчилж авах тухай гэрчилгээ” олгох:
- CCCWA үрчлэлтийн агентлагуудын бүртгэлийг хөтөлдөг бөгөөд зөвхөн эдгээр агентлагуудын аль нэгээр дамжуулан үрчлүүлэх өргөдлийг хүлээн авна[59].
- Хятад улсын иргэний асуудал хариуцсан яам улс хоорондын үрчлэлтийн асуудлаар хүүхэд үрчилж авсны гэрчилгээ олгох үүрэгтэй байна. (Ministry of Civil Affairs)

Хятад улсад улс хооронд хүүхэд үрчлэх үйл ажиллагаа явуулах эрх бүхий үрчлэлтийн агентлагт дараах шаардлага тавигддаг байна. Үүнд: Хятад улсад улс хооронд үрчлэх эрх бүхий үрчлэлтийн агентлагт тавигдах шаардлагын 5 дах хэсэгт “Хэрэв хүүхдийн нөхцөл байдал өөрчлөгдсөн болон хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөх

[57] 中国儿童福利和收养中心 机构设置 http://www.cccwa.cn/n983/n991/index.html

[58] Мөн тэнд

[59] Glover, R. ‘China’ in Colton, M. and Williams, M. (eds), Global Perspectives on Foster Family Care, Russell House Publishing, Lyme Regis, 2006

тохиолдолд зуучлагч байгууллагаас хүүхдийг хамгаалах болон үрчлэх асуудал эрхлэх төв байгууллагад нэн даруй мэдэгдэх бөгөөд үрчлүүлэгч хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах идэвхтэй арга хэмжээг авна" гэж заасан. Хятад улсад олон жилийн турш гадаадын хэд хэдэн төрийн бус байгууллагууд хүүхэд асрах чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд зарим нь үрчлэлтийн болон асран хүмүүжлийн талаар товч танилцуулгатай байдаг. Жишээлбэл, Их Британид төвтэй Хүүхдийн асрамжийн газар нь үндэсний хэмжээнд асрамжийн хөтөлбөр боловсруулж, Хятадын агентлагуудтай хамтран ажилладаг. Тэнгэрийн хагас, Хил хязгааргүй хайр, Манай Хятад охидын сан гэх мэт олон улсын буяны байгууллагууд CCCWA-тай нягт хамтран ажиллаж, стандартыг цаашид улам бүр хөгжүүлдэг байна. CCCWA нь үрчлэлтийн агентлагуудын бүртгэлийг хөтөлдөг бөгөөд зөвхөн эдгээр агентлагуудын аль нэгээр дамжуулан үрчлүүлэх өргөдлийг хүлээн авна. Ашгийн төлөө ажилладаг Хятад улсын бүртгэлтэй агентлаг байхгүй ч АНУ эсвэл Европт төвтэй, Хятадаас үрчлүүлэх ажлыг зохион байгуулдаг олон улсын зарим агентлагууд ашгийн төлөө ажилладаг байна.

III. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур

БНХАУ-ын Хүүхэд үрчлэн авах тухай хуульд заасанчлан, үрчилж авах эцэг эх нь хэд хэдэн төрлийн хатуу шаардлагыг хангасан байх ёстой. [60] Үүнд:

- Насны хувьд тавигдах шалгуур:
    - Гэрлэсэн хосууд 30-50 настай байх ёстой
    - 6-18 сартай хүүхдэд 30-40;
    - 12-36 сартай хүүхдэд 40-45;
    - 36 сартай хүүхдэд 45-50;
    - эсвэл тусгай хэрэгцээт хүүхэд авах хүсэлт гаргасан бол 30-55 насныхан.
- Гэрлэгчдэд тавигдах шалгуур:
    - Хосууд гетеросексуал, гэрлэсэн байх ёстой
    - анхны гэрлэлтийн хувьд хосууд 2-оос дээш жил гэрлэсэн байх ёстой;
    - эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь 1-2 удаа гэрлэлтээ цуцлуулсан бол одоогийн гэрлэлт дор хаяж 5 жил байх ёстой;
    - эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь 3 ба түүнээс дээш удаа гэрлэлтээ цуцлуулсан бол энэ эрхгүй.
- Эрүүл мэндэд тавигдах шалгуур:
  Үрчлэгч нь бие болон сэтгэхүйн хувьд эрүүл, хүүхдийг өсгөн хүмүүжүүлж боловсрол олгох чадвартай этгээд байх бөгөөд дараах өвчинтэй бол үрчлүүлэхийг зөвшөөрөхгүй:
    - Оюуны хомсдол
    - ДОХ болон бусад төрлийн халдварт өвчин
    - Шизофрени
    - Сэтгэл гутрал, сэтгэл түгшүүр, галзуу солио зэрэг эмгэгтэй байж болохгүй бөгөөд хэрэв бага зэргийн шинж тэмдэгтэй боловч сэтгэлзүйн эмчээр тухайн эмгэг нь хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хэвийн ажиллаж, амьдрахад ямар нэг

[60] [60] Requirements for foreign adopters and adoptees http://regional.chinadaily.com.cn/huzhou/2020-02/03/c_405080.htm

саадгүй, эмчилгээгээр хянагдах боломжтой гэдэг нь тогтоогдсон тохиолдолд зөвшөөрнө.
    - Хоёр нүд нь сохор;
    - Нүүрний хурц гажигтай;
    - Хоёр чихний сонсголын болон хэлний чадваргүй бол үрчлэхийг зөвшөөрөхгүй бөгөөд хэрэв үрчилж авах хүүхэд нь адил шинж тэмдэгтэй эсхүл гэрлэгчдийн аль нэг нь эрүүл бол зөвшөөрнө.
    - Гар хөлийн хөдөлгөөнгүй эсхүл хөдөлгөөний сааталтай, нуруу нугасны гэмтэлтэй, гар хөл нь тахир дутуу, саажилттай болон гажигтай:
    - Хүүхдийг асрамжлахад сөргөөр нөлөөлөхүйц арьсны өвчин, нефроз, унадаг өвчин, олон тооны эвэршил (multiple sclerosis) гэх мэт урт хугацаанд эмчлэгдэх өвчинтэй. Хэрэв үрчлэгч эцэг эхийн аль нэг нь өвчинтэй бөгөөд хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, хэвийн ажиллаж, амьдрахад ямар нэг саад болохгүй, эмчилгээний үр дүнд хянагдах боломжтой гэдэг нь эмчийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрнө.
    - Арьс, бамбай булчирхай, хөх, төмсгийн хорт хавдартай бөгөөд үүнийг гурваас илүү жил эмчлүүлсэн, бусад төрлийн хорт хавдартай бол таваас илүү жил эмчлүүлсэн.
    - Арван жилийн дотор амин чухал эд эрхтнийг шилжүүлэн суулгуулсан бөгөөд хэрэв гэрлэгчдийн аль нэг нь ийнхүү арван жилийн дотор эд эрхтэн шилжүүлэн суулгуулсан боловч буцаад хэвийн амьдралдаа орсон бол зөвшөөрнө.
    - 39-өөс дээш биеийн жингийн индекстэй
    - Хэт намхан нуруутай эсхүл одой бол зөвшөөрөхгүй бөгөөд хэрэв үрчилж авах хүүхэд нь адил шинж тэмдэгтэй бол зөвшөөрнө.
- Гэр бүлд байх хүүхдэд тавигдах шалгуур:
    - Үрчлэгч эцэг эх нь хүүхдийг (үрчлүүлэх хүүхдийг оролцуулан) асрамжлах хангалттай цаг хугацаа, боломжтой байх. Гэрлэгчдийн хувьд бага насны таваас дээш хүүхэдгүй байх.
    - Гэр бүлийн хамгийн бага хүүхэд нь гурван нас хүрсэн байх;
- Орлогод тавигдах шалгуур:
    - Гэрлэгчдийн аль нэг нь тогтмол ажил, орлоготой.
    - Гэр бүлийн нэг хүнд ноогдох жилийн дундаж орлого (үрчлүүлэгч хүүхдийг оролцуулан) 10,000 USD байх: (Гэр бүлийн дундаж орлогод нийгмийн халамжийн тэтгэмжийн мөнгө орохгүй)
    - Гэрлэгчдийн гэр бүлийн цэвэр хөрөнгө 80,000 USD хүрсэн байх;
    - Үрчилж авах эцэг эх нь жилийн доод тал нь 30,000 долларын орлоготой байх ёстой.
- Боловсролд тавигдах шалгуур:

Үрчлэгч эцэг эх нь ахлах сургууль болон түүнээс дээш боловсролыг дүүргэсэн, эсхүл гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролтой байх шаардлагатай.

- Зан байдлын шалгуур:

Үрчлэгч нь урьд өмнө нь ял шийтгүүлж байгаагүй, хууль болон дүрэм журмыг дагаж мөрдөх ёс зүйн зөв төлөвшил, зан байдалтай байх ёстой бөгөөд дараах нөхцөлд зөвшөөрөхгүй.Үүнд:

- Одоогоор батлан даалтад байгаа эсвэл туршилтын журмаар байгаа
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүчин, хүүхдээ хаяж, хүчирхийлж байсан; (энэ хэргээр ял шийтгүүлж байгаагүйг үл харгалзан)
- Хар тамхи, морфин, марихуан, кокайн, герион зэрэг бусад хар тамхины төрлийн зүйлс хэрэглэдэг, хэрэглэж байсан;
- Архи хэтрүүлэн хэрэглэдэг, арваас доош жилийн хугацаанд архинаас гарсан;

Мөн хүсэлт гаргагч нь гурваас дээшгүй удаа хохирлын хэмжээ бага хэрэг үйлдэж байсан, таваас дээшгүй удаа бага хэмжээний хохиролтой зам тээврийн зөрчил гаргаж байсан бол хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрнө.

- Үрчлэлтийн тоонд тавигдах шалгуур:
  - Хятад улсаас нэг удаад нэг хүүхэд үрчилж авна. Хоёрдох хүүхдийг үрчилж авах тохиолдолд хоорондох зай нь нэг жил байна.
  - Гэрлэгчдийн хувьд хэрэв үрчилж авах хүүхэд нь ихэр эсхүл олон эгч ах дүүстэй байх тохиолдолд энэ заалт хамаарахгүй. Хэрэв хоёр болон түүнээс дээш хүүхэд үрчилж авах тохиолдолд хүүхэд тус бүрд үрчлэлтийн дараах тайланг илгээх үүрэгтэй.

БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуулийн дагуу арван дөрвөн нас хүрээгүй хүүхэд үрчлэн авах эрхтэй бөгөөд гурван шаардлагын аль нэгийг нь хангасан бол хүүхэд үрчлэн авах эрхтэй.

IV. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага

БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуулийн дагуу арван дөрвөн нас хүрээгүй хүүхэд үрчлэн авах эрхтэй бөгөөд дараах гурван шаардлагын аль нэгийг нь хангасан хүүхэд авах эрхтэй байна. Үүнд:

1. Хятадын засгийн газар эцэг эх нь нас барсан эсвэл "ардын шүүхээс нас барсан гэж зарласан" хүүхэд.
2. Хятадын хуулийн дагуу үрчлүүлэх боломжтой гэж үзсэн хоёр дахь төрлийн хүүхэд бол хаягдсан эсвэл "эцэг эхийг нь [амархан] олж тогтоох боломжгүй" хүүхэд.
3. Хятадын засгийн газраас үрчлэх боломжтой гэж ангилдаг хүүхдүүдийн эцсийн ангилал нь "эцэг эх нь ер бусын хүндрэлийн улмаас тэднийг өсгөж хүмүүжүүлж чадахгүй байгаа хүүхдүүд" /хөгжлийн бэрхшээл, өвчин эмгэг, хүүхдийн биологийн эцэг эхийн амьдралыг "маш хэцүү" болгодог бусад элементүүд багтдаг байна/.

V. Үрчлэлтийн дараах хяналт

Үрчлэгч нь хүүхэд үрчилж авсны дараа үрчлэлтийн дараах хяналтын тайлан (post-placement and post adoption) явуулна. Үүнийг үрчлэлтийг албан ёсоор бүртгүүлснээс хойш 6 сар, 1 жил, 2 жил, 3 жил, 4 жил, 5 жилийн дараа гэх хугацааны давтамжтайгаар нийт 6 удаагийн тайланг явуулна. Эхний гурван тайланг тухайн үрчлэлтийн агентлагийн нийгмийн ажилтан үйлдэх бол сүүлийн гурван тайланг гэр бүлээр өөрсдөө үйлдэхийг

зөвшөөрнө.[61] CCCWA 2003 оны 2 дугаар сарын 1-ний өдөр баталсан "Хятад улсад улс хооронд хүүхэд үрчлэх талаар үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагад тавигдах шаардлага" журмын 5 дах хэсэгт үрчлэлтийн дараах тайланд тавигдах шаардлагыг тусгасан.[62] Тайлангийн загварт тусгаснаар тайлан нийт 4 хэсэгтэй байх бөгөөд дараах дарааллын дагуу үйлдэгдэх ёстой. Үүнд:

Нэгдүгээр хэсэгт: Үрчлэгч, үрчлүүлэгчийн талаар ерөнхий мэдээлэл, үрчлэлтээс 1 сарын дараах хүүхдийн орчин тойронтойгоо дасан зохицсон нөхцөл байдал,

Хоёрдугаар хэсэгт: хүүхдийн эрүүл мэнд, бие махбодын хөгжил, хүүхдийн өдөр тутам хийдэг үйл ажиллагааны хуваарь, хүүхдийн эцэг эх, гэр бүл, эгч дүүстэйгээ хэрхэн харилцдаг, хүүхдийн оюун ухаан болон хэлний хөгжил, зан ааш, боловсролын байдал, эцэг эх хүүхэдтэй хэрхэн харилцаж, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэж байгаа тухай, хүүхэд орчин тойрон, нийгэм, бусад хүмүүстэй хэрхэн харилцаж байгаа тухай, гэр бүлийн байдалд гарсан чухал өөрчлөлтүүд, нийгмийн ажилтны үрчлэгч гэр бүлийн талаарх тодорхойлолт, бусад зүйлс;

Гуравдугаар хэсэгт: Хүүхдийн гадаадын иргэний үнэмлэх болон Хятад улсаас хүүхэд үрчилж авах тухай мэдэгдлийн хуулбар, хүүхэд арван нас хүрсэн бол түүний эцэг эх, сургууль, найзууд, багш хамт олонтойгоо хэрхэн харилцаж амьдарч байгаа тухай богино хэмжээний эсээ;

Дөрөвдүгээр хэсэгт: Хүүхдийн үрчлэгч эцэг эх болон бусад гэр бүлийн гишүүдтэй харилцаж буй 8-н зураг, (A4 хэмжээтэй цаасанд 15.2cm x10.2cm хэмжээтэй 2 зураг байх бөгөөд хар цагаан зураг байж болохгүй) байх бөгөөд зураг бүрийн доор он сар өдөр, газар, хүмүүсийн тайлбар зэргийг оруулдаг байна.[63]

VI. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

Хятад улсын Хүүхэд үрчлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд: "Үрчлэгч нь хүүхдийг насанд хүрээгүй бол үрчлэлтийг хүчингүйд тооцуулж болохгүй. Хэрэв үрчлэгч нь хүүхдийг тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцоогүй бол үрчлэгч, үрчлүүлэгч нар үрчлэлтийн харилцааг дуусгавар болгохоор шүүхэд хандах эрхтэй.

Хуулийн 26 дугаар зүйлд: Үрчилсэн эцэг эх, насанд хүрсэн үрчлэгдсэн хүүхдийн хоорондын харилцаа таарамжгүй болж, хамт амьдрахаа больсон бөгөөд тэд хоорондоо үрчлэлтийг хүчингүй болгохоор тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхэд хандаж шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасан байна.

VII. Байршуулах үйл ажиллагааны зохицуулалт

Дотоодын үрчлэлтийн хувьд хүүхэд байршуулах нь зөвшилцлийн үндсэн дээр бөгөөд орон нутгийн асрамжийн газар "нэг сарын туршилтын хугацаа"-аар хийгддэг.

[61] Country information- People's Republic of China, accessed April 21, 2018 https://travel/state.gov/contenttravel/en/Intercountry-Adoption/Intercountry-Adoption-Country-/Information/China.html
[62] Provisional Regulations and Requirements by CCCWA for Foreign Adoption Organizations doing Adoption with China, Part 5, (2003) http://www.china.org.cn/english/LivinginChina/184127.htm
[63] Requirement for Post-placement reports, http://regional.chinadaily.com.cn/huzhou/2020-02/03/c_405083.htm

Үрчлэлтийн хуулийн 2-р зүйлд: "Хэрэв насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх хоёулаа иргэний бүрэн чадамжгүй хүн бол эцэг эх нь насанд хүрээгүй хүнд ноцтой хохирол учруулснаас бусад тохиолдолд хүүхдийн асран хамгаалагч түүнийг үрчлүүлэх эрхгүй." Хүүхэд хамгааллын сэрэмжлүүлэг нь хүүхдийг хүчирхийлэлд өртөх, хайхрамжгүй хандах эрсдэлд оруулах нэг талт үйл ажиллагаа явуулах эрх бүхий төрийн зохих байгууллагад олгохоор тодорхой заасан байдаг. Нийгмийн халамжийн хүрээлэнгүүд зарим хүүхдийг НХХ-ийн ажилтнуудын шууд удирдлага дор асран хүмүүжүүлэх асрамжийн газарт өгдөг жишиг тогтсон. Асран хүмүүжүүлэгч эцэг эх нь зохих шалгуурыг хангасан тохиолдолд хүрээлэнгийн зөвшөөрлөөр дараа нь өнчин, хаягдсан асрамжийн хүүхдийг үрчилж болно. Асрамжийн газрын дарга болон бусад хүмүүсээр зуучлуулж байршуулалтыг хийсний дараа мэргэжлийн дүгнэлт гаргахаас өмнө төрсөн эцэг эх (эсвэл хүүхдийн асран хамгаалагч) болон үрчилж авах хүмүүсийн хооронд шууд харилцахыг хориглосон. Энэ нь Гаагийн конвенцын 29-р зүйлийг зөрчихөд хүргэнэ. Энэ шатанд хүүхэд үрчлэн авах боломжтой эсэх, үрчилж авахаар төлөвлөж буй хүмүүс зохих, тохиромжтой эсэхийг шалгах ёстой. Улс хоорондын үрчлэлтийг байршуулах үйл явц Хятадад явагдах ёстой боловч үрчлэгдсэний дараа уг байршуулалтын хяналтыг үрчлэгдсэн улсын нутаг дэвсгэрт хийдэг. CCCWA өргөдлийг зөвшөөрч, тохирох үйл явцыг дуусгасны дараа тодорхой хүүхдэд зориулсан албан ёсны санал тавьдаг бөгөөд хэрэв зөвшөөрвөл үрчлэн авагчид хүүхдээ хүлээж авахаар Хятад руу явахад хүрдэг. Дараа нь эмнэлгийн болон цагаачлалын шаардлага хангасны дараа үрчилж авсан хүмүүс Хятадаас чөлөөтэй гарч, хүүхдээ гэртээ авч явах боломжтой. Үүний дараа CCCWA нь хүүхэд болон байршуулалт нь хангалттай хөгжиж байгааг батлахын тулд нийгмийн ажлын тайланг шаарддаг.

VIII. Үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Төрөөс үзүүлэх тусламж үйлчилгээ нь Хятад улсад байхгүй. Ялангуяа санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүйгээс гадна Хятад улс дотоодын болон улс хоорондын гуравдагч этгээдийн хүүхэд үрчлүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүгийн татвар ногдуулдаг. Үрчлэлтийн гэрээ байгуулахдаа үрчлэгчид хүүхдээ асрамжийн газарт байх хугацааны тооцоолсон асрамжийн зардалтай тэнцэх хэмжээний төлбөр төлөх ёстой. Улс хоорондын үрчлэгчид асрамжийн газарт 5000 долларын төлбөр төлдөг болно. Үрчлэгдсэний дараа холбогдох талуудад дэмжлэг үзүүлэх гэсэн бодлогыг оронд, Хятад үрчлэгчид нь хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, Хятадын соёлын онцлогийг төлөвшүүлж байгааг нотлох баримтаар гаргаж өгөх үүрэгтэй. Гэсэн хэдий ч бүх хүлээн авагч улсууд үрчилж авсан хүмүүс болон тэдний хятад хүүхдүүдийн хэрэгцээнд тусгайлан дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын хүчирхэг сүлжээтэй байдаг. Албан ёсны бодлого нь тусгай хэрэгцээт хүүхдүүдийг дотоодын болон улс хоорондын замаар үрчлэн авахыг чухалчилж байгаа учир судлаачдын хувьд "Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үрчлэн авах хүсэлтэй гэр бүлүүдэд эмнэлгийн тусламж, санхүүгийн тусламж, татварын хөнгөлөлт, урамшуулал олгох ёстой'[64] гэж үздэг байна.

[64] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021 p. 849

IX. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

Хятадад хүүхэд үрчлэлтийн дараах мэдээлэл задруулах журам, холбогдох мөрдөн шалгах, дахин нэгтгэх үйлчилгээнүүд сайн хөгжөөгүй байна. Дотоодын болон улс хоорондын үрчлэлтийн дийлэнх хувийг гэр бүлийн түүх байхгүй өнчин, хаягдсан хүүхдүүд эзэлдэг тул ийм журам, үйлчилгээ байхгүй болно. Үрчлэлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлд төрсөн эцэг, эх, үрчлэн авагчид хувийн нууц, нэрээ нууцлах эрхийг тусгайлан олгосон байдаг ч үрчлэгдсэний дараа мэдээлэл авах эрхийг тухайн хоёр талын үзэмжээр хангана. Дотоодын үрчлэгчдийн гол сэдэл нь үргүйдлийн асуудлаас үүдсэн орон зайг нөхдөг байна. Хятад улсад үргүйдэлтэй холбоотой олон жилийн соёл, нийгмийн гутаан доромжлолоос шалтгаалж уг асуудлыг зохицуулж өгөөгүй болно. Мөн үрчлэн авсан хүмүүсийн хувьд удам угсаа нь үнэнч байх ёстой гэсэн соёлын хүлээлт нь өөрсдөд нь болон гэр бүлийн гишүүдийн аль алинд нь аюул учруулахуйц мэдээлэл өгөх лавлагаа хийхээс зайлсхийдэг. Тодорхойлох мэдээлэлд хандахад болзолт болон бусад заалт байхгүй. Үрчлэлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлд “Үрчлэн авсан болон үрчлүүлсэн этгээд үрчлэгдсэн тухайгаа нууцлахыг хүсвэл бусад нь түүний хүслийг хүндэтгэж, задруулахгүй” гэж заасан байдаг. Энэхүү заавар нь үрчлэлтийн уламжлалт "хаалттай" ба хувийн шинж чанарыг чухалчилдаг тул аливаа мэдээллийг задруулах нь төрсөн эцэг эх, үрчлэн авагчдын үзэмжээр шийдэгдэх асуудал болно. Энэ нь үрчилж авсан хүн авч үзэх ёстой мэдээллийн эрхтэй байж болзошгүй гэсэн саналгүй байна. Барууны орнуудад дэлгэрч байгаа мөрдөх, дахин нэгтгэх үйлчилгээтэй дүйцэхүйц үйлчилгээ Хятад улсад байхгүй ч улс хоорондын үрчлэлтийн хүрээнд CCCWA болон холбогдох асрамжийн газрууд үрчлэгдсэн болон үрчлэн авсан хүмүүст үрчлэлтийн өмнөх асрагч нартай байнгын холбоо тогтоохыг санал болгож байгааг уг үйлчилгээтэй адилтгаж болохоор байна.

2. Франц улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт

I. Үрчлэлтийн эх сурвалж

Франц улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 оны 1 дүгээр сарын 26-ний өдөр гарын үсэг зурж, 1990 оны 8 дүгээр сарын 7-ний өдөр соёрхон баталсан.[65] Гаагийн конвенцод 1995 оны 4 дүгээр сарын 5-ний өдөр гарын үсэг зурж, 1998 оны 6 дүгээр сарын 30-ны өдөр соёрхон баталж, 1998 оны 10 дүгээр сарын 1-ны өдөр дагаж мөрдсөн.[66] Франц улсын хувьд улс хоорондын үрчлэлтийн харилцаанд дараах хууль, журмыг баримталдаг.[67]

- Францад 1804 оны Иргэний хуульд 21-ээс дээш насны насанд хүрэгчдийг үрчлэх тухай хуульд тусгасан.
- Францад 1923 оны 6-р сарын 19-ний өдрийн хуулиар насанд хүрээгүй хүүхдийг үрчилж авах боломжтой болгосон. 40-өөс доош насны хууль ёсны хүүхэдгүй насанд хүрэгчид, үргүйдэл болон дайны үеэр ганц хүүхдээ алдсан олон хосууд насанд хүрээгүй хүүхэд үрчлэн авах эрхтэй болов.
- Францад 1939 оны 7-р сарын 29-ний өдрийн хууль буюу гэр бүлийн код гэж нэрлэгддэг тогтоолоор Францын хууль тогтоомжид бүрэн үрчлэлтийг нэвтрүүлсэн байна.

---

[65] United Nations, Convention on the Rights of the Child, New York, 20 November 1989 https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=IND&mtdsg_no=IV-11&chapter=4

[66] Protection of Children and Co-operation in Respect of Intercountry Adoption, 29 May 1993

[67] Overview of French Adoption Law http://www.adoptionpolicy.org/pdf/eu-france.pdf

- 1998 оны 9-р сарын 1-ний өдрийн 98-771 тоот үрчлэлтийн дүрмээр төрийн асрамжийн газарт хүүхэд үрчлэн авах зөвшөөрөл хүссэн өргөдлийг үнэлэх зохицуулалтыг тогтоосон байна.
- 2001 оны 2-р сарын 6-ны өдрийн 2001-111 тоот дүрмээр Францын хууль тогтоомжийг 1993 оны 5-р сарын 29-ний өдөр Конвенцын де Ла Хай-тай "тохируулах" зорилгоор улс орон даяар үрчлүүлэхтэй холбоотой заалтуудыг оруулсан байна.
- 2002 оны 2-р сарын 22-ны өдрийн 2002-93 тоот дүрэм. Энэ дүрмээр тус улсын өмнө үрчлэгдсэн хүүхдүүд болон улсын хамгаалалтад байгаа хүүхдүүдэд өөрсдийн мэдээллийн бүртгэлтэйгээ танилцах эрхийг олгосон. Мөн үрчлэн авагчид, үрчлэгч болон төрсөн эцэг эхийн ашиг сонирхлын хооронд зуучлах зорилгоор Conseil national pour l'accès aux origines personalles (CNAOP) хэмээх шинэ комисс байгуулсан байна.
- 2004 оны 2 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан 'Францын Иргэний хууль" (Civil code)-ийн Үрчлэн авах тухай" бүлэг нэмсэн.
- 2005 оны 7-р сарын 4-ний өдрийн 2005-744 тоот дүрэм. Энэ дүрмээр үрчлэгчид үзүүлэх дэмжлэгийг сайжруулах зорилгоор үрчлэлтийн агентлагийг байгуулсан.
- Францын Иргэний хууль: VIII хэсэг; үрчлэлтийн тухай (343-370-5-р зүйл)

  I бүлэг - Бүрэн үрчлэлтийн тухай (343-359р зүйл)
  - I хэсэг - Бүтэн үрчлэлтэд тавигдах шаардлагуудын тухай
  - II хэсэг - Бүрэн үрчлэлтийн зорилгоор байршуулах тухай болон бүрэн үрчлэлтийн шийдвэрийн тухай
  - III хэсэг - Бүрэн үрчлэлтийн үр нөлөө

  II бүлэг - Энгийн үрчлэлтийн тухай (360-с 370-2 зүйл)
  - I хэсэг - Шаардлага ба шийдвэрийн тухай
  - II хэсэг - Энгийн үрчлэлтийн үр нөлөө

  III бүлэг - Хүүхэд үрчлэн авахтай холбоотой хууль тогтоомжийн зөрчлийн тухай болон гадаад руу үрчлэлтийн захирамжийн Франц дахь үр нөлөө (370-3-аас 370-5-р зүйл).

II. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг

Гадаад Европын харилцааны яамны харьяа "Олон улсын хүүхэд үрчлэн авах төлөөлөгчийн газрыг" ("La Mission de ['adoption internationale") улс хоорондын үрчлэлтийн асуудал хариуцсан төв байгууллагаар байгуулсан.[68] Үрчлэлтийн үйл явц нь хоёр дараалсан алхмыг шаарддаг. Зөвшөөрөл (хэлэлцээр) олгодог захиргааны журам, үрчлэлтийн шийдвэр гаргадаг шүүхийн журам байна. Хүүхэд үрчлэн авах тухай тушаал гаргах үүрэг нь дүүргийн зөвлөлийн дарга болон түүний төлөөлөгчдөд ногддог. Үрчлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг Гадаад хэргийн алба, Гэр бүлийн хэлтэс (Эрүүл мэнд, нийгмийн халамжийн хэлтэст хавсаргасан) хамтран хариуцдаг. Холбогдох төрийн байгууллагууд нь Үндэсний хамгаалах зөвлөл (CNPE), Францын үрчлэлтийн агентлаг (ICA) орон нутгийн

[68] La Mission de l'adoption internationale https://www.diplomatie.gouv.fr/fr/adopter-a-l-etranger/la-mission-de-l-adoption-internationale/#:~:text=La%20Mission%20de%20l'adoption%20internationale%20(MAI)%20est%20l,Europe%20et%20des%20Affaires%20%C3%A9trang%C3%A8res.

эрх баригчид (Conseil départementaux), Улс хоорондын үрчлэлтийн төв байгууллага (SAI) болон эрх бүхий үрчлэлтийн агентлагууд байна.

Төв байгууллага нь: Улс хоорондын үрчлэлтийн алба. (SAI)[69] Францын хувьд Гаагийн конвенцод заасан Улс хоорондын үрчлэлтийн асуудал эрхэлсэн төв байгууллага нь Гадаад, Европын харилцааны яамны харьяа алба болно. Гадаад болон Европын хэрэг, Гэр бүл, Хууль зүйн яамдаас бүрдсэн 22 хүний бүрэлдэхүүнтэй. Энэ нь улс хоорондын харилцаа, Төв эрх баригчдын хоорондын харилцаа, хүүхдийн гарал үүслийн улс болон бусад хүлээн авагч орны эрх баригчидтай харилцах, түүний дотор хоёр талын гэрээ хэлэлцээр, улс хоорондын үрчлэлтийн талаарх олон талт баримт бичгүүдийг хэлэлцэн тохиролцох, дахин хэлэлцэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

“Олон улсын хүүхэд үрчлэн авах төлөөлөгчийн газар. (Mission de l'Adoption Internationale)[70] 2009 оны 4-р сарын 14-ний өдрийн тогтоолоор байгуулагдсан. MAI нь Францын ГХЯ-нд харьяалагддаг ба улс хоорондын үрчлэлтийн үйл явцыг зохицуулах зорилготой. Энэ нь Гаагийн конвенцын зорилгын үүднээс төв байгууллагын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд улс хоорондын үрчлэлтийн агентлагуудад зөвшөөрөл олгох, хяналт тавих үүрэгтэй. MAI нь Европ, Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам, Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яам зэрэг яам хоорондын багаас бүрддэг. Энэхүү олон талт байдал нь MAI-д бүрэн эрхээ мэргэжлийн ур чадвартай, ёс зүйтэй, шударгаар хэрэгжүүлэх боломжийг олгодог. MAI нь Францын Хүүхэд үрчлэн авах агентлаг (AFA) дээр стратегийн хяналтын арга хэмжээ авч, зөвшөөрөл олгож, үрчлэн авах эрх бүхий байгууллагуудад (OAA) хяналт тавьдаг. MAI нь үрчлэлтийн үндэсний журам, гадаадад үрчлүүлэх нөхцөлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, шинэчлэх ажлыг хангаж, үрчлүүлэх явцад хүүхэд үрчлэх гэж буй нэр дэвшигчдийг дагалддаг. MAI нь үрчлэлтийн бусад талуудтай хамтран хүүхэд хамгаалал, олон улсын үрчлэлтийн асуудлаар өөрчлөлтийн төлөөлөгч байх боломжийг олгох улс орны стратегийг (байршил, хэлэлцээр гэх мэт) хэрэгжүүлдэг. Энэ нь мөн улсаас улс руу буюу хүүхдийн гарал үүслийн улсууд болон бусад хүлээн авагч орнуудын эрх баригчидтай харилцах төрийн захиргааны төв байгууллага хоорондын харилцааг хариуцаж, үрчлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг. Хүүхэд үрчилж авах нэр дэвшигчид болон салбарын мэргэжилтнүүдийг шаардлагатай баримт бичгийн эх сурвалжаар хангахын тулд MAI мэдээлэл, жилийн тайлан, товхимол гэх мэтийг нийтлэн, олон улсын үрчлэлтийн статистикт хяналт тавьж, үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад эрх олгодог.

Францын үрчлэлтийн агентлаг. 2006 оны 5-р сарын 18-нд байгуулагдсан. Энэ агентлаг нь Гаагад нийцсэн бүх улс орнууд болон Франц улстай түншлэлийн гэрээ байгуулсан бусад оронд зуучлах итгэмжлэгдсэн төрийн байгууллага болно. Төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн байгууллага гэсэн давхар статустай. Хүүхэд үрчлүүлэх агентлагууд нь практикт дотоодын үрчлэлтийн ихэнхийг Хүүхдийн хамгааллын газар шийдвэрлэдэг бөгөөд энэ нь төрийн байгууллага учраас хураамж авдаггүй. Францын

[69] Liste des pièces nécessaires à la demande d’agrément en vue d’une adoption https://www.diplomatie.gouv.fr/IMG/pdf/AdoptionFinaleAngBD.pdf
[70] La Mission de l’adoption internationale https://www.diplomatie.gouv.fr/fr/adopter-a-l-etranger/la-mission-de-l-adoption-internationale/

гэр бүл үрчлэлт гэх мэт хувийн агентлагууд байдаг бөгөөд тэдгээр нь ихэвчлэн улс хоорондын үрчлэлт дээр ажилладаггүй ч зардлаа авах эрхтэй байна.

Шүүхийн үүрэг: Францад Дүүргийн шүүх (Tribunal judi ciaire) үрчлүүлэх хүсэлтийг хүлээн авах, эсвэл татгалзах шийдвэр гаргана. Tribunal judiciaire нь олон улсын хүүхэд үрчлэлтийг хянах үүрэгтэй байгууллага юм. Өргөдөл гаргагч нь хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ оршин суугаа дүүргийн шүүхэд гаргах ёстой. Өргөдөл гаргагчийн талд үрчлэх хүүхдийг өгсөн даруйд ийм хүсэлт гаргаж болно. Гэсэн хэдий ч, хэрэв хүсэлт нь бүтэн үрчлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх өргөдөл гаргагчийн хүүхэдтэй хамт байх зургаан сарын хугацаа дууссаны дараа л хүсэлтийг хянан үзэж болно.[71] Өргөдөл гаргагч болон үрчлэгдсэн хүүхдэд хамаарах хууль эрх зүйн нөхцөл ,зөвшөөрлийн хүчинтэй эсэхийг шалгадаг байна. Шүүх ерөнхий судалгаа шинжилгээ явуулж, үрчлэн авах нь хүүхдийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэхийг шалгах эрхтэй. Хүүхдийн халамжийн газар үнэлгээний шатанд олж авсан мэдээллээр шүүхэд өгч болно.

III. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур

Эхнэр, нөхөр хоёулаа аль нэгнийх нь хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргаж байгаа бол насны хязгаар, гэрлэлтийн үргэлжлэх хугацааны талаар ямар нэгэн шаардлага тавихгүй.[72] Ганцаар өргөдөл гаргагчийн үрчлэн авах насны доод хязгаар нь 28 нас байх шаардлага нь эхнэр эсвэл нөхрийнхөө хүүхдийг үрчлэн авч байгаа тохиолдолд энэ хамаарахгүй.[73] Энэ тохиолдолд тухайн хүүхэд зөвхөн тухайн эхнэр/нөхөртэй хууль ёсоор тогтоосон харьяалалтай бол бүтэн үрчлэлтийг зөвшөөрнө.[74] Үүнд: Эхнэр, нөхрөөс аль нэгнийх нь эцэг, эх нь эцэг эх байх эрхийг бүрэн хассан бол эсхүл эхнэр /нөхрөөс аль нэг нь нас барсан бөгөөд нэгдүгээр зэрэглэлийн хамаатан садан үлдээгээгүй, эсхүл тэдгээр нь хүүхдийг сонирхохоо илт больсон бол хамаарна. Төрсөн эцэг эхийн асран хамгаалсан хамтран амьдрагч буюу бүртгэлтэй хамтрагч нь түүний хүүхдийг үрчлэн авах эрхгүй. Учир нь энэ нь нөгөө төрсөн эцэг эх нь хүүхдийнхээ эцэг, эх байх эрхээ алдахад хүргэдэг. Шүүх гэрлээгүй төрсөн эцэг эхийн хүүхэдтэй холбоотой энгийн үрчлэлтийг захирамжлахаас татгалздаг байна.[75] Үрчлэгдэх хүүхэд нь улсын асрамжийн газар байх, хууль ёсны дагуу хаягдсан гэж зарласан, эсхүл түүний хууль ёсны асран хамгаалагч нь үрчлэн авахыг бүрэн зөвшөөрсөн байх ёстой. Хүүхэд үрчлүүлэхдээ хууль ёсны байдал, ил тод байдлыг хангасан хатуу дүрэм баримталдаг.

- Насны хувьд тавигдах шалгуур:
    - Гэрлэсэн хосууд тус бүр хоёулаа 28-аас дээш настай байх ёстой. Үрчлэгч нь хамгийн багадаа 28 настай өрх толгойлсон эцэг эх байж болно;

---

[71] [71] Dispositions générales (Articles 341 à 348)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070716/LEGISCTA000034682653?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000034747019#LEGIARTI000034747019
[72] Dispositions générales (Articles 341 à 348)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070716/LEGISCTA000034682653?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000034747019#LEGIARTI000034747019

[73] De l'adoptant (Articles 343 à 343-1)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006150070?init=true&page=1&query=343-1&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000045204971#LEGIARTI000045204971
[74] Des conditions requises pour l'adoption plénière (Articles 343 à 348-7)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006150070/2022-12-31?init=true&page=1&query=343-2&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000045204964#LEGIARTI000045204964
[75] De la corruption et du trafic d'influence passifs (Articles 435-1 à 435-2)
https://www.legifrance.gouv.fr/codes/id/LEGIARTI000042780042/2023-08-13/?isSuggest=true

- Үрчлэгч үрчлүүлэгч хоёрын насны зөрүү хамгийн багадаа 15 нас байна. Эхнэр, нөхөр хүүхдийг үрчлэн авах онцгой тохиолдолд үрчлэгч нь насны болзол хангасан байх албагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн үрчлэн авагч болон үрчлэгдэгчийн насны доод хязгаарыг 10 жил болгон бууруулжээ[76].

- Гэрлэгчдэд тавигдах шалгуур:
  - Шүүхийн журмаар салаагүй, гэрлээд хоёроос дээш жил болсон гэрлэсэн хос, мөн ганц бие, гэрлээгүй хүн үрчлэх хүсэлт гаргаж болно.[77]
  - Үрчлэгч нь Францад дор хаяж зургаан сарын хугацаатай оршин суугч байх ёстой.
- Эрүүл мэндэд тавигдах шалгуур:
  - Үрчлэгч нь бие болон сэтгэхүйн хувьд эрүүл, хүүхдийг өсгөн хүмүүжүүлж боловсрол олгох чадвартай этгээд байх ёстой
  - Үрчлэгч болон үрчлэгчийн гэр бүлд амьдарч буй хүмүүсийн эрүүл мэндийн байдлыг гэрчлэх сүүлийн гурван сарын хугацаанд хамрагдсан эрүүл мэндийн гэрчилгээ (өөрийн оршин суугаа газрынхаа эмнэлгийн тэнхимийн зөвлөлд бүртгэлтэй ерөнхий эмчийн тогтоосон) болон үрчлүүлэх зорилгоор хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд эсрэг заалт байхгүй гэсэн баримт бичиг хэрэгтэй. Эмнэлгийн ёс зүйн дүрмийн 100-р зүйлд заасны дагуу гэрчилгээг гаргагч нь үрчлэгчийн эмчлэгч эмч байх ёсгүй. Эмнэлгийн гэрчилгээнд энэ тухай дурдсан байх үүрэгтэй байна.[78]
- Гэр бүлд байх хүүхдэд тавигдах шалгуур:
  - Үрчлэгч эцэг эх нь хүүхдийг (үрчлүүлэх хүүхдийг оролцуулан) асрамжлах хангалттай цаг хугацаа, боломжтой байх
  - Хэрэв үрчилж авсан хүн өөрөө хүүхэдтэй бол хүүхэд үрчлэгдсэн нь гэр бүлийн амьдралд сөргөөр нөлөөлөхгүй эсэхийг шүүх мөн шалгадаг.[79]
- Удам угсаа шууд залгамжлах, ах дүү хоёрын хооронд үрчлүүлэхийг хориглоно. Гэсэн хэдий ч үрчлэгдсэн хүний ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлагатай ноцтой шалтгаан байгаа бол шүүх үрчлүүлж болно.[80]
- Орлогод тавигдах шалгуур:
  - Олон улсад үрчилж буй эцэг эхчүүдэд хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, өдөр тутмын зардал гэх мэт хэрэгцээг хангах хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байхыг шаарддаг. Ер нь үрчилж авсан эцэг эх нь хүүхдийг насан туршдаа тэжээх тогтвортой, хангалттай орлоготой байх ёстой.
  - Үрчлэгчийн санхүүгийн чадавхыг нотлох аливаа баримт бичиг (сүүлийн цалингийн хуулганы хуулбар эсвэл бусад санхүүгийн нөөцийг нотлох баримт)**[81]**

---

[76] Conditions for adoption in France https://www.notaires.fr/en/couple-family/adoption/conditions-adoption-france

[77] De l'adoptant (Articles 343 à 343-1) https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006150070?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000046372004#LEGIARTI000046372004

[78] Liste des pièces nécessaires à la demande d'agrément en vue d'une adoption https://www.diplomatie.gouv.fr/IMG/pdf/liste_pieces_necessaires_agrement_cle8374c9.pdf

[79] Du jugement d'adoption (Articles 353-1 à 354) https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000046369853/2023-01-01/

[80] Des rapports entre l'adoptant et l'adopté (Articles 346 à 347) https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006150072/

[81] Liste des pièces nécessaires à la demande d'agrément en vue d'une adoption https://www.diplomatie.gouv.fr/IMG/pdf/liste_pieces_necessaires_agrement_cle8374c9.pdf

- Хүүхдийн гарал үүслийн улсаас хамааран үрчилж буй эцэг эх нь тухайн улсаас тогтоосон орлогын тодорхой шаардлагыг хангасан байх шаардлагатай.

- Боловсролд тавигдах шалгуур:

  Гадаад үрчлэлт хийх эцэг эхчүүдэд боловсролын тусгай шаардлага байдаггүй. Гэсэн хэдий ч үрчлүүлэх эрх бүхий байгууллага үрчлэгч эцэг, эхийн боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар зэргийг үрчлүүлэхэд тохиромжтой байдлын ерөнхий үнэлгээний нэг хэсэг болгон авч үздэг. Францын үрчлэлтийн эрх баригчид үрчилж авсан эцэг эхийн боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвараас үл хамааран хүүхдээ хайраар дүүрэн, тогтвортой гэр бүлээр хангах чадварт нь үндэслэн үрчилж авах боломжтой эсэхийг үнэлдэг.

- Зан байдлын шалгуур:
  - Гэмт хэргийн бүртгэлийн №3 товхимлыг баталгаажуулж ирнэ. Үүнд: (Хууль зүйн яам, Эрүүгийн хэрэг, өршөөлийн газрын дарга, Үндэсний гэмт хэргийн бүртгэл - 44079 Nantes cedex 01)
  - Үрчлэгч нь урьд өмнө нь ял шийтгүүлж байгаагүй, хууль болон дүрэм журмыг дагаж мөрдөх ёс зүйн зөв төлөвшил, зан байдалтай байх ёстой.

- Бусад зүйл:
  - Үрчлэгдсэн хүүхэд үрчлүүлэх үедээ 15 нас хүрээгүй (хэдийгээр зарим үл хамаарах зүйл байдаг) бөгөөд үрчилж авсан эцэг эхийн асрамжид дор хаяж зургаан сар амьдарсан байх ёстой байна.
  - Үрчлэгдсэн хүүхэд нь улсын асрамжид байгаа, эсхүл хууль ёсны дагуу хаягдсан гэж зарласан, эсхүл түүний хууль ёсны асран хамгаалагч нь үрчлэн авахыг зөвшөөрсөн байна.
  - Гадаадад зохих ёсоор үрчлүүлэхэд хэрэв үрчлэгдэгч өмнөх гэр бүлийн харилцааг бүрмөсөн, эргэлт буцалтгүй орхисон байхыг шаардана.

Францад улсад үрчлэлтийн дараах төрөлтэй. Үүнд: Бүтэн үрчлэлт болон энгийн үрчлэлт. Үрчлэн авах хүсэлт гаргаснаас хойш есөн сарын дотор өргөдөл гаргагчид зөвшөөрөл олгох эсвэл татгалзсан тухай мэдэгдэнэ. Хорооны зөвшөөрөл нь “гэр бүл, боловсрол, сэтгэл зүйн түвшинд санал болгож буй нөхцөл нь хүүхдийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцэж байна” гэсэн дүгнэлтэд үндэслэнэ. Шийдвэрт үрчлүүлж болох хүүхдийн тоог, хэрэв байгаа бол зааж өгөх бөгөөд үрчлүүлэх хүүхдийн тоо, нас зэрэгт тавих хязгаарлалттай холбоотой мэдэгдлийг тусгаж болно. Зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагч захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж болно. Зөвшөөрөл нь таван жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд хэрэв өргөдөл гаргагч нь Францад өөр газар руу нүүсэн тохиолдолд дүүргийн зөвлөлийн даргад бүртгүүлсэн тохиолдолд хүчинтэй хэвээр байна. 1998 оны 9-р сарын 1-нээс хойш улсын асрамжид байгаа хүүхдүүдийг болон гадаадын хүүхэд үрчлэн авах хүсэлтэй аливаа зөвшөөрөгдсөн хүн жил бүр үрчилж авах хүсэлтэй байгаагаа баталгаажуулах шаардлагатай болсон. Хүсэлт өгснөөс хойш хоёр жилийн дараа үрчлэн авагч хүүхэд үрчилж аваагүй байвал үрчлэлтийн алба тэдний хүсэл зоригийг тодруулах, нийгмийн ажлын тайланг шинэчлэх шаардлагатай эсэх, шаардлагатай бол зөвшөөрлийг нь буцаах шаардлагатай эсэхийг тодорхойлох уулзалт зохион байгуулдаг байна.

IV. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага

Иргэний хуулийн 347 дугаар зүйлд зааснаар дараах хүүхдүүдийг үрчилж болно: Үрчлүүлэхийг эх, эцгийнх нь болон гэр бүлийн зөвлөлөөс зөвшөөрсөн хүүхэд, төрийн асрамжид байгаа хүүхдүүд (олдсон хүүхдүүд, өнчин хүүхдүүд, эцэг эх нь эцэг эхийн бүх үүрэг хариуцлагаас хасагдсан хүүхэд). Төрийн асрамжид байгаа хүүхдийг хүүхдийн асрамжийн газраас асран хамгаалагчид нь тэдний хооронд үүссэн сэтгэл хөдлөлийн холбоо нь ийм арга хэмжээ авахыг шаардсан эсвэл үрчлүүлэх зөвшөөрөл авсан бол хүүхдийг үрчлэн авч болно. Мөн зөвхөн асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг хүлээн авах боломжтой, тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд итгэмжлэгдсэн гэр бүлийн гишүүнгүй өнчин хүүхдүүдийг үрчилнэ. Бүтэн үрчлэлт хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд (15-аас доош насны хүүхдэд) зөвхөн хүүхэд үрчлэн авагч нь итгэмжлэгдсэн, гэрт нь дор хаяж зургаан сар амьдарсан тохиолдолд л зөвшөөрнө.[82] Том хүүхдүүдийн хувьд "хүүхэд бага байх үед болон насанд хүрснээс хойш хоёр жилийн дотор" зөвхөн хүүхэд 15 нас хүрэхээс өмнө (i) үрчлүүлэх тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй хүмүүсийн гэрт амьдарч байсан (ii) энгийн үрчлэлтийн хүрээнд яригдаж байсан бол үрчлэлтийг зөвшөөрнө.[83] Дотоодын үрчлэлтийн хувьд хүүхэд үрчлэгчтэй ураг төрлийн болон гэрлэлтийн холбоогүй мөн хүүхэд хоёр нас хүрээгүй бол түүнийг хүүхэд асрах алба, үрчлэн авах эрх бүхий байгууллагад хүргүүлэх ёстой.[84] Энэхүү заалт нь биологийн гэр бүл болон үрчилж авах боломжтой хүмүүсийн хооронд шууд холбоо тогтоохоос зайлсхийх зорилготой юм.

V. Үрчлэлтийн дараах хяналт

Улс хоорондын үрчлэлтийн дараах хяналт нь хүүхэд нэг улсаас нөгөөд үрчлэгдсэний дараа явагддаг чухал үйл явц юм. Францад энэ үйл явцыг Олон улсын хүүхэд үрчлэлтийн төв байгууллага (Autorité Centrale pour l'Adoption Internationale) хянадаг бөгөөд үрчлэгдсэн хүүхдийн сайн сайхан байдал, шинэ гэр бүлтэй нь нэгтгэх байдалд хяналт тавьдаг. Улс хоорондын үрчлэлтийн дараах хяналтын үйл явц нь ихэвчлэн AFA болон үрчилж авсан гэр бүлийн хооронд тогтмол харилцах, түүнчлэн нийгмийн ажилтан эсвэл бусад итгэмжлэгдсэн төлөөлөгч гэр бүлийнх нь гэрт үе үе зочлох явдал юм. Эдгээр айлчлалын зорилго нь хүүхдийн ахиц дэвшил, сайн сайхан байдлыг үнэлэх, ар гэрт нь дэмжлэг, зөвлөгөө өгөх, үрчлэлтийн үйл ажиллагаа хүүхдийн эрх ашигт нийцсэн хэвээр байгаа эсэхийг баталгаажуулах байна. Францад үрчлэгдсэний дараах улс хоорондын хяналтын үйл ажиллагаа нь заавал байх ёстой бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний хэрэгцээг хангахад чиглэгдсэн байдаг. Хэрэв AFA хяналт шалгалтын явцад ямар нэгэн санаа зовоосон асуудал илэрвэл гэр бүлд нэмэлт дэмжлэг үзүүлэх, эсвэл онцгой тохиолдолд үрчлэлтийг цуцлах зэрэг эдгээр асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч болно. Үрчлүүлсний дараа гэр бүлд дотно харилцааг мэргэжилтнүүдээр дагалдуулан бий болгох ёстой.[85] Үрчлэлтийн дараах хяналт нь үрчлэлтийн журмын салшгүй хэсэг болно. Олон улсад үрчлүүлэх хүүхдүүдийн хувьд хүүхэд үрчилж авсны дараах хяналтын тайланг

[82] Du jugement d'adoption (Articles 353-1 à 354) https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070721/2023-01-01/
[83] Du jugement d'adoption (Articles 353-1 à 354) https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006070721/2023-01-01/
[84] Du consentement à l'adoption (Articles 348 à 350) https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000046369344?init=true&page=1&query=348-5&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000046373761#LEGIARTI000046373761
[85] Le suivi post-adoption https://www.agence-adoption.fr/lafa-vous-accompagne/apres-ladoption/le-suivi-post-adoption/3/

гаргаснаар үрчлэгдсэний дараах хяналтыг хийдэг. Энэ тохиолдолд давтамжтай тайлангуудыг гаргана. Тиймээс хүүхэд өөрийгөө бэлэн гэж үзвэл өнгөрсөн үеийнхээ мэдээллийг хайж олох бөгөөд эцэг эхийн дамжуулсан тайлангууд нь түүний түүхийн нэг хэсэг болно. Үрчлэлтийн дараах хяналт нь нийгэм болон гэр бүлийн хувийн амьдралд халдсан хэрэг биш юм. Энэ нь амьдралын эхний жилүүдийг хүүхэдтэй хамт өнгөрөөх үнэ цэнтэй боломж болно. Энэхүү гадны хяналт нь эцэг эх, хүүхдүүд амжилттай нэгдэх хэрэгсэл болдог. Үрчлэлтийн дараах тайлан бичихийн тулд хэд хэдэн айлчлал хийхээр төлөвлөдөг. Ярилцлага нь хүүхдийн бие бялдар, сэтгэл зүй, боловсролын хөгжил, түүнчлэн түүний шинэ гэр бүл дэх сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийг ажиглах боломжийг олгодог. Ихэнх ярилцлага тухайн үрчлэгдсэн гэрт явагддаг. Өөр бас төв газар товлон уулзах нь эмзэг сэдвүүдийг хэлэлцэх боломжийг олгоно. Хэлэлцүүлгийн эдгээр үе нь гэртээ хийсэн ярилцлагаас гадна явагддаг байна. Хүүхэд үрчилж авсны дараах мониторингийн тайлан нь тухайн хүүхдийн хөгжлийг хянаж байх арга болно. Мониторингийн тайланг орон нутгийн хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд, тогтоосон хэлбэрээр илгээхэд ихээхэн ач холбогдол өгдөг. Үрчлэгчид үрчлэгдсэний дараах нэг буюу хэд хэдэн тайланг гаргаж, хүүхдийн гарал үүслийн улсын эрх бүхий байгууллагад илгээх үүрэг хүлээсэн.

VI. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

1993 оны Үрчлэлтийн тухай конвенцод улс хоорондын үрчлэлтийг хүчингүй болгох талаар ямар нэгэн заавар заагаагүй болно. Тиймээс эдгээр журмыг хэлэлцэн тохирогч тал бүрийн үндэсний хуулийн дагуу явуулдаг. Францад улс хоорондын үрчлэлтийн асуудлыг Францын үрчлэлтийн төв байгууллага (Autorité Centrale pour l'Adoption Internationale эсвэл AFA) зохицуулдаг бөгөөд Францын болон олон улсын хууль тогтоомжийн аль алинд нь захирагддаг. Хүүхэд үрчилж дууссаны дараа энэ нь эргэлт буцалтгүй бөгөөд эцсийн байх зорилготой гэдгийг олон улс орнууд илэрхийлсэн байдаг. Иймд залилан мэхлэхтэй холбоотой (эсвэл түүний хууль ёсны байдлыг алдагдуулсан хууль бус үйлдэл) үндэслэлээс бусад тохиолдолд үрчлэлтийг хүчингүй болгох нь зөвхөн онцгой нөхцөл байдалд боломжтой. Францад улс хоорондын үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгаа бол түүнийг хэрэгжүүлэх үйл явц нь тухайн хэргийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаална. Үрчлэлтийг хүчингүй болгох нь зөвхөн шүүхээр шийдэгдэх бөгөөд үрчлэлт нь хүүхдийн ашиг сонирхолд нийцээгүй болохыг нотлох баримт шаардана. Францын хуулийн дагуу үрчлэлтийг хүчингүй болгох хэд хэдэн үндэслэл байдаг бөгөөд Үүнд:

- Үрчлэх нь хүүхдийн эрх ашигт нийцээгүй
- Үрчилж авсан эцэг эх нь хүүхдэд зохих ёсоор анхаарал халамж тавьж, дэмжлэг үзүүлж чадаагүй
- Үрчилж авсан эцэг, эх нь үрчлэлтийн нөхцөлийг зөрчсөн буюу хүүхдийн эрхийг зөрчсөн
- Хууран мэхлэлт эсвэл албадлагаар үрчлүүлсэн

VII. Байршуулах үйл ажиллагааны зохицуулалт

Гэр бүлийн байдлаас үл хамааран хэрэгжих, “нууцыг хадгалах” хууль, мөрдөснөөс хойш хоёр хоногийн дараа эх нь нийгмийн халамжийн байгууллагад удаан хугацаагаар ярилцлага өгч, эцэст нь нийгмийн халамж, гэр бүлийн тухайх уульд заасны дагуу хүүхдээ төрийн асрамжид өгсөн тухай тэмдэглэлд гарын үсэг зурсан мөн захидал, гэрэл зураг,

захиргааны баримт бичиг бүхий хүүхдэд зориулсан баримтын хамт төрийн асрамжид өгөхийг хүссэн, үүнийгээ нууцлахыг хүсэж, үрчлэн авахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл үйлдсэн байх ёстой. Дараах тохиолдолд хүүхдээ эргүүлэн авах хүсэлтийг хүлээн авна.

- Хүүхдийг Хүүхдийн асрамжийн газарт даатгасан эцэг, эх нь хоёр сарын дотор буцаан нэхэмжилсэн хүүхдийг ямар нэгэн албан ёсны арга хэмжээ авахгүйгээр тухайн эцэг эхэд нь буцаан олгоно.[86]
- Хэрэв тухайн хүүхдийг өөрийг нь хүүхдийн халамжийн төвд хүлээлгэж өгөөгүй хоёр дахь эцэг эхтэй бөгөөд зургаан сарын дотор хүүхдээ эргүүлэн авахыг хүссэн бол хүүхдийг ямар нэгэн албан ёсны арга хэмжээ авахгүйгээр тухайн эцэг эхэд нь буцаан олгоно.[87]
- Эдгээр хугацаа дууссаны дараа (хэрэв ганц эцэг эх, эсвэл эцэг эх хоёулаа хүүхдийг халамжид даатгасан хоёр сар, хоёр дахь эцэг эх нь хүүхдээ үйлчилгээнд даатгаагүй зургаан сар) хүүхдийг төрийн асрамжид байлгах асуудлыг шүүхээр хянан шийдвэрлүүлэх хүсэлтийг албан ёсоор бүртгүүлснээс хойш гуч хоногийн дотор Их шатны шүүхэд хандаж болно.

Хүүхдийг үрчлүүлэхээр байршуулснаас хойш эдгээр хугацаа өнгөрсөн бол хүүхдийг буцааж өгөх хүсэлтийг хүлээн авах боломжгүй болно.[88] Үүнд:

- Түүнд төрийн асрамжийн газарт өгөх, үрчлэн авахыг зөвшөөрсний үр дагавар, хүүхдийг эдгээх эрүүлжүүлэх, зөвшөөрлийг буцаах нөхцөлийг тусгасан мэдэгдэл өгсөн
- Түүнд хүүхдээ буцааж өгөх болон/эсвэл хэрэв зөвшөөрөл авсан бол үрчлэн авах зөвшөөрлөө буцааж авах тухай үлгэрчилсэн захидал өгсөн.
- Мөн өдөр тэрээр хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрч, дээрх мэдээллийг хүлээн авч, зөвшөөрөл өгөх нь ямар үр дагавартай болохыг ойлгож, үрчлэлтийн үйл явцын үр дагаврыг хүлээн зөвшөөрч байгаагаа баталгаажуулсан.

Байршуулахаас өмнө төрсөн эцэг, эхэд зөвлөгөө өгөх ямар нэгэн хуулиар тодорхой үүрэг хүлээсэн байгууллага байхгүй ч сайн туршлагын хувьд, дотоод дахь бүрэн үрчлэн авалтын журмын хүрээнд үүнийг Хүүхэд халамжийн алба/газар хариуцдаг байна. Үрчлүүлэхийн тулд зөвшөөрөл авах шаардлагатай хүмүүст үргэлж зөвлөгөө өгч, тэдний зөвшөөрлийн үр нөлөөг зохих ёсоор мэдээлнэ, тэр дундаа бүрэн үрчлэлтээр хүүхэд болон түүний төрсөн гэр бүлийн хоорондын хууль эрх зүйн харилцаа дуусгавар болно гэдгийг бүгдэд нь мэдэгдэх болно. Зөвшөөрлийн хороо ирээдүйн үрчлэгчдийг албан ёсоор баталсны дараа үрчилж авах хүүхэдтэй холбоо тогтоох талаар урьдчилсан зохицуулалт хийх боломжтой. Энэ зохицуулалтыг хийх зохих байгууллага нь үрчлэхээр төлөвлөж буй хүмүүс нь анхан эсвэл гуравдагч этгээдийн өргөдөл гаргаж буй эсэх, дотоодын эсвэл улс хооронд үрчлэлтийн санал гаргаж байгаа эсэхээс хамаарна. Үрчлэн авах эцсийн захирамж гарахаас өмнө хүүхдийг ихэвчлэн гуравдагч этгээдэд үрчлүүлэхээр туршилтын журмаар

[86] Dispositions générales (Articles 341 à 348)
https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000034747019?init=true&page=1&query=343&searchField=ALL&tab_selection=all

[87] Мөн тэнд

[88] Du consentement à l'adoption (Articles 348 à 350)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000046369344?init=true&page=1&query=348-3&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000046373309#LEGIARTI000046373309

байрлуулдаг. Үүнийг placement en vue d'adoption гэж нэрлэдэг. Үрчлэх зөвшөөрөл олгогдсоноос хойш хоёр сарын дотор байршуулж болохгүй бөгөөд зөвхөн санал болгож буй бүтэн үрчлэлтийн хүрээнд байршуулна. Хэрэв энэ хугацаа дууссаны дараа зөвшөөрлийг нь буцаагаагүй байвал тухайн хүүхдийг үрчлүүлэхээр байршуулж болно.[89] Хүүхдийг байршуулахаас өмнө гэр бүл, эцэг тогтоох аливаа ажиллагааг явуулах ёстой. Хүүхдийг үрчлэх зорилгоор гэр бүлд байршуулснаар (popment en vue d'adoption) хүүхдийг төрсөн гэр бүлд нь буцааж өгөх сонголтыг цаашид хориглоно.[90] Хэрэв үрчилж авахаар төлөвлөж буй хүмүүс нь хүүхэдтэй хамаатан садан, мөн тухайн хүүхэд 2-оос доошгүй настай бол эцэг эхийн зөвшөөрлийг авсны дараа (жишээлбэл, хөндлөнгийн хяналтгүйгээр) шууд шүүхэд өргөдөл гаргадаг.[91]

Төрсөн эцэг эх нь байршуулах: Францад хүүхэд үрчлэн авах үйл явц нь төрсөн(хоёр нас хүрээгүй бол) эцэг эх нь үрчилж авах эцэг эхийг шууд сонгох, эсвэл өөрсдийн сонгосон хүнд үрчлүүлэхийг хориглодог.[92] Эцэг эхийн үүрэг нь хүүхдээ үрчлэн авах зөвшөөрөгдсөн агентлагт хүлээлгэн өгөхөөр хязгаарлагддаг бөгөөд тус агентлаг нь үрчлүүлэх сонгон шалгаруулалтыг бүрэн хариуцдаг байна. Энэ журам нь төрсөн эцэг эх, эсвэл үрчилж авахаар төлөвлөж буй хүмүүст хэт дарамт учруулахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. "Accouchement sous X(төрөлтийг "X" үсгээр тэмдэглэсэн нь төрсөн эхийн хэн болох нь тодорхойгүй)" хүүхэд төрөх үед хүүхдийг үрчлэн авах зөвшөөрлийг төрийн зохих байгууллага хариуцдаг. Иргэний хуулийн 352 дугаар зүйлд заасны дагуу ийм байршуулалт нь хүүхдийг эхэд нь буцааж өгөхөөс гадна ураг төрөл болох тухай эсвэл хүлээн зөвшөөрөх тухай мэдүүлэг гаргахад саад учруулдаг.[93] Хүүхэд шинэ гэр бүлд ирсэн цагаас эхлэн үрчлүүлэх тухай тушаал гарах хүртэл хүүхдийг байршуулах ажилд хяналт тавьдаг. Хүүхдийн асрамжийн газрын хүүхэд үрчлэх алба нь шүүхийн шийдвэрээр хүүхдийн эрх зүйн статусыг өөрчлөх хүртэл улсын асрамжид буй хүүхдийн эрх ашиг, эрүүл мэндийг хариуцна. Хүүхэд асрамжийн газрын үрчлэлтийн алба эсвэл Францын үрчлэлтийн агентлаг (Agence française de l'adoption) аль алинд нь байршуулсны дараах үнэлгээ, дэмжлэг үзүүлэх үйл явц байдаг. Улс хоорондын зуучлалын хувьд эх орон болон үрчлэн авагчдын хүсэлтээр гадаадад төрсөн хүүхдийг байршуулах ажлыг зохион байгуулсан алба, байгууллага хяналт тавьж болно. Өргөдлийн албан ёсны шүүхийн сонсон үйл явц нь Францад үрчлүүлэх үйл явцын эцсийн шатанд болно.

VIII. Үрчлэлтийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон улс хоорондын үрчлэлтийн бүх талуудад үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүлэх хуулийн хариуцлага хэлтэс бүр дээр байдаг. CLSC

---

[89] Du consentement à l'adoption (Articles 348 à 350)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000046369344?init=true&page=1&query=348-3&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000046373309#LEGIARTI000046373309

[90] Le renvoi pour cause de sûreté publique (Articles 351 à 354)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070716/LEGISCTA000006135982?init=true&page=1&query=352&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000034803449#LEGIARTI000034803449

[91] Dispositions générales (Articles 341 à 348)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070716/LEGISCTA000034682653?init=true&page=1&query=347&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000035369543#LEGIARTI000035369543

[92] Du consentement à l'adoption (Articles 348 à 350)
https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000046369344?init=true&page=1&query=348-5&searchField=ALL&tab_selection=all&anchor=LEGIARTI000046373761#LEGIARTI000046373761

[93] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 604

Plateau Mont Royal зэрэг байгууллагууд үрчлэлтийн дараах янз бүрийн үйлчилгээг бүлгийн хуралдаан, ганцаарчилсан зөвлөгөө хэлбэрээр үнэ төлбөргүй санал болгодог. Үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэхийн тулд Хүүхэд үрчлэлтийн зөвлөгөө, зөвлөх үйлчилгээ (COCAs) байдаг. 2005 оны 7-р сарын 4-ний өдрийн 2005-744 тоот дүрмээр үрчлэгчдэд туслах зорилгоор үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээг санал болгох үүргийг нэвтрүүлсэн. Хэрэв үрчлэгчид саналыг хүлээн авбал үйлчилгээний хариуцлагыг орон нутгийн засаг захиргааны үрчлэлтийн алба эсвэл Францын үрчлэх агентлаг хариуцан үйлчилгээг үзүүлнэ.

IX. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

Холбогдох хүүхдүүдийн хувьд эцэг эхийн нэрээ нууцлах хууль эрх зүйн баталгаа олгосон.[94] 2002 оны нэгдүгээр сарын 22-нд батлагдсан "Үндэс угсаагаа мэдэх эрхийн тухай" хуулийг мөрдөж[95], хүүхэд төрүүлсэн эхэд нууцаар овог нэрээ битүүмжилсэн дугтуйнд бичиж өгөхийг зөвшөөрснөөр тэд хүүхэдтэйгээ уулзах эсэхээ хожим нь шийдэх боломжийг нээлттэй үлдээж байна. Эх хүн хэн болохоо илчлэх үүрэг хуулиар хүлээгээгүй. Төрөх үед өөрийнхөө төрөлт болон хэн болохыг нууцлахыг хүссэн эмэгтэйг сайн дурын үндсэн дээр өөрийнхөө болон эцгийн эрүүл мэнд (хэрэв түүнд ийм мэдээлэл байгаа бол), хүүхдийн гарал үүсэл, төрсөн нөхцөл байдал, мөн түүний биеийн байдлын талаарх мэдээллийг битүүмжилсэн дугтуйнд хийж үлдээхийг зөвлөдөг. Үүнд тэрээр өөрийн нэр, төрсөн он сар өдөр, төрсөн газраа зааж өгч болно. Дугтуйны хавтсанд түүний хүүхдэд зориулж сонгосон анхны нэрс, түүнчлэн түүний хүйс, огноо, цаг, төрсөн газар бичсэн байна. Энэхүү дугтуйг хадгалдаг бөгөөд зөвхөн хүүхэд эсвэл түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр CNAOP-ийн гишүүн л битүүмжлэлийг тайлж болно. Энэ тохиолдолд CNAOP эхийг хайж эхэлж, түүнтэй холбоо барьж болно. Үнэн хэрэгтээ ээж нь ямар ч үед өөрийн хувийн нууцлалаа түдгэлзүүлж болно, гэхдээ тэр хүүхдээ хайх эрхгүй байхаар зохицуулж өгсөн байна.Үрчлэгдсэн хүний төрсний гэрчилгээнд бичигдсэн хязгаарлагдмал бодит мэдээлэл, түүнд хандах үйл явц болон агентлагийн файлд хадгалагдах шаардлагатай мэдээллийн хэмжээ зэрэг нь үрчлэгдэгч эсвэл төрсөн эцэг эх нь үрчлэлийн талаар бүрэн бодит дүр зургийг олж авахад хэцүү болгодог. Гэхдээ үрчлэгдсэн хүүхэд насанд хүрсэн бол хүсэлт гаргасны дагуу, эс бөгөөс хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан захиргааны хэргийн бүх бичиг баримттай танилцах эрхтэй байх болно.

Үрчлэгдсэн хүмүүс өөрийн бүртгэлтэй төрийн нийгмийн халамжийн газар болон үрчлэлийн агентлагт хандаж болно. Үрчлэхээс өмнө хэн болох нь тодорхой байсан хүүхдүүд шүүхийн шийдвэрээр эдгээр мэдээллийг олж авах боломжтой. 2009 онд Хүүхдийн эрхийн хороо "Конвенцын 7 дугаар зүйлд заасан хүүхдийн төрсөн эцэг, эх, ах эгч дүүсээ мэдэх эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Франц улс зохих бүх арга хэмжээг авна гэсэн өмнөх зөвлөмжөө дахин давтсан".[96] Мэдээлэл олж авах эрх нь үрчлүүлэх захирамжийн төрлөөс хамаарна .Үүнд:

[94] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 611
[95] Мөн тэнд
[96] Committee on Rights of the Child concludes fifty-first session https://reliefweb.int/report/mauritania/committee-rights-child-concludes-fifty-first-session

Бүрэн буюу "бүтэн" үрчлэлтэд нийтийн бүртгэлтэй танилцах тухай заалтууд нь үрчлэгдсэн болон үрчилж авсан хүмүүст үрчлэгдсэн тухай баримтыг дурдсан албан ёсны баримт бичиг (төрсний гэрчилгээний бүрэн хуулбар) авах боломжийг олгодог. Үрчлэх тухай захирамж гарах үед хүүхдийн хэн болох нь тодорхой байсан бол уг захирамжид бүрэн үрчлэлт байсан ч гэсэн хүүхдийн төрсөн нэрийг бичнэ. Хэрэв хэн болох нь мэдэгдэхгүй байсан бол үрчлэлтийн захирамжийн хуулбарыг авах боломжтой боловч таниулах дэлгэрэнгүй мэдээлэл нь зөвхөн үрчлэгчтэй холбоотой байх болно.

Энгийн үрчлэлтээр хүүхэд болон үрчлэлтийн бусад талууд нь төрсөн эцэг, эхийн хэн болохыг харуулсан холбогдох албан ёсны баримт бичиг (жишээ нь төрсний гэрчилгээний бүрэн хуулбар) авах эрхтэй бөгөөд төрсний гэрчилгээний эх хувийг хүчингүй болгохгүй. Төрсний гэрчилгээнд үрчлэгдсэн баримт, үрчлэгчийн биеийн байцаалт бичигдэнэ. Гэсэн хэдий ч хууль ёсны ашиг сонирхолгүй хүмүүс үрчлэлтийн тухай (бүрэн эсвэл энгийн) баримт бичиг болон төрсөн эцэг эхийн хэн болохыг олж мэдэх боломжйүг. Эцэг эх нь төрөх үед нууцыг хадгалахыг албан ёсоор хүссэн бөгөөд энэ хүсэлтээс албан ёсоор татгалзаагүй бол төрсөн эцэг эхийн хэн болохыг үрчлэгдсэн хүүхдэд задруулахгүй. Үрчлэгдсэн хүүхдүүд болон тэдний төрсөн эцэг, эхийн мэдээллийг олж тогтоох хүсэлтийг тодорхойлох, төрөл төрөгсдийг хайж олоход туслах эрх бүхий үндэсний төрийн байгууллага болсон. Энэхүү хууль тогтоомж нь өргөдөл гаргагчийг төрсөн эхтэйгээ холбоо тогтоох боломжийг бүрдүүлдэг байна. Хувь хүмүүст өөрсдийнхөө гарал үүслийн талаарх мэдээллийг олж авах боломжгүй болно.

3. Герман улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт

I. Үрчлэлтийн эх сурвалж

Герман улс 1973 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1966 оны олон улсын фактыг зөвшөөрч, 1976 онд мөрдөж эхэлсэн, 1992 оны хоёрдугаар сард Хүүхдийн эрхийн тухай конвенцыг мөрдөж эхэлсэн. ХБНГУ 2015 онд Хүүхэд үрчлэн авах тухай Европын шинэчилсэн конвенц, 2002 онд Гаагийн конвенцыг соёрхон баталсан. Энэ нь Гаагийн конвенцыг Үрчлэлтийн зуучлалын тухай хууль, Үрчлэлтийн конвенцыг хэрэгжүүлэх тухай хуулиар улс хооронд үрчлүүлэх, үндэсний төв байгууллагуудын хамтын ажиллагаатай холбоотой; болон гадаадын үрчлэлтийн тушаалыг хүлээн зөвшөөрөх асуудлыг зохицуулдаг. ХБНГУ-ын хувьд улсын хувьд улс хоорондын үрчлэлтийн харилцаанд дараах хууль, журмыг баримталдаг. Үүнд:

Иргэний хууль (Gesetzbuch) - Хүүхдийг үрчлүүлэхтэй холбоотой заалтуудыг 1741–1766-д багтаасан бөгөөд дараах асуудлууд орно. Үүнд: зөвшөөрөл, үрчлүүлэх боломжтой байдал, үрчлэлтийн тушаалын үр нөлөө, болон үрчлэлтийг хүчингүй болгох. Насанд хүрэгчдийн үрчлэлтийн асуудлыг 1767-1772-д илүү товч тусгасан байна

Гэр бүлийн асуудлаарх журам 2009 он - Энэхүү хууль тогтоомжоор үрчлэлтийн асуудал Гэр бүлийн шүүхэд харьяалагдана.[97] Мөн үрчлэлтийн хэргийн шүүх хуралдааны зохицуулалтыг тусгасан байна.

Үрчлэлтийн зуучлалын тухай хууль 1976 он - Хүүхэд үрчлэн авахтай холбоотой талуудад зөвлөгөө өгөх, үрчлэн авах өргөдөл гаргагчдыг шалгах, хүүхэд үрчлэн авах шийдвэр

[97] The Procedure in Family Matters Act, 2009, s 1, 111 No.4, 186ff

гаргах, үрчлэн авсны дараа асрах болон зөвлөх, үрчлэн авах үйл ажиллагаанаас эхлээд үрчлэлттэй холбоотой зохицуулалтын бүх асуудлыг тусгасан болно. Үүнд: Үрчлэлтийн агентлагийн чиг үүрэг, магадлан итгэмжлэл, мэргэжлийн боловсон хүчний үүрэг, зар сурталчилгаа уриалгатай холбоотой хориг, үрчлэлтийг дэмжих үйлчилгээ болон мэдэгдлийн үүрэг хамаарна.

Хүүхэд залуучуудын үйлчилгээний тухай хууль 1991 он - Хүүхэд залуучуудын үйлчилгээний тухай хууль (Kinder und Jugendhilfegesetz) нь Нийгмийн хуулийн 8-р номд тусгагдсан болно. 11-42-р хэсэг нь эмзэг бүлгийн гэр бүлүүдийг дэмжиж, хүүхдүүдийг хамгаалж, гэр бүлдээ үлдэх боломжгүй хүүхдүүдийг асрах зохицуулалтаар хангадаг орон нутгийн Залуучуудын үйлчилгээний халамжийн газрын үйлчилгээ үзүүлэх үүргийг зохицуулдаг. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүүхэд үрчлэхийг асрамжийн асаргаанаас илүүд үзэх ёстойг тодорхойлсон байна. 51-р зүйлд орон нутгийн Залуучуудын халамжийн газраас төрсөн эцэг эх болон үрчлэлтэд оролцож буй хүүхдүүдэд зөвлөгөө заавар өгөх, дэмжлэг үзүүлэх үүргийг тусгайлан тусгасан.

Эцэг эхийн тухай хуулийн шинэчлэлийн тухай хууль 1998 оны долоодугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн энэхүү хуулийн нэг үр дагавар нь үрчлэгдсэн хүүхдэд эцэг, эхийнх нь төрсөн хүүхдийн адил эрх зүйн статус олгодог байна. Гэсэн хэдий ч үндсэндээ уг хуулиар гэр бүлгүй хүүхдийн эцгийн эрх зүйн байр суурийг бэхжүүлж, хүүхдээ үрчлэн авахдаа төрсөн эцэг эхийн аль алиных нь зөвшөөрлийг авдаг байна.[98]

Асран хамгаалагчийн тухай хууль 1997 он - 1998 оны 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн хууль нь "хууль ёсны бус хүүхдийг асран хамгаалах эцэг эхийн эрхийн хэмжээг тодорхойлсон".[99]Энэ нь эхэд нь эцэг нь хүүхэдтэйгээ холбоотой ямар нэгэн эрх хүсэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдээ үрчлүүлэхийн тулд эрхээсээ татгалзах онцгой эрх олгосон байна.[100]

II. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг

Мужуудын үрчлэлтийн төв байгууллагууд (Länder) дараах асуудлыг хариуцдаг. Үүнд: Бие даасан үрчлэлтийн агентлагуудын бүртгэл ба хяналт; ажилтнуудын сургалтыг зохион байгуулах; мөн тохирох байршлыг тодорхойлоход хялбар болгохын тулд байрлуулахад хэцүү хүүхдүүдийн бүс нутгийн жагсаалтыг хөтлөх. Тэд мөн улс хоорондын хүүхэд үрчлэх үйл ажиллагаа явуулж, Гаагийн конвенцын зорилгоор төв байгууллагын үүрэг гүйцэтгэдэг байна.

Улс хоорондын үрчлэлтийн тухайд Холбооны Ерөнхий Прокурор нь Гаагийн конвенцын зорилгоор томилогдсон үндэсний төв удирдлагын (Bundeszentralstelle für Auslandadoption) үүрэг гүйцэтгэдэг бол Германы 16 муж тус бүр улс хоорондын үрчлэлтийг хянан шийдвэрлэх өөрийн буюу хамтарсан Төв эрх бүхий байгууллагуудыг байгуулсан.[101] ХБНГУ-д үрчлэлтийн асуудал хариуцсан холбооны зохицуулах төв

[98] The Parentage Law Reform Act 1997, s 1747 1.
[99] Frank., R., 'Germany: Parentage Law Reformed', in Bainham, A. (ed), The International Survey of Family Law, Martinus Nijhoff, The Hague, 1997, pp. 167–182, at p. 167.
[100] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 627

[101] Adoptionsvermittlungsgesetz https://dejure.org/gesetze/AdVermiG

байгууллага байдаггүй. Уг процесс нь шүүхийн шинж чанартай бөгөөд шүүхийн шийдвэрээр шийддэг байна. Гэр бүлийн шүүх (Familiengericht) бүх өргөдлийг Германы Иргэний хуулийн ss 1741–1772 (Bürgerliches Gesetzbuch) болон Гэр бүлийн харилцааны тухай хуулийн (Familienverfahrensgesetz) дагуу шийдвэрлэдэг. Давж заалдах гомдлыг дүүргийн дээд шүүх (Oberlandesgericht), цаашлаад холбооны шүүхэд (Bundesgerichtshof) гаргадаг. Шүүх нь төрсөн эцэг эх, тэдний гэр бүлийн талаарх бүрэн тайланг шаардах эрхтэй. Энэ нь хүүхдээс сайн дурааараа татгалзсан шалтгаан, нөхцөл байдлыг шийдвэрлэх шаардлагатай эсхүл санал болгож буй үрчлэлтийг зөвшөөрөхөөс татгалзсан шалтгааны бүрэн тайлбар байх ёстой. Тайлан нь төрсөн эцэг эхэд өгсөн аливаа мэдээлэл эсвэл зөвлөгөөний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байх ёстой. ХБНГУ-д үрчлэлтийн үйл явц үндсэндээ зөвшилцлийн шинж чанартай байдаг тул шүүхээс төрсөн эцэг, эхийн асран хамгаалах эрхийг цуцалсан ч бүх талууд зөвшөөрсний дараа үрчлэлтийн үйл ажиллагаа явагдана.[102]

Үрчлэлтийн Агентлагууд*:* Үрчлэлтийг төрийн үйлчилгээ гэж үздэг тул үрчлэлтийн бүх агентлаг нь Залуучуудын халамжийн газар эсвэл мужуудын (Länder) үрчлэлтийн төв байгууллага, зарим нь төрийн итгэмжлэгдсэн байгууллага болно. Улс хоорондын үрчлэлтийн үйл ажиллагаа явуулж буй агентлаг холбогдох түнш орнуудад тусгай магадлан итгэмжлэл авах шаардлагатай. Үрчлэлтийн агентлагийн үүрэг, чиг үүргийг үрчлэлтийн зуучлалын тухай хуулиар (Adoptionsvermittlungsgesetz) тодорхойлсон бөгөөд бүх агентлаг бүртгэлтэй мөн төрийн хяналтад байх ёстой. Агентлаг бүр дор хаяж хоёр үрчлэлтийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтантай байх ёстой. Агентлагийн үүрэгт дараах зүйлс орно: зөвлөгөө өгөх, түүнчлэн эмнэлгийн, сэтгэл зүй, сэтгэцийн болон хууль эрх зүйн туршлага, байршуулах болон үрчлэлтийн дараах тусламж үйлчилгээний туршлага. Үрчлэлтийн агентлагууд үрчлэгдсэн хүүхэдтэй тасралтгүй холбоо барих дээр зөвшилцсөн тохиролцоо хийх гэж хичээх эсвэл ядаж хөгжлийн талаар байнгын мэдээлэл солилцох үүрэгтэй байна.

ХБНГУ-д үрчлэлтийн зуучлалын тухай хуулиар зөвшөөрөгдсөн, зохицуулсан хэд хэдэн бие даасан ашгийн бус үрчлэлтийн агентлагууд ажилладаг.[103] Улс хоорондын үрчлэлтийн үйлчилгээ нь бие даасан ашгийн бус үйлчилгээ юм. Үрчлэлтийн аливаа байгууллага нь мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн нийгмийн ажилтантай ажиллах ёстой.[104] Үрчлэлтийн агентлаг нь ирээдүйн үрчлэн авагчдын эрх бүхий байдал болон зохимжтой байдлыг үнэлж, олж мэдсэн зүйлээ гэрийн судалгааны тайланд оруулж зөвлөмжид заасан шаардлагын[105] дагуу шүүхэд өгнө.[106]

Үрчлэгдэгчийн хэн болохыг тогтоохтой холбоотой мэдээллийг хайж олоход нь туслах нь төрийн үйлчилгээний үүрэг гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн, холбогдох зөвлөгөө өгөх үйлчилгээг авах боломжтой бөгөөд үрчлэлтийн файлд хандах эрх олгохоос ч өмнө заавал хийх ёстой байна. Шаардлагатай зөвшөөрлийг авсан тохиолдолд үрчлүүлэх холбогдох байгууллага талуудын хооронд зуучлах, мэдээлэл солилцох, хувийн харилцаа

[102] The Civil Code, s 1666
[103] The Adoption Intermediation Act, s 2(2).
[104] Мөн тэнд s 3(2).
[105] The Recommendations, No 3.3.
[106] The Adoption Placement Act, s.7

холбоо тогтооход туслах үүрэгтэй. Үрчлэлтийн агентлагууд болон орон нутгийн Залуучуудын халамжийн газар хүсэлтийн дагуу үрчлэгдсэний дараа бүх талуудад байнгын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.[107] Бие даасан 12 агентлаг (Annerkannte Auslandsvermittlungsstelle) нь үрчлэлтийн зуучлалын тухай хуулийн 4(1)-д заасны дагуу олгогдсон тусгай зөвшөөрлөөр зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн байгууллага юм. Эдгээрт Олон улсын нийгмийн үйлчилгээ: Герман дахь салбар, Хүүхдэд зориулсан эцэг эх, Хүүхдэд туслах, AdA зэрэг байгууллагууд багтдаг. Тэд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд холбогдох мужуудын үрчлэлтийн төв байгууллага хяналт тавьдаг.

III. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур

Германд үрчлэн авах насны дээд хязгаар нь 18 байдаг ч насанд хүрсэн хүнийг үрчилж болно.[108] ХБНГУ-ын хуулиар эцэг эх хоёулаа асран хамгаалагчаа хуваалцахыг зөвшөөрөөгүй тохиолдолд гэрлээгүй хосын хүүхдийг асран хамгаалах бүрэн эрхийг ээжид нь даатгадаг.[109] Гэсэн хэдий ч, хүүхдийн эцгээс өөр хүнтэй гэрлэсэн тохиолдолд эцэг нь тодорхойгүй, эсвэл эцэг нь гэж бүртгүүлээгүй бол эцгийн зөвшөөрөл шаардлагатай байна.[110] Төрсөн эцэг эх хоёулаа гэрлэлтийн байдал, хүүхэдтэй хамт амьдардаг эсэхээс үл хамааран хүүхдийнхээ үрчлэлтийг зөвшөөрөх ёстой. Зөвшөөрлийн шаардлага нь эцэг эхийн эрхээс хамааралгүй байдаг. Иймээс төрсөн эцэг эх хоёулаа гэрлээгүй, эсвэл шүүхийн шийдвэрээр эцэг эх байх эрхээ хасуулсан ч гэсэн зөвшөөрөх ёстой. Хамтран үрчлэх нь зөвхөн эхнэр, нөхөр хоёрын хувьд боломжтой, бүртгүүлсэн хамтран амьдрагчид хосын хувиар үрчлэлт хийж болохгүй. Гэхдээ хосын нэг гишүүн дангаараа үрчилж болно.[111] Насанд хүрсэн хүний хувьд үрчлэгдэгч нь гэрлэсэн хүн бол эхнэр, нөхрийнх нь зөвшөөрөл шаардлагатай.[112] Герман бус хүмүүс Герман хүүхэд үрчлэн авч болно. Ирээдүйн үрчлэлт нь дагавар хүүхэдтэй холбоотой бол 21 нас хүртэлх насны доод хязгаарыг зөвшөөрнө. Дагавар хүүхэд үрчлэн авах тохиолдолд "нөгөө" төрсөн эцэг эх нь, түүнчлэн эхнэр, нөхөр эсвэл бүртгүүлсэн хамтрагчийн зөвшөөрөл байх ёстой.[113] Зөвлөмжид үрчлэн авагчийн сэдэл, гэр бүлийн динамик байдал, хүүхдийн сайн сайхны ашиг сонирхол, гэр бүлийн шинэ нэгжийн тогтвортой байдлыг сайтар үнэлэхээр зохицуулсан байна.[114] Гэрлээгүй, ганц бие хүмүүс, түүнчлэн гэрлээгүй хосын нэг гишүүн, түүний дотор иргэний хамтрагчийн бүртгэлтэй хүмүүс (Lebenspartnerschaft) хүүхэд үрчилж авах боломжтой. Гэрлэсэн (гетеросексуал эсвэл ижил хүйстэн) хосууд зөвхөн хамтран үрчлэх боломжтой.[115] Дагавар хүүхдийг төрсөн эцэг эхийн аль нэгнийх нь шинэ хамтрагч, үрчлэн авагч болон эцэг эх нь гэрлээгүй байсан ч[116] нөгөө төрсөн эцэг эх нь тодорхойгүй эсхүл байхгүй, эсхүл үрчлэн авахыг зөвшөөрсөн тохиолдолд үрчилж авч болно.

---

[107] Adoption Intermediation Act 1976, s 9
[108] Civil Code, s 1743

[109] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 623
[110] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 624
[111] The Registered Partnership Act, s 9(6) 1.
[112] Мөн тэнд
[113] Мөн тэнд s 1749(1).
[114] The Recommendations, No 3.43.
[115] Civil Code, s 1742.
[116] Civil Code, s 1766a.

IV. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага

Хүүхдийн хувьд үрчлэлтийн үйл явцыг олон нийтийн (Залуучуудын халамжийн газар) эсвэл хувийн үрчлэлтийн агентлагууд хариуцдаг. Үйлчилгээ үзүүлэгчдийн аль аль нь насанд хүрээгүй хүүхдийн үрчлэлтэй холбоотой ямар ч тохиолдолд өргөдөл гаргагчийг үнэлэх, гэрийн судалгааны тайланг шүүхэд өгөх зэргийг хариуцдаг. Хүүхдийн насны дээд хязгаар нь 18 насны төрсөн өдөр юм. Хуулийн дагуу тухайн хүүхдийн сайн сайхны ашиг сонирхолд хамаарах бүх асуудлаар, түүний дотор тэдний гарал үүслийн талаарх мэдээллийг бүрэн эхээр нь шүүхэд өгөхийг шаарддаг.[117] Хүүхдийн зөвшөөрөл нь түүнийг үрчлэн авах урьдчилсан нөхцөл[118] боловч үүнийг хэрхэн олгохыг зохицуулах дүрэм журам нь маш нарийн байдаг. Жишээлбэл: Хүүхэд бие даан зөвшөөрөл өгөх эрхгүй, тэд асран хамгаалагчийн хамт байх ёстой[119]; хэрэв хүүхэд 14 нас хүрээгүй эсвэл эрх зүйн чадамжгүй бол түүний асран хамгаалагчийн зөвшөөрөл шаардлагатай.[120] 14 ба түүнээс дээш насны хүүхэд зөвшөөрөл өгөх эрхтэй боловч асран хамгаалагч нь л зөвшөөрсөн тохиолдолд болно.[121] Гэсэн хэдий ч 3 жилийн дотор үрчлэлтийн тушаал гараагүй тохиолдолд эцэг эхийн олгосон зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдал үгүй болдог.[122]

Тээгч эх: Германд тээгч эхийн асуудлыг маш хязгаарлагдмал хуулиар зохицуулдаг. Үр хөврөлийг хамгаалах хууль (Embryonenschutzgesetz) нь өндөг хандивлах болон үр хөврөлийн манипуляци эсвэл шилжүүлэх бусад хэлбэрийг хориглодог. Энэ нь тээгч эхийн гэрээний дагуу хүүхдээ төрөхөөр нь захиалагч эцэг эхэд нь хүлээлгэн өгөх хүсэлтэй эмэгтэйд хиймэл үр суулгалт, үр хөврөл хандивлахыг ямар ч эмч хийж болохгүй гэж заасан. Хүүхэд үрчлэн авах тухай хуульд хэн ч тээгч эхийг ирээдүйн захиалагч эцэг эхтэй зуучлах ёсгүй, ийм хүмүүсийг уулзуулахыг зорьж буй зар сурталчилгааг хориглоно гэж заасан. Германы хуулиар хүнийг гэрээний субъект болгохыг хориглоно: Хүүхдийн эх нь тухайн хүүхдийг төрүүлсэн эмэгтэй юм. Тиймээс зөвхөн тээгч эхийг хүүхдийн эх гэж хүлээн зөвшөөрдөг.[123]

V. Үрчлэлтийн дараах хяналт

ХБНГУ-д хүүхэд үрчлэгдсэний дараах хяналт нь үрчлэгдсэн хүүхдүүдийн сайн сайхан байдал, хөгжлийг хангах тус улсын үрчлэлтийн тогтолцооны чухал хэсэг болдог. Үндсэн зорилго нь үрчлэгдсэн хүүхдүүдийг аюулгүй хүмүүжлийн орчныг бүрдүүлж, шинэ гэр бүлтэй нь нэгтгэхэд нь дэмжлэг үзүүлэх явдал юм. ХБНГУ-д хүүхэд үрчлүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн агентлагууд ихэвчлэн хийдэг. Эдгээр агентлагууд үрчлэгдсэний дараах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүнд гэрээр судлах, зөвлөгөө өгөх, үрчилж авсан гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Үрчлэлтийн асуудлыг эцэслэхээс өмнө үрчлэлтийн агентлагууд үрчилж авах эцэг эхийн хүүхдэд аюулгүй, хайраар дүүрэн орчныг бүрдүүлэх чадварыг үнэлэхийн тулд гэрийн судалгаа хийдэг. Энэхүү үнэлгээнд гэр бүлийн амьдралын нөхцөл, санхүү, хүүхэд

[117] Personenstandsgesetz, s 45.
[118] The Civil Code, s 1746(1) 1.
[119] Мөн тэнд s 1746(1) 3.
[120] Мөн тэнд s 1746(1) 2.
[121] Мөн тэнд s 1746(2)
[122] Мөн тэнд s 1750(4) 2
[123] Kerry O'Halloran "The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition", White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 618

хүмүүжүүлэх ур чадварыг үнэлэх зэрэг багтана. Хүүхэд үрчилж авахаар төлөвлөж буй эцэг эхчүүдэд хүүхэд үрчлүүлэхэд тулгарч буй бэрхшээл, үүрэг хариуцлагад бэлтгэхийн тулд зөвлөгөө, сургалтад хамрагддаг. Хүүхэд үрчлүүлсний дараа гэр бүлд гарч болзошгүй аливаа асуудлыг шийдвэрлэхэд нь туслах зорилгоор эдгээр үйлчилгээг ашиглах боломжтой хэвээр байна. Үрчлэлтийн дараах хяналт нь үрчлэлтийн агентлагууд болон үрчлэгдсэн гэр бүлийн хооронд тогтмол зочлох, харилцах явдал юм. Нийгмийн ажилтан эсвэл үрчлэлтийн мэргэжилтнүүд гэрт нь очиж, гэр бүлийн гишүүдтэй ярилцлага хийж, хүүхдийн сайн сайхан байдлыг үнэлдэг. Ерөнхийдөө Германд үрчлэгдсэний дараах хяналт нь үрчлэгдсэн хүүхдүүд шинэ гэр бүлдээ өсч хөгжих, шаардлагатай дэмжлэгийг авч, аз жаргалтай, эрүүл хүүхэд наслах боломжийг бүрдүүлэх зорилготой юм. Энэ нь үрчлэгдсэн хүүхдүүдийн сайн сайхан байдлыг дэмжихийн тулд үрчлэгдсэн гэр бүлүүдэд гарч болзошгүй аливаа бэрхшээлийг шийдвэрлэх, тусламж, эх үүсвэрээр хангах зорилготой юм.

VI. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

Германы үрчлэх тухай тушаал нь онолын хувьд байнгын бөгөөд эргэлт буцалтгүй байдаг. Гэсэн хэдий ч үрчлэлт нь анхнаасаа хууль зүйн хувьд алдаатай байсан бол үүнийг хүчингүй болгож болно. Тухайлбал: Зөвшөөрлийн мэдүүлгийг буруугаар, дарамт шахалт дор эсвэл талуудын аль нэгнийх нь эрх зүйн чадамжгүйн улмаас гаргасан бол,[124] тухайн алдааг засаагүй бол,[125] хүүхдийн сайн сайхны эрх ашгийг[126] ноцтойгоор хохироохгүй байх нөхцөлийг бүрдүүлэн цуцлах бөгөөд үрчлэлтийн зарлиг гарснаас хойш гурван жилийн дотор[127] хохирогч тал гомдол гаргах үүрэгтэй.[128] Герман улсад үрчлэлтийн тушаалын онцгой шинж чанар нь гэр бүлийн шүүх уг захирамжийг өөрийн үзэмжээр, оролцогч талуудын аль нэгний санаачилгагүйгээр хүчингүй болгож болно.[129] Үрчлэлтийн тушаал нь хосуудын талд гарсан бол зөвхөн аль нэгийнх нь хувьд хүчингүй болгож болно.[130] Мөн хэн нэгний санаачилгаар Үндсэн хуулийн цэц хүчингүй болгож болно. Үрчлэгдэгч хүүхдийн гэрлээгүй эцэг шүүхийн шийдвэр гарахаас өмнө шүүхээр хэлэлцүүлэх үндсэн эрх нь зөрчигдсөнийг нотлох баримттай гэх мэт тохиолдолд хүчингүйд тооцно.[131] Хүчингүй болгох нөхцөл нь төрсөн эцэг эх нь хүүхдээ асран хамгаалахад бэлэн, боломжтой байх эсвэл хүчингүй болгох зорилго нь шинээр үрчлүүлэхийг зөвшөөрөх юм.[132] Хүчингүй болгосны үр дагавар нь: хүчингүй болгох хүртэл[133] үрчлэлтийн хууль зүйн үр дагаврыг хэвээр үлдээх үүрэгтэй. Үүний дараа хүүхэд болон тэдний төрсөн гэр бүлийн хоорондын харилцааг сэргээхийн зэрэгцээ үрчлэн авагчид болон тэдний гэр бүлтэй хууль ёсны бүх харилцааг таслах.[134] Төрсөн эцэг эхийн зөвшөөрөл шаардлагатай боловч хүүхэд төрснөөс хойш 8 долоо хоногоос доошгүй хугацаанд зөвшөөрөгдсөн тохиолдолд л хууль ёсоор хүчин төгөлдөр байна.[135]Харин гэрлээгүй эцгийн зөвшөөрөл нь төрөхөөс өмнө өгсөн байсан ч хүчинтэй. Зөвшөөрөл ихэвчлэн ирээдүйн үрчлэн авагчдын хувийн мэдээллийг

[124] The Civil Code s 1759
[125] Мөн тэнд s 1760(1) and (2).
[126] Мөн тэнд s 1761(2).
[127] Мөн тэнд s 1762(2) 2.
[128] Мөн тэнд s 1762(2) 1.
[129] Мөн тэнд s 1763(1)
[130] Мөн тэнд s 1763(2).
[131] The Federal Constitution, Basic Law, Article 103.
[132] The Civil Code, s 1763(3).
[133] Мөн тэнд s 1764(1).
[134] The Civil Code s 1764(2) and (3).
[135] Мөн тэнд The Civil Code, s 1747(2) 1.

задруулахгүйгээр олгогддог боловч энэ нь тодорхой хүн эсвэл хосуудад хамаарах ёстой. Эцэг эхийн зөвшөөрөл авах боломжгүй дараах тохиолдол байна. Үүнд: Хүүхдийн эцэг эх нэрээ нууцалсан, (*Vertrauliche Geburt*), , эцэг эхийн зан үйлийн улмаас зөвшөөрөл олгох эрх нь хасагдсан гэх мэт тохиолдолд боломжгүй болно.

Төрсөн эцэг, эх нь нас барсан, сэтгэцийн эмгэгийн улмаас тахир дутуу болсон, эсвэл хаана байгаа нь тодорхойгүй бол шүүх тэдний зөвшөөрлийг үгүйсгэж болно.[136] Хүүхдийг хүчирхийлсэн, хайхрамжгүй хандсан, хаясан, нэг жилээс дээш хугацаанд санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй зэрэг хэргээр шийтгэгдсэний дараа төрсөн эцэг, эхийн асран хамгаалах эрх нь дуусгавар болсон тохиолдолд үүнийг хийж болно.[137] Түүнчлэн, төрсөн эцэг эх нь хүүхдийнхээ сайн сайхан байдалд хайхрамжгүй хандсан боловч хүчирхийлсэн, хаясан гэм буруугүй бол тэдний эрхийн талаар зөвлөгөө өгснөөс хойш гурван сарын дараа зөвшөөрөл авах шаардлагагүй болно.[138] ХБНГУ-д үрчлүүлэх зөвшөөрөл нь эцэг эхийн төрөлхийн эрх бөгөөд эцэг эхийн аливаа асран халамжлах үүргээс эрс ялгаатай байна.

VII. Байршуулахын үйл ажиллагааны зохицуулалт

Үрчлэлтийн байршуулалт хийх эрх мэдлийг Үрчлэлтийн зуучлалын тухай хуульд зөвхөн мэргэжлийн хүмүүс хийх ёстой гэж заасан байдаг.[139] Үрчлэлтийн үйл явцад холбогдох мэргэжилтнүүдийн нарийн нийцсэн үнэлгээ хийж,[140] үрчлэн авагчид хүүхдийг харах, мөн зарчмын хувьд тохиролцсоны дагуу хүүхдийн гарал үүсэлтэй холбоотой бүх мэдээллийг бүрэн илчилсний дараа л болдог. Бүх талууд нээлттэй үрчлэлтийг дэмжиж байгаа тохиолдолд хүүхдийн төрсөн эцэг эх нь хүүхдийг дор хаяж 8 долоо хоногтой болтол нь хүчин төгөлдөр зөвшөөрөл өгөх боломжгүй байсан ч үрчлэлтийн агентлаг хүүхэд төрсний дараа шууд эмнэлгээс байршуулах ажлыг хөнгөвчлөх боломжтой.[141]

Үрчлэлтийн байршуулалтыг ихэвчлэн магадлан итгэмжлэгдсэн бие даасан үрчлэлтийн агентлагууд эсвэл орон нутгийн Залуучуудын халамжийн газар хийдэг. Тус бүр дотоодын үрчлэлтийг хариуцдаг. Улс хоорондын байршуулалтыг[142] мужуудын Үрчлэлтийн төв байгууллага эсвэл Гаагийн конвенцын дагуу төв байгууллагын үүрэг гүйцэтгэдэг тусгай итгэмжлэгдсэн байгууллагуудаар дамжуулан зохион байгуулагддаг. Үрчлэлтийн агентлаг эсвэл магадлан итгэмжлэгдсэн байгууллага хүүхдийг байршуулсны дараа байршуулалтын статусыг асрамжийн газрын байршуулалт(Adoptionspflege) гэж хуулиар тодорхойлдог байна. Туршилтын үрчлэлтийн байршуулалт (Adoptionspflege) нь хуулийн[143] дагуу үрчлүүлэх өргөдөл гаргах урьдчилсан нөхцөл бөгөөд үйл явц нь дотоодын эсвэл улс хоорондын шинж чанартай байснаас үл хамаарна. Холбогдох мэргэжилтнүүд үүнийг "туршилтын" гэх бус харин эмчилгээний чанартай дасах хугацаа гэж үздэг.[144] Энэ хугацаанд зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурах, хүүхдийн асрамжийн тухай шийдвэр гаргахаас эхлээд үрчлэлтийн өргөдлийг шүүх шийдвэрлэх хүртэл эцэг эх

[136] Мөн тэнд s 1747(4).
[137] Мөн тэнд s 1748(1) 1 and 2.
[138] Мөн тэнд s 1748(2) 1 and the Code of Social Law (Sozialgesetzbuch), Vol VIII, s 51(1).
[139] The Civil Code, s 2(1).
[140] The Recommendations, No 4.
[141] The Civil Code, s 1747, para 3.
[142] Мөн тэнд s 2a(4).
[143] Мөн тэнд s 1744
[144] The Recommendations, No 4.4.

байх эрхийг түдгэлзүүлдэг. Орон нутгийн Залуучуудын халамжийн алба нь асран хамгаалагчийн үүргийг хариуцдаг. Тодорхой хугацааны хязгаарлалт байхгүй: үргэлжлэх хугацаа нь хүүхэд дасах, гэр бүлийн динамик ирээдүйд тохирсон эсэхийг батлахад шаардагдах хугацаанаас хамаарна. Туршилтын хугацаа дуусмагц хяналтын агентлаг нь шинээр ирж буй гэр бүлийн динамикийг нарийвчлан тодорхойлсон үнэлгээний тайланг Гэр бүлийн шүүхэд өгөх ёстой. Байршуулалт тасарсан тохиолдолд шүүхэд мэдэгдэх ёстой бөгөөд энэ нь хүүхдэд хамгийн бага хор хөнөөлтэй өөр асран хамгаалах зохицуулалтыг тогтоох ёстой. Нэг хувилбар нь төрсөн эцэг эхийн асран хамгаалах хариуцлагыг сэргээх байж болно.[145]

VIII. Үрчлэлтийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Үрчлэгчид болон хүүхдэд байнгын дэмжлэг шаардлагатай гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрч,[146] тэдний гэр бүл, олон нийтийн хэвийн үйлчилгээнд бүрэн хамрагдах эрхийг тайлбарлаж, хөнгөвчлөх үүрэгтэй.[147] Дэмжлэгт нь орон нутгийн болон үндэсний үрчлэлтийн сүлжээ, дэмжлэг үзүүлэх бүлгүүдийн холбоо барих мэдээллээр хангах, тэдэнтэй харилцах зэрэг болно. Ерөнхийдөө Германы эрх баригчид агентлагуудыг үрчлэн авагч гэр бүл болон төрсөн эцэг эхийн хоорондын харилцаа холбоог хөнгөвчлөх, хүүхдийн хөгжлийн талаар мэдээлэл өгөх, гэрэл зураг солилцох зэрэгт туслахыг дэмждэг.[148] Дотоодын үрчлэлтийн системийг бүхэлд нь төрөөс санхүүжүүлдэг. Эцэг эхчүүд зөвхөн ар гэрийн шинжилгээ, эрүүл мэндийн үзлэгт зориулж бага хэмжээний төлбөр төлдөг. Үрчлэлтийн дараах дэмжлэгийн үйлчилгээг төрийн үйлчилгээний эрх гэж үздэг. Үрчлэн авагчид, хүүхэд, төрсөн эцэг эх холбогдох үрчлэлтийн агентлаг эсвэл орон нутгийн Залуучуудын халамжийн газраас зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээг авах эрхтэй.

IX. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

ХБНГУ-ын Үндсэн хууль нь мэдээллийн эрхийн тал дээр хамгаалагдсан байдаг. Энэ нь хувь хүн өөрийн онцлог зан чанарыг хөгжүүлэх үндсэн эрхтэй гэдгийг баталж байгаа боловч, бусдын эрх, нийтийн ёс суртахууныг зөрчихгүй байх үүрэгтэй байна.[149] Хүүхдээ нэрээ нууцлан, ямар ч мэдээлэл үлдээхгүйгээр орхих эхийн эрхэд хамаарах нууцыг хамгаалах эрх хязгаарлагдмал. Хэдийгээр эх нь хүүхдээ төрөх үед (Vertrauliche Geburt) нэрээ нууцалсан байсан ч дараа нь 16 нас хүрсэн хойно хувь шинжийн мэдээлэлд нь (Herkunftsnachweis) нэвтрэх эрхтэй.[150] Холбооны Үндсэн хуулийн шүүх хүн бүр өөрийн биологийн гарал үүслийг мэдэх үндсэн хуулиар олгогдсон эрхийг баталгаажуулсан.[151] 16 ба түүнээс дээш насны үрчлэгдэгчид үрчлэлтийн баримт бичиг (хэрэв 16 нас хүрээгүй бол үрчилж авсан эцэг эх нь үрчлэгдэгчийн хууль ёсны төлөөлөгчийн хувьд нэвтэрч болно)[152] болон өөрийнх нь гарал үүсэлтэй холбоотой баримтуудыг тэмдэглэсэн улсын бүртгэлд нэвтэрч болно.[153] Түүнчлэн, агентлагууд үрчлэлтийн тушаал гарахаас өмнө болон дараа нь

[145] The Code of Procedure in Non-Contentious Matters, section 49, para 1, No 1 m.
[146] The Recommendations, No 4.4.
[147] The Social Code, VIII, ss 27–41.
[148] Adoption Intermediation Act, ss. 8a, 8b and 9.
[149] The Federal Constitution, Basic Law, Article 2.

[150] Pregnancy Conflict Act, s 31.

[151] Decision of the German Constitutional Court, BVerfGE 79, 256; FamRZ 1989, 255.
[152] The Adoption Intermediation Act, s 9b(2)
[153] Personal Status Act (Personenstandsgesetz), s 61(2) 1.

нээлттэй байх боломжийг судлах үүрэгтэй байна.Үрчлэгдэгчийн төрсөн эцэг эхийн мэдээллийг хэн гэдгийг нь олж авах эрхийг хуулиар[154] олгосон. Үрчлэгдэгчийн эцэг эх, ах, эгч нарын амьдралын талаарх мэдээллийг зөвхөн холбогдох төрсөн эцэг, эх, ах, эгч нарын сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр л зөвшөөрнө. Үрчлэлтийн талууд дараах мэдээллүүдийг авах эрх нь харилцан адилгүй байдаг. Төрсөн гэр бүлийн гишүүдийн хайж буй үрчлэгдэгчийн талаарх мэдээллийг агентлаг задруулах нь үрчлэгдэгч болон үрчлэн авагчийн зөвшөөрлөөс бүрэн хамаарна. Харин үрчлэгдэгч үрчлэлтийн баримт бичиг болон өөрийн хувийн бүртгэлтэй танилцах эрхтэй. "Мэдээлэл хайж буй" үрчлэгдэгчид зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэг хариуцлага нь зөвхөн хуулиар тогтоогдоод[155] зогсохгүй Германы үрчлэлтийн агентлагуудын орчин үеийн ажлын гол хэсэг болсон. Тэд мөн үрчлэгдсэн хүмүүс болон тэдний төрсөн гэр бүлийн хоорондох үрчлэлтийн дараах харилцааг урамшуулж, дэмжиж, үрчлэгдсэн төрөл төрөгсдөө "хайж" байгаа төрсөн эцэг эх, ах эгч нарынх нь холбоо тогтоох үйл ажиллагааг хөнгөвчилдөг болно.

4. Америк улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт

I. Үрчлэлтийн эх сурвалж

Америк улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1995 оны 2 дугаар сарын 16-ний өдөр нэгдэн орсон. Гаагийн конвенцод 1994 оны 3 дүгээр сарын 31-ны өдөр нэгдэн орж , 2007 оны 12 дугаар сарын 27-ний өдрөөс соёрхон баталсан. Америк улсын хувьд хүүхэд үрчлэлтийн харилцаанд дараах хууль, журмыг баримталдаг байна.

- 1851 оны Массачусетсийн Хүүхдийг үрчлэх тухай хуулиар АНУ-д үрчлэхийг албан ёсны хууль ёсны журам болгон нэвтрүүлсэн мөн үрчлэлттэй холбоотой хуулийн зарим үндсэн чиг үүргийг анх удаа тодорхойлсон.
- 1929 он гэхэд АНУ-н бүх мужууд Массачусетсийн жишээг дагаж, хүүхэд үрчлэх тухай хууль тогтоомжийн зарим хэлбэрийг баталжээ.
- 1891 онд Мичиган зэрэг зарим мужууд нэг алхам урагшилж, үрчилж авахаар төлөвлөж буй хүмүүс болон тэдний гэрийн нөхцөл байдлын талаар лавлагаа авах шаардлагатай хууль тогтоомжийг нэвтрүүлсэн. Үүний дараа үрчлэлт нь зөвхөн шүүхээр тогтоогдсон үйл явц болж, амжилттай дуусмагц үрчлүүлэх захирамж гарсан.
- 1917 онд Миннесота муж хүүхэд үрчлэлтийн талаарх (гэрийн судалгааг оролцуулан) нийгмийн мөрдөн байцаалтыг явуулах, үрчлэлтийн бүртгэлийн нууцлалыг хангах анхны хуулийг баталсан.
- 1919 онд Рассел Сэйж сан нь хүүхэд байрлуулах мэргэжлийн анхны гарын авлагыг хэвлүүлсэн; АНУ-ын Хүүхдийн товчоо хүүхэд байршуулах хамгийн наад захын стандартыг тогтоосон; Жесси Тафт "Хувь хүний судалгаа нь хүүхэдтэй болох харилцаа" гэсэн эмчилгээний үрчлэлтэд зориулсан анхны тунхаг бичиг зохиосон.
- 1958 онд Америкийн Хүүхдийн Халамжийн Лигээс Үрчлэлтийн стандартыг нийтэлсэн (1968, 1973, 1978, 1988, 2000 онд шинэчлэгдсэн);
- 1960 онд НҮБ-ын Ассамблей Цагаан ордны Алтан жилийн ойд зориулсан Хүүхэд залуучуудын бага хурлаар Хүүхдийн эрхийн тунхаглалыг баталсан.

[154] Adoption Intermediation Act, s 9b.
[155] Adoption Intermediation Act, s. 9 (2)

- 1994 онд Олон үндэстний байршуулах тухай хууль үрчлэлтийн асуудалтай холбоотой анхны холбооны хууль
- 1997 онд Үрчлэх ба аюулгүй гэр бүлийн тухай хууль батлагдсан. Хүүхдэд зориулсан байнгын төлөвлөлтийг онцлон тэмдэглэж, гэр бүлээ нэгтгэхээс татгалзаж, үрчлүүлэх бодлогод шилжихийг илэрхийлсэн.
- 2000 онд батлагдсан Хүүхдийн иргэний харьяаллын тухай хуулинд гадаадад төрсөн үрчлэгдэгчид АНУ-д ороходоо автоматаар Америкийн иргэн болохыг зөвшөөрч, олон улсын үрчлэлтийн иргэний харьяаллын хууль ёсны дарамтыг арилгасан.
- 2000 онд Улс хоорондын үрчлэлтийн акт. Энэхүү дотоодын хууль тогтоомж нь ICA-ийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
- 2012 онд Улс хоорондын үрчлэлтийн бүх нийтийн магадлан итгэмжлэлийн тухай хууль. 2014 оны 7-р сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон 2012 оны хууль нь Гаагийн конвенцод нэгдээгүй улс орнуудад төрсөн бүтэн өнчин хүүхдүүд, үрчлэн авах эцэг эх болон төрсөн эцэг эхчүүдэд Гаагийн магадлан итгэмжлэлээр олгодог хамгаалалтыг олгосон.
- 2013 онд Хүүхэд бүр гэр бүлтэй байх эрхтэй хууль. Энэхүү хууль тогтоомж нь холбооны санхүүжилт авдаг хүүхдийг асран хүмүүжүүлэх, үрчлэн авах асуудал эрхэлдэг аливаа байгууллага ижил хүйстний харилцаатай эсвэл ЛГБТ гэж тодорхойлсон тохиолдолд үрчилж авах хүсэлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглодог.
- 2018 онд гэр бүлийн анхны урьдчилан сэргийлэх үйлчилгээний тухай хууль. Энэхүү хууль нь холбооны хүүхдийн халамжийн санхүүжилтийг шинэчилсэн. Энэ нь муж улсуудад хүүхэд, гэр бүлд илүү их дэмжлэг үзүүлэхийн тулд холбооны санг ашиглах боломжийг олгодог бөгөөд ингэснээр хүүхдүүдийг төрийн асрамжийн системд хамруулах шаардлагагүй болно.

II. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг

АНУ-д үрчлэлтийн асуудлыг ихэвчлэн хүүхдийн халамжийн төрийн агентлагууд (магадлан итгэмжлэлийн шаардлагаас чөлөөлөгдсөн) эсвэл хувийн бие даасан байгууллага болох үрчлэлтийн агентлагууд зохион байгуулдаг. Аль ч тохиолдолд ийм агентлаг нь гэр бүлтэй байх хэрэгцээтэй хүүхдүүд болон үрчилж авах эцэг эхийн хоорондох холбоосыг хангадаг. Ийм маш олон байгууллагууд байдаг бөгөөд ойролцоогоор 1,552, үүнээс 192 нь улс хоорондын үрчлэлтийн асуудалд анхаарлаа хандуулдаг. Үрчлэлтийн агентлагууд өргөдөл гаргагчдыг үнэлж, зохих байршуулалтыг зохион байгуулж, шүүхийн өргөдлийг хянан шийдвэрлэдэг. Төрсөн эцэг эх нь агентлагт эцэг эх байх эрхээсээ татгалзсан тохиолдолд тэд ирээдүйн үрчлэн авагчийн хууль ёсны бүрэн хариуцлагыг хүлээнэ. Хүүхэд үрчлэн авах үйл явцад ийм байгууллагуудын гол байр суурь нь хуулийн хариуцлага дагалддаг.

Бие даасан болон сайн дурын үрчлэлтийн агентлагууд. Дотоодын хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд оролцож буй бүх хувийн хэвшлийн байгууллагууд тусгай зөвшөөрөлтэй байх ёстой бөгөөд хяналт, хугацааны давтамжит шалгалт, төрийн зохицуулалтын тогтолцоонд хамрагдах ёстой. Эдгээр агентлагуудыг төрийн хүүхдийн халамжийн хэлтэс асран хүмүүжүүлэх асрамжийн газарт хүүхдүүдийг байрлуулахад, мөн үрчлэн авахаар

тохиролцох хүсэлтэй ирээдүйн эцэг, эх болон үрчлүүлэх гэж буй эцэг эх ашиглаж болно. Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүүхэд үрчлэн авах бүх агентлагууд 2008-2019 он хүртэл Нью-Йорк хотод төвтэй ашгийн бус байгууллага болох Магадлан итгэмжлэлийн зөвлөл (COA)-өөр зохицуулагдаж, Төрийн департмент хянадаг. COA нь 2,200 орчим байгууллагыг магадлан итгэмжлүүлсэн бөгөөд хууль бус үйлдэл илэрсэн тохиолдолд магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах эрхтэй байв. Төрийн департментын дэргэдэх Гаагийн гомдлын бүртгэлийн газар нь үрчлэн авсан эцэг эхээс үрчлүүлэх агентлагийн талаарх гомдлыг хүлээн авдаг зохицуулалтын механизмын үүрэг гүйцэтгэдэг. Цаашилбал, Төрийн департамент үрчлэлтийн агентлагийн үйл ажиллагааг таслан зогсоох эрхтэй. Хувийн үрчлэлтийг агентлагийн чиг үүрэг нь:

- Хүүхэд үрчлэн авах үйл явцад төрсөн эцэг, эх, үрчлэн авсан эцэг эхчүүдэд туслах.
- Гэрийн судалгаа, үнэлгээ хийх.
- Төрсөн болон үрчилж авсан гэр бүлийн хооронд үрчлүүлэх ажлыг хөнгөвчлөх.

Хүүхэд үрчлэн авах төрийн байгууллагууд. АНУ-ын хүүхэд үрчлэн авах эрх бүхий байгууллага нь өөрийн харьяаллын хүрээнд хүүхэд үрчлэн авах үйл явцыг хянах, зохицуулах үүрэгтэй төрийн болон захиргааны байгууллагуудыг хэлдэг. Эдгээр эрх мэдэл нь муж улсаас хамаарч өөр өөр байдаг бөгөөд олон улсын үрчлэлтийн ажилд оролцдог холбооны агентлагуудыг багтааж болно.

- *Хүүхэд, гэр бүлийн үйлчилгээний газар (DCFS) эсвэл ижил төстэй төрийн агентлагууд.* Эдгээр агентлагууд нь тус тусын муждаа хүүхдийн халамж, үрчлэлтийн үйлчилгээг хариуцдаг. Тэдний чиг үүрэг нь:
  - Ирээдүйн үрчилж авах эцэг эхчүүдийг үнэлэхийн тулд гэрийн судалгаа хийх.
  - Үрчилж авах гэр шаардлагатай хүүхдүүдийг тохирох гэр бүлтэй нь тааруулах.
  - Үрчилж авсан гэр бүлүүдэд дэмжлэг, эх үүсвэрээр хангах.
  - Асрамжийн тогтолцоонд хяналт тавьж, асрамжийн газраас үрчлүүлэх.
- *Дүүргийн нийгмийн үйлчилгээ эсвэл Нийгмийн үйлчилгээний хэлтэс.* Мужийн түвшинд нийгмийн үйлчилгээний агентлагууд орон нутгийн үрчлэлтийн хэрэг, тэр дундаа асран хүмүүжүүлэгч үрчлэлтийн асуудлыг хариуцдаг үрчлэлтийн албатай байж болно.
- *Хүүхэд үрчлэн авах солилцооны хөтөлбөрүүд.* Зарим мужид үрчлэлтийн солилцооны хөтөлбөрүүд байдаг бөгөөд энэ нь үрчлэгдэхээр хүлээж буй хүүхдүүдийг үрчилж авах боломжтой гэр бүлүүдтэй холбож тусалдаг бөгөөд ихэвчлэн ахимаг насны хүүхдүүд болон тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд анхаарлаа хандуулдаг.
- *Улсын шүүхүүд.* Үрчлэлтийн ажиллагаанд шүүх чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд үрчлэлтийг батлах, эцэг эх байх эрхийг цуцлах, үрчлэн авах тухай тогтоол, захирамж гаргах үүрэгтэй. Шүүх засаглал нь АНУ-ын хүүхэд үрчлэн авах үйл явцад гол үүрэг гүйцэтгэдэг: хүүхэд үрчлэн авах өргөдлийн бүх сонсголыг шүүгчийн өмнө явуулдаг; Талуудын эрх, шаардлагатай зөвшөөрөл, хүүхдийн сайн сайхны ашиг сонирхол нь шүүхээр шалгах ёстой чухал асуудлуудын нэг юм. Шүүхийн үйл явц, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн шударга байдлын талаархи тойм нь

шүүх ажиллагаа болон үр дүн нь хүүхдийн сайн сайхны ашиг сонирхолд нийцэх хамгийн сайн баталгааг өгдөг.

- *Хүүхэд зуучлалын тухай улс хоорондын компакт (ICPC)-ийн алба.* Тус алба нь хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавьж, улс хоорондын үрчлэлтийн үед хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хамгаалдаг.
- *Холбооны агентлагууд.* АНУ-ын Иргэншил, Цагаачлалын алба (USCIS): Олон улсын үрчлэлтийн хувьд USCIS нь АНУ-ын иргэдэд үрчлэгдсэн хүүхдүүдэд цагаачлалын виз олгодог.
- *Төрийн департмент.* АНУ-ын Төрийн департамент нь олон улсын хүүхэд үрчлэлтийг зохицуулах, хяналт тавих, үүнд оролцогч орнуудыг Гаагийн үрчлэлтийн конвенцыг дагаж мөрдүүлэх үүрэг гүйцэтгэдэг.
- *Индианчуудын Хүүхдийн халамжийн тухай хууль (ICWA)-ын газрууд.* Америкийн уугуул хүүхдүүдтэй холбоотой тохиолдолд ICWA-ийн шаардлагыг дагаж мөрдөхийн тулд ICWA оффисууд оролцож болно.
- *Үрчлэлтийн тусламжийн хөтөлбөрүүд.* Ихэнхдээ төрийн байгууллагуудын удирддаг эдгээр хөтөлбөрүүд нь үрчлэн авсан гэр бүлүүдэд, ялангуяа тусгай хэрэгцээт хүүхдүүд үрчилж буй хүмүүст санхүүгийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

III. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур

АНУ-д хүүхэд үрчлэн авах үйл явцад оролцох шалгуурыг бүх мужид ижил төстэй хуулиар тогтоосон байдаг. Үрчлэх өргөдөл гаргагчид АНУ-ын холбооны хууль, үрчилж авахаар төлөвлөж буй хүүхдийн гарал үүслийн улсын хууль тогтоомж, үрчлэн авагчдын оршин суугаа улсын хууль гэсэн гурван багц хуулийг дагаж мөрдөх ёстой. Улс хоорондын үрчлэлт нь Гаагийн конвенцын шаардлагуудыг дагаж мөрдөх бөгөөд үрчлэгчдийг үнэлэхэд хэрэглэгдэх шалгуурууд нь бусад гарын үсэг зурсан улсуудтай адил байна. I-800A болон I-600A маягтууд нь үрчилж авах эцэг эхчүүдэд үрчлүүлэх эрхтэй, хүүхдэд зохих ёсоор анхаарал тавих чадвартай гэдгээ харуулах боломжийг олгодог. Тэд таны тухай, хэрэв та гэрлэсэн бол таны ханьтай холбоотой мэдээллийг авахыг хүсдэг. Тэд иргэний харьяалал, гэр бүлийн байдлын нотлох баримт (хэрэв байгаа бол) зэрэг туслах баримт бичгийг шаарддаг. Хэрэв танай гэр бүлд та болон таны эхнэр, нөхрөөс өөр насанд хүрсэн гишүүд байгаа бол та эдгээр хүмүүсийн талаар нэмэлт маягт бөглөх шаардлагатай болно.

- Гэрлэгчдэд тавигдах шаардлага:
  - Үрчилж буй эцэг эх нь хүүхдийн төрөлх эх оронд эцсийн үрчлэлтээ дуусгасан эсвэл АНУ-д цагаачлах, үрчлэн авах зорилгоор хүүхдийг хууль ёсны асран хамгаалах эрхийг авсан байх шаардлагатай;
  - Үрчилж авах эцэг эх нь АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны оршин суугч байх ёстой. Өргөдөл гаргагчийн АНУ-ын харьяат болохыг нотлох баримт хэрэгтэй. Зарим агентлагууд цагаачлалын статустай холбоотой нэмэлт шаардлага тавьж болно.
  - Хэрэв та гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээний хуулбарыг өгөх ёстой. Хэрэв та эсвэл таны эхнэр өмнө нь гэрлэж байсан бол өмнөх гэрлэлтийг цуцалсан тухай нотлох баримтыг мөн ирүүлэх ёстой.
- Насны хувьд тавигдах шалгуур:

Хүүхдийг гэрлэсэн АНУ-ын иргэн, эхнэр, нөхөр, эсвэл 25-аас доошгүй настай гэрлээгүй АНУ-ын иргэн эцэг эх/хүүхдийн шударга харилцааг бий болгох зорилгоор үрчилж авна.

- Санхүүгийн хувьд тавигдах шалгуур:
  Гэр бүлийнхээ санхүүгийн болон сэтгэл санааны хэрэгцээг хангах чадвартай байх ёстой. Үүнд орлогын баталгаажуулалт, ажил эрхлэлтийн байдал, санхүүгийн тайлан зэрэг орно.
- Эрүүл мэндэд тавигдах шалгуур:
  Үрчлэгч нь бие болон сэтгэхүйн хувьд хүүхдийг өсгөн хүмүүжүүлэхийн тулд бие бялдар, оюун санааны хувьд эрүүл байх ёстой, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах шаардлагатай. Бие бялдар, сэтгэхүй, сэтгэлзүйн хувд ямар нэгэн асуудалтай бол түүнийгээ илчлэх ёстой.
- Орлогод тавигдах шалгуур:
  Гэрлэгчдийн аль нэг нь тогтмол ажил, орлоготой
- Зан байдлын шалгуур:
  Үрчлэгч нь урьд өмнө нь ял шийтгүүлж байгаагүй, хууль болон дүрэм журмыг дагаж мөрдөх ёс зүйн зөв төлөвшил, зан байдалтай байх ёстой. Ирээдүйн үрчилж авах эцэг эх нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд холбогдож байсан эсэхийг шалгах, хүүхдийн хүчирхийлэлд холбогдож байсан эсэх тодруулга авах, заримдаа хурууны хээ авах шаардлагатай бөгөөд эрүүгийн шийтгэл хүлээхгүй байх, эсвэл хүүхэд хүчирхийлсэн түүх байхгүй эсэхийг баталгаажуулах ёстой.
- Гэрийн судалгаа:
  Гэрийн судалгаа буюу гэрийн судалгааны хамгийн сүүлийн үеийн шинэчилсэн хувилбар нь USCIS-д бүртгүүлсэн цагаас хойш 6-аас дээш сар хэтэрч болохгүй болохгүй. Гэрийн судалгаа гэдэг нь үрчилж авах ирээдүйн эцэг эхийн гэр орон, амьдралын хэв маягийн цогц үнэлгээ юм. Энэ нь хүүхдэд аюулгүй, тохиромжтой байхын тулд ярилцлага, лавлагаа, гэрийн орчныг тоймлон дүгнэх зэрэг орно. Гэрийн судалгааг тусгай зөвшөөрөлтэй нийгмийн ажилтан эсвэл үрчлэлтийн агентлагууд хийдэг.

IV. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага

Хүүхэд үрчлэн авах боломжтой эсэх нь эцэг эхийн зөвшөөрөл байгаа эсэх, эсвэл ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлага байхгүй (өөрөөр хэлбэл, өнчин, хаягдсан) эсвэл түүнээс татгалзах үндэслэл байгаа эсэх (жишээлбэл, эцэг эх байх эрхийг шүүхээр хасах) зэргээр тодорхойлогддог. Хүүхдийн эцэг эх нь хоёулаа нас барсан, алга болсон, хаягдсан, зугтсан, эсхүл салсан, эсхүл хүүхэд эцэг эхээ алдсан байх; эсхүл хүүхдийг зохих ёсоор асран хүмүүжүүлэх чадваргүй, цагаачлах, үрчлэх бичгийг эргэлт буцалтгүй гаргасан эцэг, эх байгаа бол тухайн хүүхдийг үрчилнэ[156]. Хүүхдийн биеийн байцаалт зохих ёсоор бичигдсэн байх ёстой. Ирээдүйн үрчилж авах эцэг эх нь хүүхдийг бүрэн үрчилж дуусаагүй эсвэл шаардлагатай бүх баримт бичгийг аваагүй байсан ч, хүүхдийг 16 нас хүрэхээс өмнө үрчилж авах өргөдлөө (I-600 маягт) гаргах ёстой.

[156] Who can be adopted https://travel.state.gov/content/travel/en/Intercountry-Adoption/Adoption-Process/before-you-adopt/who-can-be-adopted.html

V. Үрчлэлтийн дараах хяналт

АНУ-д үрчлэгдсэний дараах хяналт нь үрчлэгдсэн хүүхдүүдийн сайн сайхан, тогтвортой байдлыг хангах үрчлэлтийн үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. АНУ-ын дүрэм журмын дагуу үрчлэлтийн үйлчилгээ үзүүлэгчдээс үрчлэгдсэн эцэг эхтэй байгуулсан гэрээнд үрчлэгдсэний дараах тайлагналын шаардлагуудыг тусгаж, тэднийг ийм тайлан гаргахыг дэмжихийн тулд сайн санааны хүчин чармайлт гаргахыг шаарддаг[157]. Хүүхэд үрчилж авсны дараа хийх ёстой чухал алхмууд байдаг[158].

Хүүхдэдээ АНУ-ын иргэншил авах нь: Хүүхэд АНУ-ын иргэн болох нь чухал. Хэрэв хүүхдийн иргэний харьяалал авах, бичиг баримт бүрдүүлэхээ хойшлуулбал хүүхэд коллежид суралцах, хууль ёсны дагуу ажиллах, санал өгөх, бусад эрх, давуу эрх эдлэх зэрэгт хүндрэлтэй байж болзошгүй. Зарим тохиолдолд хүүхдийг албадан гаргах тохиолдол ч бий.

Үрчлэлтийн дараах тайлан: Олон улс орнууд хүүхэд үрчилж авсан эцэг эх эсвэл үрчлэлтийн үйлчилгээ үзүүлэгчдээс үрчлэгдсэний дараа, заримдаа үрчлэгдсэнээс хойш хэдэн жилийн дараа хүүхдийн ахиц дэвшил, сайн сайхан байдлын талаар мэдээлэхийг шаарддаг. Эдгээр тайланд хүүхдийн шинэ гэр бүл, шинэ улс дахь амьдралдаа дасан зохицож буй хөгжил, ахиц дэвшлийг ерөнхийд нь багтаадаг. Үрчлэлтийн дараах тайлан нь үрчилж авсан эцэг эх болон хүүхдэд үрчлэлтийн явцын талаар ярилцах чухал боломжийг олгодог.

Байршуулсны дараах тайлан: Зарим мужуудад тухайн хүүхэд үрчлэгдсэн гэр бүлтэйгээ хэдэн сарын турш хамт амьдрах хугацаанд нь үрчлүүлэхийг түр зөвшөөрнө. Дараа нь эдгээр улсууд үрчилж авах эцэг эхчүүдийг байршуулсны дараах тайланг тогтмол гаргаж байхыг шаарддаг. Эдгээр тайланд үндэслэн хүүхдийн гарал үүслийн улс нь хүүхэд, эцэг эхийн харилцаа холбоо сайн байгаа эсэх, хүүхэд шинэ соёл, гэр бүлийн орчинд хэр сайн дасан зохицож байгааг үнэлдэг.

Тайлагнах шаардлагуудыг ойлгох: Тусгай шаардлага нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг, заримдаа нэлээд нарийвчилсан байдаг бөгөөд үрчлэгдсэн хүүхдүүд 18 нас (эсвэл түүнээс дээш ховор тохиолдолд) хүртэл тайлагнал үргэлжлэх боломжтой. Үрчлэлтийн үйлчилгээ үзүүлэгч, үрчлэлтийн талаарх тухайн улсын мэдээлэл, мөн хүүхдийн гарал үүслийн улс дахь АНУ-ын элчин сайдын яам эсвэл консулын газар нь **Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтын тухай**

Америк улсын бүх мужуудад үрчлэлтийн захирамжийн эсрэг давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд холбогдох талуудын альных нь ч хүсэлтээр үрчлэлтийг хүчингүй болгож болохгүй гэсэн ерөнхий журам байдаг. Үрчлэлтийн захирамж нь хууль бус, алдаатай гэх мэт ердийн үндэслэлээс бусад тохиолдолд үрчлэлтийн захирамж хөдлөшгүй хэвээр байна.

[157] https://travel.state.gov/content/travel/en/Intercountry-Adoption/post-adoption/post-adoption-reporting.html
[158] https://travel.state.gov/content/travel/en/Intercountry-Adoption/post-adoption.html

VI. Байршуулах үйл ажиллагааны зохицуулалт

Үрчлэлтийн дараах байршуулалтын зөвлөгөө нь Америк улсын бүх муж биш гэхэд дийлэнх мужуудад боломжтой байдаг бөгөөд дийлэнх мужид төрийн болон хувийн үрчлэлтийн агентлагууд хүүхдийн төрсөн эхэд, хэрэв холбогдсон бол төрсөн эцэгт нь хууль ёсны эрхүүд болон боломжуудынх нь тухай үрчлэлтийн өмнөх байргуулалтын зөвлөгөө өгөх шаардлагатай байдаг. Зарим мужуудад тухайн хүүхэд үрчлэгдсэн гэр бүлтэйгээ хэдэн сарын турш хамт амьдрах хугацаанд нь үрчлүүлэхийг түр зөвшөөрнө. Дараа нь эдгээр улсууд үрчилж авах эцэг эхчүүдийг байршуулсны дараах тайланг тогтмол гаргаж байхыг шаарддаг. Эдгээр тайланд үндэслэн хүүхдийн гарал үүслийн улс нь хүүхэд, эцэг эхийн харилцаа холбоо сайн байгаа эсэх, хүүхэд шинэ соёл, гэр бүлийн орчинд хэр сайн дасан зохицож байгааг үнэлдэг.

VII. Үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Үрчлэлтийн агентлаг байршуулах үе шатанд оролцсоноор цаашдаа дэмжлэг үзүүлэх боломжтой байх, мөн талуудад дараагийн шатанд хувь хүнийг тодорхойлох мэдээлэл авах шаардлага үүсэхэд нь бүртгэлийн болон зөвлөгөө өгөх үйлчилгээ авах боломжийг олгоно. Зарим төрийн агентлагууд болон ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагууд зөвлөгөө өгөх, мэдээлэл авах, үрчлэлтийн бүртгэлд нэвтрэхэд туслах зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр үйлчилгээнд мөн холбоотой хүн бүрийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тааруулж болох эрэл хайгуул хийх, эргэн нэгтгэх үйл ажиллагаа орно. үрчилж буй тухайн улсын тайлагнах шаардлагыг илүү сайн ойлгоход тусална.

Үрчлэлтийн дараах үйлчилгээ: Үрчлэлтийн дараах үйлчилгээнд туслах бүлгүүд, боловсрол, нийгэм, соёлын үйл ажиллагаа, зуслан, эмчлэгч эмч, эмнэлгийн нөөц, гэр бүлээ хайхад туслалцаа үзүүлэх үйлчилгээ, файлд хандах зэрэг багтаж болно. Үрчлэлтийн дараах ийм эх үүсвэр, үйлчилгээг үзүүлдэг төрийн болон хувийн ашгийн бус олон байгууллага байдаг. Түүнчлэн АНУ-д үрчилж авсан гэр бүлийг дэмжих олон тооны бүлгүүд болон үрчлэгч байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр нь нэг эх орноос үрчлэн авсан бусад гэр бүл эсвэл үрчлэн авсан гэр бүлтэй харилцахыг хүссэн үрчлэгдсэн гэр бүлүүдэд зориулсан сүлжээг бий болгодог.

VIII. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

1994 оны Үрчлэлтийн нэгдсэн хууль нь талуудын зөвшилцсөний үндсэн дээр эсвэл эрүүл мэндийн шаардлагатай тохиолдолд хувь хүнийг тодорхойлох мэдээлэлд нэвтрэхийг зөвшөөрдөг бөгөөд үрчлэгч эцэг эх эсвэл насанд хүрсэн үрчлэгдэгчдийн хүсэлтээр хувь хүнийг тодорхойлолтгүйгээр мэдээллийг задруулдаг. Энэхүү хууль тогтоомж нь үндсэн тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд муж улсууд илүү нарийн эсвэл хялбар болгох нэмэлт журам нэмж оруулж болно. Бараг арав гаруй муж төрсний гэрчилгээний мэдээлэлд нэвтрэхийг зөвшөөрч байгаа ч энэ чиглэлийн хөдөлгөөн удааширч байгаа бололтой. Өнөө үеийн ихэнх үрчлэлтийн хувьд хувь хүнийг тодорхойлох мэдээл асуудал биш болсон, учир нь хүн бүрийн хувь хүнийг тодорхойлох мэдээл ил болсон.

Мэдээллийн ил тод байдал. Одоогоор ил тод байдлыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Ихэнх тохиолдолд үрчлэгдэгч ядаж төрсөн эцэг, эхийнхээ нэрийг мэдэх эрхтэй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай бол холбогдох шүүхийн шийдвэртэй холбоотой шүүхийн бүртгэл, баримт бичигтэй танилцах эрхтэй гэж шүүхээс тогтоосон байдаг. (жишээ нь Нью-Йорк, Калифорниа, Мичиган, Вашингтон, Вайоминг, Нью Жерси мужууд).

Гэсэн хэдий ч төрсөн эцэг эхийн эрх ашгийг төлөөлдөг байгууллагуудаас нээлттэй хандалтыг эсэргүүцсээр байна. Энэ нь АНУ-ын орчин үеийн хүүхэд үрчлэх практикийн өөр нэг онцлог шинж чанар юм.

Мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ. АНУ-д зөвлөгөө өгөхөөс эхлээд мэдээлэл цуглуулах, гэр бүлийг нэгтгэх хүртэл үрчлэлттэй холбоотой янз бүрийн үйлчилгээ үзүүлдэг бие даасан агентлагууд түгээмэл байдаг. Эдгээр агентлагуудын ихэнх нь ашгийн төлөө олон мужид үйл ажиллагаа эрхэлдэг.

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сонгосон 4 улс болон Монгол улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг дээрх 9 үзүүлэлтээр энэ бүлэгт харьцуулан судалсан болно.

I. Үрчлэлтийн эх сурвалж

БНХАУ, Франц, ХБНГУ, АНУ нь хувьд бие даасан үрчлэлтийн болон үрчлэлтийн бүртгэл, үрчлэлтийн агентлагийн хуулиудтай нь зэрэгцээ маш олон хууль журмуудаар зохицуулдаг бол нь Монгол улсын хувьд Гэр бүлийн тухай хуулийн долоодугаар бүлэг буюу 54-62 дугаар зүйлүүдийн хүрээнд хүүхэд үрчлэлттэй системийг тогтоож улмаар уг хуулийн 58 дугаар зүйлд Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх харилцааг зохицуулсан. Монгол улсын хувьд бие даасан үрчлэлтийн болон үрчлэлтийн бүртгэл, зуучлалын хуулиудгүй болно. Гэр бүлийн тухай хуулиар зохицуулагдаагүй Гадаадын иргэдээс Монгол улсын харьяат хүүхэд үрчлэн авахтай холбогдсон бусад харилцааг “Гадаадын иргэнд Монгол улсын харьяат Хүүхдийг үрчлүүлэх журам”-аар зохицуулдаг нь сул тал болно.

II. Үрчлэлтийн асуудал шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний чиг үүрэг[159]

БНХАУ-ын хувьд Гэр бүлийн тухай хууль болон Хүүхэд үрчлэх тухай хуульд улс хооронд хүүхэд үрчлэх эсэх асуудлыг Гаагийн конвенцыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгай бие даасан байгууллага буюу БНХАУ-д CCCWA, Төв байгууллага нь: Улс хоорондын үрчлэлтийн алба (SAI)[160] шийдвэрлэдэг байна.

Франц улсын хувьд Гадаад Европын харилцааны яамны харьяа “Олон улсын хүүхэд үрчлэн авах төлөөлөгчийн газрыг” ("La Mission de ['adoption internationale") улс хоорондын үрчлэлтийн асуудал хариуцсан төв байгууллага байгуулагдсан.[161] Үрчлэлтийн үйл явц нь хоёр дараалсан алхмыг шаарддаг. Зөвшөөрөл (хэлэлцээр) олгодог захиргааны журам,

---

[159] 中国儿童福利和收养中心 机构设置 http://www.cccwa.cn/n983/n991/index.html

[160] Liste des pièces nécessaires à la demande d’agrément en vue d’une adoption https://www.diplomatie.gouv.fr/IMG/pdf/AdoptionFinaleAngBD.pdf

[161] La Mission de l’adoption internationale https://www.diplomatie.gouv.fr/fr/adopter-a-l-etranger/la-mission-de-l-adoption-internationale/#:~:text=La%20Mission%20de%20l'adoption%20internationale%20(MAI)%20est%20l,Europe%20et%20des%20Affaires%20%C3%A9trang%C3%A8res

үрчлэлтийн шийдвэр гаргадаг шүүхийн журам байна. Францад Дүүргийн шүүх (Tribunal judi ciaire) үрчлүүлэх хүсэлтийг хүлээн авах, эсвэл татгалзах шийдвэр гаргана. Tribunal judiciaire нь олон улсын хүүхэд үрчлэлтийг хянах үүрэгтэй байгууллага болно.

ХБНГУ-ын хувьд у*лс* хоорондын үрчлэлтийн тухайд Холбооны Ерөнхий Прокурор нь Гаагийн конвенцын зорилгоор томилогдсон үндэсний төв удирдлагын (Bundeszentralstelle für Auslandadoption) үүрэг гүйцэтгэдэг бол Германы 16 муж тус бүр улс хоорондын үрчлэлтийг хянан шийдвэрлэх өөрийн буюу хамтарсан Төв эрх бүхий байгууллагуудыг байгуулсан.[162] ХБНГУ-д үрчлэлтийн асуудал хариуцсан холбооны зохицуулах төв байгууллага байдаггүй. Уг процесс нь шүүхийн шинж чанартай бөгөөд Гэр бүлийн шүүхээр шийддэг байна.

Харин Монгол улсын хувьд дотоод үрчлэлтийг Сум, дүүргийн засаг дарга шийдвэрлэдэг. Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх эсэх асуудлыг Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журмын 13 дахь хэсэгт “гадаадын иргэнээс хүүхдийг үрчилж авах тухай санал дүгнэлтээ гаргаж холбогдох материалын хамт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд ирүүлнэ”,14 дэх хэсэгт “Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх тухай Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба 30 хоногийн дотор үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж, гаргасан шийдвэрийн талаар гадаад улсын иргэн болон эрх бүхий байгууллагад уламжилна" гэж заасны дагуу Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх эсэхийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам санал гаргаж, Гадаадын иргэн, Харьяатын газар хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх эцсийн шийдвэрийг гаргах байдлаар улс хоорондын хүүхэд үрчлэх эсэх асуудлыг дээрх хоёр байгууллага хамтран шийдвэрлэдэг болно.Уг асуудалтай холбоотойгоор НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол улсад Гаагийн конвенцын хэрэгжилтийг хангах үндэсний газрыг байгуулах, үрчлэлтийн явцад хүүхдийн дээд эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим хамгийн чухлыг анхаарах, хүүхдийг үрчлүүлэх шаардлагатай эсэх талаар үнэлгээ хийхдээ энэ зарчмыг мөрдөх шаардлагатай байгааг зөвлөсөн.

III. Үрчлэгч эцэг эхэд тавигдах шалгуур

Бусад улс орнуудын хувьд үрчлэгч эцэг эхэд тавих шалгуурыг тогтоохдоо хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд ээлжид анхааран үзэж байна. Тухайлбал, БНХАУ, Франц, ХБНГУ-ын хувьд үрчлэгч эцэг эхийн насны доод хэмжээ, гэрлэснээс хойш хамт амьдарсан хугацаа, гэрлэсэн байх, үрчлэгч эцэг эхийн гэр бүлд байх хүүхдийн тоо, тэдний үрчилж авах хүүхдийн насны зөрүү, үрчлэгч эцэг эхийн болон түүнтэй хамт амьдарч буй гэр бүлд байх хүүхдийн тоо, үрчлэгч эцэг эхийн насны доод хэмжээ, тэдний үрчилж авах хүүхдийн насны зөрүү, үрчлэгч эцэг эхийн болон түүнтэй хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн хувийн байдал буюу урьд нь ял шийтгэгдэж гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг шалгаж, эрүүл мэнд, зан байдал, боловсрол, соёл, санхүүгийн орлогын хэмжээнд нарийн шалгуур тавьж, хүүхдийг албан ёсоор үрчлүүлэхээс өмнө үрчлэгч эцэг эхийг тусгай сургаалтанд хамруулж байгаа зэрэг нь хүүхдийг баталгаатай гэр бүлд

[162] Adoptionsvermittlungsgesetz https://dejure.org/gesetze/AdVermiG

үрчлүүлэх, хулгайлагдах, хил дамнан худалдагдахаас сэргийлэхэд нэлээд ач холбогдолтой зохицуулалт гэж үзэхээр байна.

Монгол улсын хувьд Гэр бүлийн тухай хуулийн 57.1, 57.2 дах хэсэгт зааснаар үрчлэгч нь ганц бие, насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байх ёстой бөгөөд 60-аас дээш насны гадаадын иргэн, эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж хасуулж байсан, урьд нь үрчилж авсан хүүхдээ өөрийн буруугаас буцааж өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа. мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, хорих ял эдэлж байгаа болон ганц бие эрэгтэй гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхгүй хэрэв гэр бүл хүсэлт гаргах тохиолдолд таваас доошгүй жил хамт амьдарсан байх зэрэг ерөнхий шаардлага тавигддаг. Эрүүл мэнд болон үрчлэгч эцэг эхийн насны доод хэмжээ, хамт амьдарсан хугацаа, гэр бүлд байх хүүхдийн тоо, үрчилж авах хүүхдийн насны зөрүү, үрчлэгч эцэг эхийн болон түүнтэй хамт амьдарч буй гэр бүлд байх хүүхдийн тоо, үрчлэгч эцэг эхийн насны доод хэмжээ, тэдний үрчилж авах хүүхдийн насны зөрүү зэрэг нарийвчилсан зохицуулалт үгүй болно.

IV. Үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлага

Бусад улс оронд үрчлэлтийн тухай хуулийн дагуу арван дөрөв эсх үл арван таван нас хүрээгүй хүүхэд эцэг эх нь нас барсан эсвэл нас барсан гэж зарласан хүүхэд,хаягдсан эсвэл эцэг эхийг нь [амархан] олж тогтоох боломжгүй , эцэг эх нь ер бусын хүндрэлийн улмаас тэднийг өсгөж хүмүүжүүлж чадахгүй байгаа хүүхдүүд, хөгжлийн бэрхшээл, өвчин эмгэг, хүүхдийн биологийн эцэг эхийн амьдралыг "маш хэцүү" болгодог бусад элементүүд багтдаг байна. Мөн төрийн асрамжид байгаа хүүхдүүд олдсон хүүхдүүд, өнчин хүүхдүүд, эцэг эх нь эцэг эхийн бүх үүрэг хариуцлагаас хасагдсан хүүхэд, бие даан зөвшөөрөл өгөх эрхгүй зөвхөн асран хамгаалагчийн хамт зөвшөөрөл өгсөн тохиолдолд үрчлэлт хийж болохоор зохицуулалттай байна.Монгол улсын хувьд үрчлэгдэх хүүхдэд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалтыг гэр бүлийн тухай хуулиар тусгаагүй болно.

V. Үрчлэлтийн дараах хяналт

БНХАУ-ын хувьд “Хятад улсад улс хооронд хүүхэд үрчлэх талаар үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагад тавигдах шаардлага" журамдаа үрчлэлтийн дараах тайланд тавигдах шаардлагыг тодорхой зохицуулсан байна. Үүнд: Тайланг 4 хэсэгтэй байх, 2 дах хэсэгт хүүхдийн амьдрал, хөгжил дэвшлийг илтгэсэн тайлан, 3 дах хэсэгт, 13 нас хүрсэн бол өөрийнх нь эсээг хавсаргах, 4 дэх хэсэгт хүүхдийн нөхцөл байдлын талаарх зургууд хавсаргах шаардлага тавьж байна.

Франц улсын хувьд улс хоорондын үрчлэлтийн дараах хяналтын үйл явц нь ихэвчлэн AFA болон үрчилж авсан гэр бүлийн хооронд тогтмол харилцах, түүнчлэн нийгмийн ажилтан эсвэл бусад итгэмжлэгдсэн төлөөлөгч гэр бүлийнх нь гэрт үе үе зочлох явдал юм. Эдгээр айлчлалын зорилго нь хүүхдийн ахиц дэвшил, сайн сайхан байдлыг үнэлэх, ар гэрт нь дэмжлэг, зөвлөгөө өгөх, үрчлэлтийн үйл ажиллагаа хүүхдийн эрх ашигт нийцсэн хэвээр байгаа эсэхийг баталгаажуулах зорилготой байна.

ХБНГУ болон Франц улсад үрчлэлтийн дараах тайлан бичихийн тулд хэд хэдэн айлчлал хийхээр төлөвлөдөг. Ярилцлага нь хүүхдийн бие бялдар, сэтгэл зүй, боловсролын хөгжил, түүнчлэн түүний шинэ гэр бүл дэх сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийг ажиглах боломжийг олгодог. Ихэнх ярилцлага тухайн үрчлэгдсэн гэрт явагддаг. Өөр бас төв газар товлон уулзах нь эмзэг сэдвүүдийг хэлэлцэх боломжийг олгоно. Хэлэлцүүлгийн эдгээр үе нь гэртээ хийсэн ярилцлагаас гадна явагддаг байна.

Монгол улсын Гэр бүлийн тухай хуульд дотоод болон гадаад үрчлэлтийн хяналтын асуудлыг зохицуулаагүй болно. Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журамд үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам Монгол улсын Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх, г/-д шаардлагатай тохиолдолд Монгол улсын эрх бүхий байгууллагаас тухайн хүүхдийн аж байдалтай танилцах, түүнтэй ярилцах боломжоор хангах” гэж зохицуулсан.

Үрчлэгч нь зуучлагч байгууллагаар дамжуулан үрчилж байгаа тохиолдолд ГИХГ-аас зуучлагч байгууллага (итгэмжлэгдсэн байгууллага) болон үрчлэгч эцэг эхтэй гурван талт гэрээ. хэрэв зуучлагч байгууллагаар дамжуулалгүй үрчилж байгаа тохиолдолд үрчлэгч эцэг эхтэй хоёр талт гэрээ байгуулах замаар үрчлэлтийн дараах хяналтыг тавьдаг хэдий ч тайланд тавигдах шаардлага, стандартыг хууль, журмаар тодорхой зохицуулаагүй болно.

VI. Үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалт

БНХАУ-ын хувьд үрчлэгч нь хүүхдийг насанд хүрээгүй бол үрчлэлтийг хүчингүйд тооцуулж болохгүй. Хэрэв үрчлэгч нь хүүхдийг тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцоогүй, мөн үрчилсэн эцэг эх, насанд хүрсэн үрчлүүлэгч хүүхдийн хоорондын харилцаа таарамжгүй болж хамт амьдрахаа больсон гэх мэт тохиолдлуудыг тусгасан байна.

Франц улсын хувьд үрчлэх нь хүүхдийн эрх ашигт нийцээгүй, үрчилж авсан эцэг эх нь хүүхдэд зохих ёсоор анхаарал халамж тавьж, дэмжлэг үзүүлж чадаагүй, үрчилж авсан эцэг, эх нь үрчлэлтийн нөхцөлийг зөрчсөн буюу хүүхдийн эрхийг зөрчсөн, хууран мэхлэлт эсвэл албадлагаар үрчлүүлсэн зэрэг тохиолдлыг тусгасан байна.

ХБНГУ-ын хувьд үрчлэх тухай тушаал нь онолын хувьд байнгын бөгөөд эргэлт буцалтгүй байдаг. Үрчлэлт нь анхнаасаа хууль зүйн хувьд алдаатай байсан бол үүнийг хүчингүй болгож болно. Тухайлбал: Зөвшөөрлийн мэдүүлгийг буруугаар, дарамт шахалт дор эсвэл талуудын аль нэгнийх нь эрх зүйн чадамжгүйн улмаас гаргасан бол, тухайн алдааг засаагүй бол, хүүхдийн сайн сайхны эрх ашгийг ноцтойгоор хохироохгүй байх нөхцөлийг бүрдүүлэн цуцлах бөгөөд үрчлэлтийн зарлиг гарснаас хойш гурван жилийн дотор хохирогч тал гомдол гаргах үүрэгтэй байна.

АНУ-ын хувьд бүх мужуудад үрчлэлтийн захирамжийн эсрэг давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд холбогдох талуудын алиных нь ч хүсэлтээр үрчлэлтийг хүчингүй болгож болохгүй гэсэн ерөнхий журам байдаг. Үрчлэлтийн захирамж нь хууль бус, алдаатай гэх мэт ердийн үндэслэлээс бусад тохиолдолд үрчлэлтийн захирамж хөдөлшгүй хэвээр байна.

МУ-ын хувьд үрчлэгч нь эцэг эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан эсхүл хүүхэд үрчлэн авахыг хуулиар хориглосон этгээдэд хүүхэд үрчлэхийг хориглохоор зохицуулсан. Уг асуудлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим, хүүхдийн нас төлөвшил, үзэл бодлыг харгалзах, хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд анхаарах, мэргэжлийн хүүхдийн эрхийн байгууллага оролцох эрхийг хангаагүй болно.

VII. Байршуулах үйл ажиллагааны зохицуулалт

БНХАУ-ын хувьд асрамжийн газар тодорхой туршилтын хугацаагаар байршуулах үйлчилгээ үзүүлдэг. Байршуулалтыг хийсний дараа мэргэжлийн дүгнэлт гаргахаас өмнө төрсөн эцэг эх (эсвэл хүүхдийн асран хамгаалагч) болон үрчилж авах хүмүүсийн хооронд шууд харилцахыг хориглосон. Энэ шатанд хүүхэд үрчлэн авах боломжтой эсэх, үрчилж авахаар төлөвлөж буй хүмүүс зохих, тохиромжтой эсэхийг шалгах ёстой.

Франц улсын хувьд асрамжийн газар байршуулахаас өмнө төрсөн эцэг, эхэд зөвлөгөө өгөх ямар нэгэн хуулиар тодорхой үүрэг хүлээсэн байгууллага байхгүй ч сайн туршлагын хувьд, дотоод дахь бүрэн үрчлэн авалтын журмын хүрээнд үүнийг Хүүхэд халамжийн газар хариуцдаг байна. Үрчлүүлэхийн тулд зөвшөөрөл авах шаардлагатай хүмүүст үргэлж зөвлөгөө өгч, тэдний зөвшөөрлийн үр нөлөөг зохих ёсоор мэдээлнэ. Тэр дундаа бүрэн үрчлэлтээр хүүхэд болон түүний төрсөн гэр бүлийн хооронд хууль эрх зүйн харилцаа дуусгавар болно гэдгийг бүгдэд нь мэдэгдэх болно. Зөвшөөрлийн хороо ирээдүйн үрчлэгчдийг албан ёсоор баталсны дараа үрчилж авах хүүхэдтэй холбоо тогтоох талаар урьдчилсан зохицуулалт хийх боломжтой болдог байна. Үрчлэлтийн байршуулалт хийх эрх мэдлийг Үрчлэлтийн зуучлалын тухай хуульд зөвхөн мэргэжлийн хүмүүс хийх ёстой гэж заасан байдаг. Үрчлэлтийн үйл явцад холбогдох мэргэжилтнүүдийн нарийн нийцсэн үнэлгээ хийж, үрчлэн авагчид хүүхдийг харах, мөн зарчмын хувьд тохиролцсоны дагуу хүүхдийн гарал үүсэлтэй холбоотой бүх мэдээллийг бүрэн илчилсний дараа л болдог. Бүх талууд нээлттэй үрчлэлтийг дэмжиж байгаа тохиолдолд хүүхдийн төрсөн эцэг эх нь хүүхдийг дор хаяж 8 долоо хоногтой болтол нь хүчин төгөлдөр зөвшөөрөл өгөх боломжгүй байсан ч үрчлэлтийн агентлаг хүүхэд төрсний дараа шууд эмнэлгээс байршуулах ажлыг хөнгөвчлөх боломжтой.[163]

ХБНГУ-ын хувьд үрчлэлтийн байршуулалтыг ихэвчлэн магадлан итгэмжлэгдсэн бие даасан үрчлэлтийн агентлагууд эсвэл орон нутгийн Залуучуудын халамжийн газар хийдэг. Үрчлэлтийн агентлаг эсвэл магадлан итгэмжлэгдсэн байгууллага хүүхдийг байршуулсны дараа байршуулалтын статусыг асрамжийн газрын байршуулалт (Adoptionspflege) гэж хуулиар тодорхойлдог байна. Туршилтын үрчлэлтийн байршуулалт (Adoptionspflege) нь хуулийн[164] дагуу үрчлүүлэх өргөдөл гаргах урьдчилсан нөхцөл бөгөөд үйл явц нь дотоодын эсвэл улс хоорондын шинж чанартай байснаас үл хамаарна. Холбогдох мэргэжилтнүүд үүнийг "туршилтын" гэх бус харин эмчилгээний чанартай дасах хугацаа гэж үздэг[165] байна.

---

[163] The Civil Code, s 1747, para 3.

[164] Мөн тэнд s 1744

[165] The Recommendations, No 4.4.

АНУ-д Үрчлэлтийн агентлаг байршуулах үе шатанд оролцсоноор цаашдаа дэмжлэг үзүүлэх боломжтой байх, мөн талуудад дараагийн шатанд хувь хүнийг тодорхойлох мэдээлэл авах шаардлага үүсэхэд нь бүртгэлийн болон зөвлөгөө өгөх үйлчилгээ авах боломжийг олгоно. Зарим төрийн агентлагууд болон ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагууд зөвлөгөө өгөх, мэдээлэл авах, үрчлэлтийн бүртгэлд нэвтрэхэд туслах зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр үйлчилгээнд мөн холбоотой хүн бүрийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тааруулж болох эрэл хайгуул хийх, эргэн нэгтгэх үйл ажиллагаа орно.

Монгол улсын хувьд хүүхдийн асрамжийн газар байршуулалт хийдэг хэдий ч ихэнхдээ өөрийн гэр оронд эсхүл төрөх эмнэлгээс шууд гараас гарт дамжуулан үрчлэгч, үрчлүүлэг нар шууд харилцан хувийн үрчлэлт хийдэг болно. Энэ нь Гаагийн конвенцын 29-р зүйлийг зөрчдөг болно.

VIII. Үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

БНХАУ-ын хувьд дэмжлэг үзүүлэх үйлчилгээний асуудал орхигдсон болно.

Франц улсын хувьд CLSC Plateau Mont Royal зэрэг байгууллагууд үрчлэлтийн дараах янз бүрийн үйлчилгээг бүлгийн хуралдаан, ганцаарчилсан зөвлөгөө хэлбэрээр үнэ төлбөргүй санал болгодог. Үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэхийн тулд Хүүхэд үрчлэлтийн зөвлөгөө, зөвлөх үйлчилгээ (COCAs) ажиллалдаг байна

ХБНГУ-ын хувьд үрчлэгчид болон хүүхдэд байнгын дэмжлэг шаардлагатай гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрч тэдний гэр бүл, олон нийтийн хэвийн үйлчилгээнд бүрэн хамрагдах эрхийг тайлбарлаж, хөнгөвчлөх үүрэгтэй. Дэмжлэгт нь орон нутгийн болон үндэсний үрчлэлтийн сүлжээ, дэмжлэг үзүүлэх бүлгүүдийн холбоо барих мэдээллээр хангах, тэдэнтэй харилцах зэрэг болно. Ерөнхийдөө Германы эрх баригчид агентлагуудыг үрчлэн авагч гэр бүл болон төрсөн эцэг эхийн хоорондын харилцаа холбоог хөнгөвчлөх, хүүхдийн хөгжлийн талаар мэдээлэл өгөх, гэрэл зураг солилцох зэрэгт туслахыг дэмждэг.[166] Дотоодын үрчлэлтийн системийг бүхэлд нь төрөөс санхүүжүүлдэг.

АНУ-ын хувьд Үрчлэлтийн дараах зөвлөгөө нь Америк улсын бүх муж биш гэхэд дийлэнх мужуудад боломжтой байдаг бөгөөд дийлэнх мужид төрийн болон хувийн үрчлэлтийн агентлагууд хүүхдийн төрсөн эхэд, хэрэв холбогдсон бол төрсөн эцэгт нь хууль ёсны эрхүүд болон боломжуудынх нь тухай үрчлэлтийн өмнөх зөвлөгөө өгөх шаардлагатай байдаг. Үрчлэлтийн өмнөх зөвлөгөөг мөн үрчлэгч эцэг эхэд ч өгөх ёстой байдаг. Харин Монгол улсын хувьд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байхгүй болно.

IX. Мэдээллийг ил болгох, мөрдөх ба дахин нэгтгэх үйлчилгээ

БНХАУ-ын хувьд хүүхэд үрчлэлтийн дараах мэдээлэл задруулах журам, холбогдох мөрдөн шалгах, дахин нэгтгэх үйлчилгээнүүд сайн хөгжөөгүй байна. Дотоодын болон улс хоорондын үрчлэлтийн дийлэнх хувийг гэр бүлийн түүх байхгүй өнчин, хаягдсан хүүхдүүд эзэлдэг тул ийм журам, үйлчилгээ байхгүй болно. Үрчлэлтийн тухай хуулиар төрсөн эцэг, эх, үрчлэн авагчид хувийн нууц, нэрээ нууцлах эрхийг тусгайлан олгосон байдаг ч үрчлэгдсэний дараа мэдээлэл авах эрхийг тухайн хоёр талын үзэмжээр хангадаг байна.

[166] Adoption Intermediation Act, ss. 8a, 8b and 9.

Франц улсын хувьд холбогдох хүүхдүүдийн хувьд эцэг эхийн нэрээ нууцлах хууль эрх зүйн баталгаа олгосон. “Үндэс угсаагаа мэдэх эрхийн тухай” хуулийг мөрдөж[167], хүүхэд төрүүлсэн эхэд нууцаар овог нэрээ битүүмжилсэн дугтуйнд бичиж өгөхийг зөвшөөрснөөр тэд хүүхэдтэйгээ уулзах эсэхээ хожим нь шийдэх боломжийг нээлттэй үлдээж байна. Эх хүн хэн болохоо илчлэх үүрэг хуулиар хүлээгээгүй. Төрөх үед өөрийнхөө төрөлт болон хэн болохыг нууцлахыг хүссэн эмэгтэйг сайн дурын үндсэн дээр өөрийнхөө болон эцгийн эрүүл мэнд (хэрэв түүнд ийм мэдээлэл байгаа бол), хүүхдийн гарал үүсэл, төрсөн нөхцөл байдал, мөн түүний биеийн байдлын талаарх мэдээллийг битүүмжилсэн дугтуйнд хийж үлдээхийг зөвлөдөг. Үүнд тэрээр өөрийн нэр, төрсөн он сар өдөр, төрсөн газраа зааж өгч болно. Дугтуйны хавтсанд түүний хүүхдэд зориулж сонгосон анхны нэрс, түүнчлэн түүний хүйс, огноо, цаг, төрсөн газар бичсэн байна. Энэхүү дугтуйг хадгалдаг бөгөөд зөвхөн хүүхэд эсвэл түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр CNAOP-ийн гишүүн л битүүмжлэлийг тайлж болно. Энэ тохиолдолд CNAOP эхийг хайж эхэлж, түүнтэй холбоо барьж болно. Үнэн хэрэгтээ ээж нь ямар ч үед өөрийн хувийн нууцлалаа түдгэлзүүлж болно, гэхдээ тэр хүүхдээ хайх эрхгүй байхаар зохицуулж өгсөн байна.

ХБНГУ-ын хувьд хүүхдээ нэрээ нууцлан, ямар ч мэдээлэл үлдээхгүйгээр орхих эхийн эрхэд хамаарах нууцыг хамгаалах эрх хязгаарлагдмал. Хэдийгээр эх нь хүүхдээ төрөх үед (Vertrauliche Geburt) нэрээ нууцалсан байсан ч дараа нь 16 нас хүрсэн хойно хувь шинжийн мэдээлэлд нь (Herkunftsnachweis) нэвтрэх эрхтэй. Холбооны Үндсэн хуулийн шүүх хүн бүр өөрийн биологийн гарал үүслийг мэдэх үндсэн хуулиар олгогдсон эрхийг баталгаажуулсан. 16 ба түүнээс дээш насны үрчлэгдэгчид үрчлэлтийн баримт бичиг (хэрэв 16 нас хүрээгүй бол үрчилж авсан эцэг эх нь үрчлэгдэгчийн хууль ёсны төлөөлөгчийн хувьд нэвтэрч болно) болон өөрийнх нь гарал үүсэлтэй холбоотой баримтуудыг тэмдэглэсэн улсын бүртгэлд нэвтэрч болно. Түүнчлэн, агентлагууд үрчлэлтийн тушаал гарахаас өмнө болон дараа нь нээлттэй байх боломжийг судлах үүрэгтэй байна.Үрчлэгдэгчийн төрсөн эцэг эхийн мэдээллийг хэн гэдгийг нь олж авах эрхийг хуулиар[168] олгосон.

АНУ-ын хувьд 1994 оны Үрчлэлтийн нэгдсэн хууль нь талуудын зөвшилцсөний үндсэн дээр эсвэл эрүүл мэндийн шаардлагатай тохиолдолд хувь хүнийг тодорхойлох мэдээлэлд нэвтрэхийг зөвшөөрдөг бөгөөд үрчлэгч эцэг эх эсвэл насанд хүрсэн үрчлэгдэгчдийн энгийн хүсэлтээр хувь хүнийг тодорхойлохгүй мэдээллийг задруулдаг. Энэхүү хууль тогтоомж нь үндсэн тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд муж улсууд илүү нарийн эсвэл хялбар болгох нэмэлт журам нэмж оруулж болно. Бараг арав гаруй муж төрсний гэрчилгээний мэдээлэлд нэвтрэхийг зөвшөөрч байгаа ч энэ чиглэлийн хөдөлгөөн удааширч байгаа бололтой. Өнөө үеийн ихэнх үрчлэлтийн хувьд хувь хүнийг тодорхойлох мэдээл асуудал биш болсон, учир нь хүн бүрийн хувь хүнийг тодорхойлох мэдээл ил болсон.

Монгол улсын хувьд үрчлэлтийн нууцыг хадгалах үүргийг хуулиар хүлээлгэснээс өөр дорвитой зохицуулалт үгүй болно.

[167] Kerry O’Halloran “The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition”, White Park Bay, Northern Ireland, UK, 2021, p. 611
[168] Adoption Intermediation Act, s 9b.

Тав. Хүүхэд үрчлэлтийн харилцаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Хүүхэд үрчлэлтийн тухай хууль тогтоомж нь улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо хууль тогтоомжийн уламжлал онцлогоос шалгаалж харилцан адилгүй байдаг. Хүүхэд үрчлэлт нь эмзэг нарийн харилцаа тул холбогдох хууль эрх зүйн үйл явцыг удирдах нь нэн төвөгтэй бөгөөд цаг хугацаа их шаардсан асуудал юм. Тиймээс ирээдүйн үрчилж авах эцэг эхчүүд үрчлэх улсынхаа болон дотоодын үрчлэлтийн хууль тогтоомж, шаардлагыг сайтар судалж, хүүхдийн төрсөн газар эсвэл оршин суугаа улсын онцлогийг ойлгох нь чухал юм. Шүүх болон үрчлэлтийн байгууллага шийдвэр гаргахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж ажиллах үүрэгтэй. Учир нь үрчлэлтийн гол зорилго бол хүүхдийн сайн сайхны төлөө юм гэдгийг анхаарч, хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдал, тогтвортой байдлыг чухалчилан үздэг. Тийм учраас хүүхдэд эрсдэлтэй бүхий л нөхцөл байдал, үр дагавраас сэргийлэх, зайлсхийх, түүнээс хүүхдийг хамгаалах бүхий л арга хэмжээг авах шаардлагатай байдаг. Энэ дагуу үрчлэлтийн өмнөх болон дараах бүхий л үйл явцад төрийн бодлого, зохицуулалт, хяналт шаардагддаг. Үүнд ихэвчлэн үнэлгээ, гэрийн судалгаа, намтрын судалгаа, хууль эрх зүйн баримт бичиг, шүүх хуралдаан зэрэг үе шатууд багтдаг. Үрчлэлт нь үрчлэгдсэн хүүхдэд хамгийн таатай орчинг бүрдүүлэхийн тулд маш анхааралтай авч үзэх, бэлтгэх шаардлагатай амьдралыг өөрчлөх маш чухал үйл явц юм. Тийм учраас үрчлэлтийн үйл явцад мэргэжлийн агентлагууд, нийгмийн ажилтнууд эсвэл үрчлэлтийн сэтгэл зүйчид, өмгөөлөгчид удирдан чиглүүлж, хууль ёсны шаардлагыг дагаж мөрдөхөд тусалдаг. Мөн зарим оронд үрчлэлтийн дараах олон агентлаг, байгууллагууд үрчилсэн гэр бүлүүд болон үрчлэгдсэн хүүхдүүдэд гэр бүлийн шинэ нөхцөл байдалд дасан зохицоход нь туслахын тулд үрчлэлтийн дараах дэмжлэг үзүүлэх үйлчилгээг санал болгодог. Хүүхэд үрчлэн авах нь эрхэм нандин бөгөөд энэрэнгүй үйл хэрэг боловч тухайн улс орон, хууль эрх зүйн орчин, хувь хүний нөхцөл байдлаас шалтгаалж дараах сорилтуудыг дагуулдаг. Үүнд:

- Хүүхэд үрчлэн авах тухай хууль тогтоомж нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг тул хууль эрх зүйн үйл явц нь маш төвөгтэй бөгөөд цаг хугацаа их шаарддаг, мэргэжлийн тусламж чиглүүлэг шаардлагатай үйл ажиллагаа юм.
- Хүүхэд үрчлэн авах нь хуулийн үйлчилгээ, агентлагийн хураамж, гэрийн сургалт, аялалын зардал зэрэг өндөр төсөв хөрөнгө шаарддаг.
- Хүүхэд үрчлэн авах үйл явц нь удаан үргэлжилдэг бөгөөд заримдаа өргөдөл гаргаснаас хойш эцсийн шийдвэр гарах хүртэл хэдэн жил болдог. Энэхүү уртасгасан хугацаа нь хүүхэд үрчилж авах эцэг эхчүүдэд санхүү болон сэтгэл санааны том сорилт болдог.
- Үрчлэх эцэг эх болон үрчлүүлэх шаардлагатай хүүхдийн хооронд нийцэл тохирлыг олох нь хэцүү байдаг. Нас, хүйс, царай төрх, тусгай хэрэгцээ гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлдөг.
- Ирээдүйн үрчилж авах эцэг эх нь ихэвчлэн гэр орон болон хувийн амьдралыг нь сайтар үнэлдэг гэрийн судалгаанд хамрагдах шаардлагатай байдаг. Гэрийн судалгаанд бүтэлгүйтэх нь хүүхэд үрчлэн авах үйл явцад ихээхэн бэрхшээл учруулж болзошгүй юм.

- Үрчлэгдсэн хүүхдүүдийн хувьд шинэ гэр бүл, орчинд дасан зохицоход хэцүү байдаг. Хүүхэд болон үрчилж авсан эцэг эхийн аль алинд нь дасах, холбоо үүсэх нь цаг хугацаа, хүчин чармайлт шаарддаг үйл явц юм.
- Олон улсын үрчлэлтийн хувьд олон агентлагтай харьцах, өөр өөр хуулийн тогтолцоонд үйл ажиллагаагаа удирдах нь төвөгтэй байж болно. Олон улсын үрчлэлтийн бодлого, дипломат харилцаанд гарсан өөрчлөлтүүд энэ үйл явцад нөлөөлж болно.
- Арьс дамнасан, үндэстэн дамнасан эсвэл соёл дамжсан хүүхэд үрчлэлт нь үрчлэгдсэн хүүхдүүдэд хувийн шинж чанар, соёлын сорилтыг бий болгодог.
- Хүүхэд болон бусдад үрчлэлтийн тухай хэзээ, хэрхэн мэдэгдэхийг шийдэх нь эмзэг асуудал байдаг. Төрсөн эцэг эх нь хувийн нууцлал, холбоо барих талаар өөр өөр сонголттой байдаг.
- Хүүхэд үрчлэлтийг дэмжих бүлгүүд, зөвлөгөө өгөх, эх сурвалжид хандах боломж зарим хэсэгт хязгаарлагдмал байж болно. Ирээдүйн үрчилж авах эцэг эхчүүд эдгээр нөөцийг идэвхтэй хайх шаардлагатай байж магадгүй юм.
- Хуулийн эрсдэлд төрсөн эцэг эх үрчлэлтийн талаар шүүхэд гомдол гаргах, зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг орно. Энэ нь хүүхэд болон үрчилсэн гэр бүлд хагацал өнчрөл үзүүлэх эрсдэлийг авчирдаг.
- Зарим хүмүүс үрчлэлтийн талаар өрөөсгөл, буруу ойлголттой байдаг нь нийгэмд гутаан доромжлол, үл тоомсорлолтой учрахад хүргэдэг.

Улс хоорондын үрчлэлтийн үйл ажиллагаа нь хүүхэд үрчлэх ёс зүй, хууль ёсны үйл ажиллагааны стандартыг тогтоож, хүүхэд худалдаалах, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой Гаагийн конвенц зэрэг олон улсын гэрээ, конвенцоор зохицуулагддаг. Хүүхэд үрчлэн авах асуудлыг зохицуулах олон улсын эрх зүйд голчлон хил дамнан үрчлэгдсэн хүүхдийн хамгаалал, сайн сайхан байдлыг хангах удирдамж, зохицуулалтыг бий болгох зорилготой гэрээ, конвенц багтдаг. Хүүхэд үрчлэхтэй холбоотой олон улсын эрх зүйн актуудыг энд дурдъя. Үүнд:

- Үрчлэлтийн тухай Гаагийн конвенц (1993): Энэ нь улс хоорондын үрчлэлттэй холбоотой хамгийн чухал олон улсын гэрээ юм. Хүүхдийг хамгаалах, улс хоорондын үрчлэлтийн талаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцод хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах үүднээс улс хоорондын үрчлэлтийн журам, хамгаалалтыг тогтоодог. Мөн хүүхэд хулгайлах, худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой. Олон улс орон энэхүү конвенцод нэгдэн орсон бөгөөд уг конвенцын зарчмууд нь тухайн улс орнуудад олон улсын хүүхэд үрчлэлтийг удирдан чиглүүлдэг.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989): Хэдийгээр үрчлэлтийн асуудалд онцгой анхаарал хандуулдаггүй ч энэ конвенц нь эх орондоо асрах боломжгүй хүүхдүүдийг олон улсад үрчлэн авах нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь хүүхдийн дээд ашиг сонирхол, хувийн шинж чанараа хадгалах эрх, тогтвортой, хүмүүжлийн орчны хэрэгцээг чухалчилдаг.
- Хүүхэд үрчлэх тухай түгээмэл тунхаглал (1959): Энэхүү заавал биелүүлэх албагүй баримт бичиг нь хүүхэд үрчлэн авах зарчмуудыг тодорхойлсон. Хэдийгээр гэрээний

хэрэгжилтийн механизм дутмаг ч олон улсын хүүхэд үрчлэх практикт лавлах эх сурвалж болдог.

- Насанд хүрээгүй хүүхдийг үрчлэн авахтай холбоотой хууль тогтоомжийн зөрчлийн тухай Америк хоорондын конвенц (1984): Америк тивд мөрдөгдөж буй энэхүү бүс нутгийн гэрээ нь хил дамнан хүүхэд үрчлэх хэргийн харьяаллын асуудлыг авч үздэг.
- Хүүхдийн эрх, сайн сайхны тухай Африкийн дүрэм (1990): Энэхүү Африкийн холбооны гэрээ нь хүүхэд үрчлэн авахтай холбоотой заалтуудыг агуулсан бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхол, хувийн шинж чанарыг хадгалах, хулгайлах, худалдаалахаас хамгаалах арга хэмжээг тусгасан болно.
- Улс хоорондын үрчлэлтийн тухай Гаагийн конвенцын нэмэлт протокол (2000): Энэхүү протокол нь хүүхэд хулгайлах, худалдахаас урьдчилан сэргийлэх нэмэлт хамгаалалт, арга хэмжээг тогтоодог.
- Үрчлэлттэй холбогдох асуудалд хэрэглэгдэх эрх зүй болон үрчлэлтийн талаарх шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байгууллагын харьяаллын тухай Гаагийн конвенц /1964 он/[169]
- Улс орны онцлогт тохирсон гэрээ, хууль тогтоомж: Олон улс үрчлэлтийн асуудлыг зохицуулдаг өөрийн хууль тогтоомж, хоёр талт гэрээтэй байдаг. Эдгээр гэрээнд хүүхэд үрчлэх тухай Гаагийн конвенцын зарчмуудыг тусгасан байдаг ч холбогдох улс орнуудтай холбоотой тодорхой заалтуудыг багтааж болно.

Хүүхэд үрчлэн авах тухай олон улсын хуульд хүүхдийн эрх ашгийг гол зарчим болгон чухалчилдаг. Энэ нь хүүхэд худалдаалах, хууль бус үрчлэн авах зэрэг хүчирхийлэл, ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ улс орон даяар аюулгүй, ёс зүйтэй үрчлэн авах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой юм.

Даяаршиж байгаа өнөө үед хүүхэд үрчлэлтийн асуудал нь зөвхөн тухайн улсын дотоод асуудал байхаа больж, олон улсын практик болсон. Хүүхдийг хамгаалах болон үрчлэх асуудлаар хамтран ажиллах Гаагийн конвенцод нэгдсэн улс бүр өөрийн эрх зүйн зохицуулалтаа энэ зохицуулалтад нийцүүлэхийг хичээж байна. Уг конвенцод Монгол Улс нь нэгдэн орсон тул хүлээсэн үүргийнхээ дагуу 1973 оны Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болгож, 1999 оны 06 дугаар сарын 11-ны өдөр Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Уг хуулийн 7 дугаар бүлгээр хүүхэд үрчлэх, үрчлүүлэх харилцааг зохицуулж өгснөөс хойш 2022 он хүртэлх хугацаанд гадаадын 17 улсад 274 хүүхэд үрчлэлт хийсэн бол дотоодод нийт 43169 хүүхэд үрчлэгдсэн байна. Дээрх үрчлэгдсэн хүүхдүүдийн эрх ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хангаж хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх нь Монгол төрийн үүрэг болно. Гэсэн хэдий ч нийт үрчлэлтийн 90 гаруй хувь нь төрийн хяналтаас гадуур хувийн үрчлэлтээр хийгдэж байгаа нь төр энэхүү үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа бөгөөд хүүхэд үрчлэлтийн үйл явц маш эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа гэдгийг харуулж байгаа юм.

[169] Э.Байгаль. Олон улсын хувийн эрх зүй, УБ, 2012 249 дэх тал


Зураг** Error! No text of specified style in document.**-1. Монгол Улсын хэмжээнд 2000 оноос 2023 оны хооронд хийгдсэн хүүхэд үрчлэлтийн тоон мэдээлэл[170]



Улсын хэмжээнд 2000–2023 он хүртэлх хугацаанд нийт 44,590 хүүхдийн үрчлэлт бүртгэгдсэн байна. Тус 23 жилийн үрчлэлтийн дундаж нь 1858 байна. Үүнээс 2005 онд улсын хэмжээнд хамгийн их буюу 3797 хүүхэд үрчлэгдсэн байна. Ерөнхийдөө 2000-2010 оны хооронд хүүхэд үрчлэлтийн тоо өсөөд 2010-2022 оны хооронд хүүхэд үрчлэлтийн тоо буурсан төлөвтэй харагдаж байна. 2005 онд хүүхэд үрчлэлт эрс өссөн шалтгааныг тодруулбал төрөөс хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаатай холбоотой бөгөөд энэ нь тус онд батлагдсан Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тухай хууль юм.


Зураг** Error! No text of specified style in document.**-2. Монгол Улсын 21 аймгийн хэмжээнд 2000-2023 оны хооронд хийгдсэн хүүхэд үрчлэлтийн тоон мэдээлэл[171]

[170] Үндэсний статистикийн хорооны тайлан УБ,2022 он 105 дахь тал
[171] Үндэсний статистикийн хорооны тайлан УБ хот.,2022 он 103 дахь тал



2000-2023 онд үрчлэгдсэн нийт хүүхдүүдийн 33% нь Улаанбаатарт, 20.3% нь Баруун бүсэд, 25.2% нь Хангайн бүсэд, 13% нь Төвийн бүсэд, 8.6% нь Зүүн бүсэд үрчлэгдсэн байна. Нийт үрчлэлтийн 32.8% нь Улаанбаатар хотод, 9% нь Баян-Өлгий аймагт, 7% нь Хөвсгөл аймагт хийгдсэн ба үлдсэн 50% нь бусад аймагт хийгдсэн байна.

***Зураг** Error! No text of specified style in document.-3. Монгол улсын хэмжээнд 2011-2023 онд хийгдсэн үрчлэлт насны бүлгээр хийгдсэн тоон мэдээлэл[172]*



Улсын хэмжээнд 2000-2023 оны байдлаар нийт 44590 үрчлэлт бүртгэгдсэнээс:

- 0-3 настай хүүхдийн үрчлэлт 43.9%,
- 3-6 настай хүүхдийн үрчлэлт 22.8%,
- 7-9 настай хүүхдийн үрчлэлт 12.4%,

[172] Үндэсний статистикийн хорооны тайлан УБ хот.,2022 он 105 дахь тал

- 10-с дээш настай хүүхдийн үрчлэлт 20.9% тус тус бүртгэгдсэн байна.

Хүүхэд үрчлэлтийн процесс, процедур, үйл ажиллагааны алдаа дутагдал, эрх зүйн зохицуулалтын талаар санаа бодлыг нь сонсож, практик дээр тулгамдаж байгаа асуудлыг нээн илрүүлэх зорилгоор хүүхэд үрчлэлтийн процесст оролцдог дараах байгууллагуудын удирдлага болоод мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, судалгаа авсан болно. Үүнд:

1. Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор
2. Хүүхдийн төв сувилал
3. Монголын хүүхдийн сан
4. Хүүхдийн асрамжийн “ Өнөр бүл” төв
5. Хүүхдийн асрамжийн “Гэрэл” төв
6. Хүүхдийн асрамжийн “Мана” төв
7. Holt international ОУТББ
8. Amici Di Don Bosko, I Fiori
9. Semplici Onlus
10. 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс
11. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
12. ХНХЯ-ны Үрчлэлтийн зөвлөл
13. ГИХАЭА-ны ярилцлагын комисс

Мөн хүүхэд үрчилж авсан 15 иргэнтэй ярилцлага хийсэн. Дээрх судалгааны дүгнэлтэнд үндэслэн хүүхэд үрчлэлтийн харилцаанд тулгамдаж буй бүхий л асуудлуудыг ерөнхийлөн дараах байдлаар бүлэглэн авч үзлээ. Үүнд:

1. Монгол улсад хүүхэд үрчлэлтийн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, үйл ажиллагаанд баримтлах нэгдсэн журам байхгүй.
2. Монгол улсын хүүхэд үрчлэлтийн харилцааны эрх зүйн зохицуулалт нь дотоодын болон олон улсын эрх зүйн хэм хэмжээтэйгээ зөрчилдөж байна.
3. Хүүхэд үрчлэлтийн бодлого хэрэгжүүлэх, олон талт нарийн төвөгтэй энэ процессыг удирдах нэгдсэн чиг үүргийн байгууллага дутагдаж байна.
4. Хүүхэд үрчлэлтийн процесст дэмжлэг үзүүлэх, мэдээлэл өгөх, өргөдөл хүсэлт хүлээн авах, бүртгэх, хянах, тайлагнах нэгдсэн цахим систем дутагдаж байна.

Эдгээр нь бүхий л тулгамдаж буй асуудлуудыг дэлгэрүүлэн авч үзье.

Нэг. Хүүхэд үрчлэлтийн нэгдсэн журам, хүүхэд үрчлэлтийн асуудал эрхэлсэн чиг үүргийн байгууллага дутагдаж байна.

Судалгаанаас харахад хүүхэд үрчлэлтийн нэгдсэн журам, зохицуулалт байхгүйн улмаас дүүрэг бүрт ялгаатай бодлого, журам, үе шат хэрэгжиж, өөр өөр субъектууд үйлчилж, ажил үүргийн давхцал гарч байна. Хүүхэд үрчлэх болон үрчлүүлэх хэрэгцээ шаардлага бүхий хүмүүс ямар дараалал үе шаттайгаар, хаана, хэнд хандаж асуудлаа шийдвэрлэдэг талаар судалж үзэхэд 9 дүүрэгт ялгаатай журам үйлчилж байв. Доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт** Error! No text of specified style in document.**-1. Нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжиж буй үрчлэлтийн журам


№	Дүүрэг	Үрчлэлтийн хүсэлт, материал хүлээн авах	Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ	Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ	ХГБЗХХ-ийн оролцоо	Хүүхдийн эрхийн байцаагч	ЗДТГ-НХХ оролцоо	Захирамж	Төрсний
1	Сүхбаатар	Хорооны нийгмийн ажилтан	Хорооны хамтарсан баг	Хорооны хамтарсан баг	Үрчлэлтийн дүгнэлт гаргана.	Байхгүй	ЗД-н захирамжийн төсөл боловсруулна.	ЗД	ИБХ
2	Чингэлтэй	Хорооны нийгмийн ажилтан	Хорооны хамтарсан баг	Хорооны хамтарсан баг	Материал бүрдүүлэлтэд хяналт тавьж бүрэн бол ажлын хэсэгт шилжүүлнэ.	Байхгүй	Тусгай ажлын хэсэг хуралдаж, ЗД-н захирамжийн төсөл боловсруулна.	ЗД	ИБХ
3	Сонгино хайрхан	Хорооны нийгмийн ажилтан	Хорооны хамтарсан баг	Хорооны хамтарсан баг	Материал хүлээн авч хүүхдийн эрхийн улсын байцаагчид шилжүүлнэ.	Дүгнэлт бичнэ	НХХ-ээс захирамжийн төсөл бичиж, ИБХ-рүү шилжүүлнэ. ИБХ холбогдох материал төслийг хянаад, ирүүлснийг НХХ хянана.	ЗД	ИБХ
4	Баянзүрх	Хорооны нийгмийн ажилтан	Байхгүй	Хорооны хамтарсан баг	Материал хүлээн авч хүүхдийн эрхийн улсын байцаагчид шилжүүлнэ.	Дүгнэлт бичнэ	НХХ захирамжийн төсөл боловсруулна	ЗД	ИБХ

5	Баянгол	Хорооны нийгмийн ажилтан	Байхгүй	Хорооны хамтарсан баг	Материал бүрдүүлэлтэд хяналт тавьж бүрэн бол ажлын хэсэгт шилжүүлнэ.	Байхгүй	Тусгай ажлын хэсэг хуралдаж, дүгнэлт гаргаж, захирамжийн төсөл бэлдэнэ.	ЗД	ИБХ
6	Хан-Уул	ХГБЗХХ	Байхгүй	ХГБЗХХ	Мэргэжилтэн дүгнэлт бичнэ. Ахлах мэргэжилтэн хянаж, захирамжийн төсөл бичнэ.	Байхгүй	ЗДТГ-н хэлтсийн дарга нар хянана	ЗД	ИБХ
7	Багануур	ХГБЗХХ	Хорооны хамтарсан баг	Байхгүй	Ахлах мэргэжилтэн хянаж, захирамжийн төсөл бичнэ.	Байхгүй	ЗДТГ-н НХХ хянаж захирамжийн төсөл бэлдэнэ	ЗД	ИБХ
8	Багахангай	ЗДТГ хүлээн авч ХГБЗХХ-руу явуулна.	•ХГБЗХХ зөвхөн эрсдэлтэй үед хийнэ. •ХГБЗХХ- хүүхдийн эрхийн улсын байцаагч нь зөвхөн эрхийн зөрчилтэй хүүхэд байгаа тохиолдолд үрчлэлтийн харилцаанд дүгнэлт гаргаж, захирамжийн төсөл боловсруулах байдлаар оролцоно.				ЗДТГ-н эрх зүй, хяналт, шинжилгээ үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг, хариуцсан мэргэжилтэн захирамжийн төслийг хянана	ЗД	ИБХ
9	Налайх	ЗДТГ хүлээн авч ХГБЗХХ-руу явуулна.	• ХГБЗХХ-н мэргэжилтэн хүүхэдтэй зан төлөвийн тодрол тест, уулзалт ярилцлага хийнэ. • ХГБЗХХ-н мэргэжилтэн гэр бүлийн орчны үнэлгээ, багц оношилгоо, эцэг эхийн хандлагын тест, архины хамаарал эрсдлийн үнэлгээ			Байхгүй	ЗДТГ-НХХ захирамжийн төсөл боловсруулна	ЗД	ИБХ

- Хүүхэд үрчлэх хүсэлт болон холбогдох бичиг баримтыг хүлээн авч анхан шатны зөвлөгөө өгөх үүргийг зарим дүүрэгт хорооны нийгмийн ажилтан, зарим дүүрэгт ЗДТГ-ын дэргэдэх нийгмийн хөгжлийн хэлтэс, зарим дүүрэгт ГБХЗХХ гэх мэт ялгаатай субъектууд хэрэгжүүлж байв.
- Нөхцөл байдлын үнэлгээг зарим дүүрэгт хүүхдийн оршин суугаа хорооны хамтарсан баг, зарим дүүрэгт ГБХЗХХ эсвэл хүүхдийн эрхийн байцаагч, зарим дүүрэгт ЗДТГ-ын НХХ хийж байна.
- 9 дүүрэг хүүхэд үрчлэлттэй холбоотой өөр өөр үнэлгээ хийж байна. Нийслэлийн 9 дүүргээс 3 дүүрэгт нь хүүхдийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийдэггүй бол 4 дүүрэгт дээрх хоёр үнэлгээг хоёуланг хийж байна. Багахангай дүүрэгт нь зөвхөн эрхийн зөрчилтэй хүүхэд үрчилж байгаа тохиолдолд үнэлгээ хийж байв. Гэтэл Налайх дүүрэгт дээрх хоёр үнэлгээнээс огт өөр үнэлгээг хийж байна. Тухайлбал: Хүүхдээс зан төлвийн тодрол тест, ажиглалт, уулзалт ярилцлага хийдэг. Үрчлэн авагчаас гэр бүлийн орчны үнэлгээ, багц оношилгоо, эцэг, эхийн хандлага, хариу үйлдлийг хэмжих асуумж, эцэг эхийн архины хамаарлын эрсдэлийн үнэлгээ зэргийг хийж байна.
- Дээрх харилцан адилгүй хийгдэж байгаа үнэлгээнүүдийг баталгаажуулж дүгнэлт гаргах эрхтэй субъект нь дүүрэг бүрт бас л харилцан адилгүй байна. 4 дүүрэгт ГБХЗХХ дүгнэлт гаргадаг бол 3 дүүрэгт хүүхдийн эрхийн улсын байцаагч дүгнэлт гаргаж байна. Харин үлдсэн хоёр дүүрэгт нь тусгай ажлын хэсэг гарч дүгнэлт гаргаж, засаг даргын захирамжийн төслийг боловсруулж хянадаг байна.
- Үрчлэлтийн үйл явц нь Гаагийн конвенцын шаардлагад огт нийцэхгүй байгаа бөгөөд хэд хэдэн чухал үе шатыг орхигдуулсан. Үрчлэлтийн бүртгэл болон үнэлгээний үе шатнаас бусад бүх үе шат манай үрчлэлтийн тогтолцоонд үндсэндээ байхгүй байна. Цаашлаад үрчлэлтийн үе шат бүрд мэргэжлийн бус хүмүүс ажиллаж, буруу арга хэрэгслээр эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ, оношилгоо, тохирол нийцлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж байна.
- Үүнээс үүдэлтэй үрчлэлтийн өмнөх болон дараах үе шатанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, үнэлгээ хийх, оношилгоо хийх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дасан зохицох үйл явцыг дэмжих үйлчилгээ огт байхгүй, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн агентлаг үндэсний хэмжээнд байхгүй байна.

Хоёр. Дотоодын хууль тогтоомж, журмууд хоорондоо зөрчилтэй байна.

Зураг** Error! No text of specified style in document.**-4. Монгол улсын дотоод үрчлэлтийн процессийн зураглал



Дээрх процесс, үйл ажиллагаанууд дүүрэг бүрт харилцан адилгүй байгаа шалтгаан нь 2018 онд ИУБтХ-ийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлийн 11.4 “баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулна” гэсэн заалттай шууд хамааралтай. Энэ асуудлыг үүсгээд байгаа эхний гол гогцоо нь Гэр бүлийн тухай хуулинд тусгах ёстой зохицуулалтыг чиглэлийн бус буюу ИУБтХ-нд тодорхой бус байдлаар тусгаж өгсөнтэй шууд хамааралтай юм. Тухайлбал: ИУБтХ-ийн зорилт нь “иргэний улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Гэтэл огтын хамааралгүй хүүхэд үрчлэх асуудалд дүгнэлт гаргахтай холбоотой бүрэн эрх олгосон зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Дээрх зохицуулалт орсноор ХГБЗХХ болон ЗДТГ-ын дэргэдэх нийгмийн хөгжлийн хэлтсүүдийн ажил үүргийн хуваарь давхцдаг болно. Үүнд хүүхэд үрчлэлтийн асуудлаар дүгнэлт гаргахтай холбоотой заалтын хэрэгжилтийг хангахын тулд хүүхэд үрчлэхтэй холбоотой дүгнэлтийг хэн, хэрхэн хийх талаар нарийвчилсан журам батлах ёстой. Гэтэл

хүүхэд үрчлэлтийн асуудалд дүгнэлт гаргахтай холбоотой шинэ журмыг батлаагүй учир дүүрэг бүр өөр өөрсдийн онцлогт нийцүүлэн өөр өөр байгууллага албан тушаалтнаар ялгаатай дүгнэлт гаргуулсаар байна. Мөн нийслэлийн 9 дүүргүүдээс хийж байгаа үнэлгээ болон дүгнэлт нь хүүхэд үрчлэхтэй холбоогүй 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан нөхцөл байдлын үнэлгээний загварыг[173] тэр чигт нь ашиглаж, хүүхэд үрчлэх дүгнэлтийг гаргасаар байна. Уг дүгнэлт нь хүүхэд үрчлэхтэй холбоогүй гэр бүлийн хүчирхийлэлд ашигладаг журам[174] зааврыг тэр чигт нь ашиглаж, хүүхэд үрчлэх дүгнэлтийг гаргаж байгаа нь зохисгүй юм. Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан нь нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргахаар[175] зохицуулсан бол 2016 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1. Нийгмийн ажилтан дараах байдлыг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ гэжээ. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдлыг;
- Хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагаврыг;
- Хохирогчид үзүүлэх үйлчилгээг.[176]

Уг хуулиар нөхцөл байдлын үнэлгээ нь дүгнэлт хэлбэртэй байхаар хуулиар зохицуулсан байна. Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах үүднээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал177 /2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн/ А/120, А/178-аар баталсан журам болон хавсралт нь Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид /цаашид үйлчлүүлэгч гэнэ/ учирсан, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнд учирч болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлох, хариу үйлчилгээг төлөвлөх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор баталсан байна. Эндээс дүгнэн үзэхэд нөхцөл байдлын үнэлгээний журам нь Хүүхэд үрчлэн авахтай холбоотойгоор гаргасан үнэлгээний журам биш тул журамд заасан хавсралт нь Хүүхэд үрчлэн авагч этгээдийн эрх зүйн байдлыг бүрэн дүүрэн тусгах боломжгүй, Гэр бүлийн тухай хуульд заасан хүүхэд үрчлүүлэхтэй холбогдсон нөхцөлүүдийг бүрэн илэрхийлэх боломжгүй журам, заавар болно. Нийслэлийн 9 дүүргээс ярилцлагын аргаар авсан судалгаагаар дүүрэг бүр хүүхэд үрчлэхтэй холбоотой нөхцөл байдлын үнэлгээний загвар нь үнэлгээ хийхэд тохирдоггүй тул тохирсон үнэлгээний загвар гаргах зайлшгүй шаардлагатай гэж 100% хариулсан байна. Мөн судалгаанаас үзэхэд 6 дүүрэг хүүхдийн эрхийн улсын байцаагчгүй, 6 дүүрэг нь Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлэгээг хорооны хамтарсан багаар хийлгэж байна. Хамтарсан багт ийм дүгнэлтүүдийг хийх чадамжтай мэргэжлийн боловсон хүчин байгаа эсэх нь эргэлзээтэй. Учир нь дээрх үнэлгээ тайлан дүгнэлтийг бусад улс оронд /судалгааны ажлын хүрээнд харьцуулан судалсан улс, орнуудад/ сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, гэр бүл судлаач нар хийдэг болно.

[173] “Төрийн мэдээлэл” №06, 2016
[174] “Төрийн мэдээлэл” №06, 2016
[175] “Төрийн мэдээлэл” №06, 2016
[176] “Төрийн мэдээлэл” №47, 2016
[177] Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны сайт https://mlsp.gov.mn/content/detail/1087

Гурав. Дотоодын эрх зүйн зохицуулалт ОУ-ын эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөж байна.

Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт ОУ-ын гэрээ конвенцтэй нийцээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна. Тухайлбал: НҮБ-ын хүүхдийн эрхийн хороо 2009 болон 2010 онуудад Монгол Улсын гурав болон дөрөв дэх удаагийн илтгэлийг хэлэлцээд 2010 оны 1 дүгээр сард дараах дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн. Үүнд:

- хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ;
- үрчлэн авагч эцэг эхэд тавигдах шалгуур;
- үрчлэгчийн гэр бүлд судалгаа хийх;
- хараат бус дүгнэлт гаргах нийгмийн ажлын үйлчилгээ;
- үрчлэгчдийг сургалтад хамруулах;
- үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалд хяналт тавьж, үнэлгээ хийх; зэрэг үе шатуудыг хийх талаар өгсөн зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй байна.[178]

Монголчуудын өнөөгийн хүүхэд үрчлэлтийн практикт хүүхдийн эх хүүхдийг гэдсэнд байхад нь төрөх эмнэлэг болон нийгмийн ажилтнаар дамжуулж гуравдагч этгээдтэй холбогдох, цахим орчинд зар тавих байдлаар мэдээлэл түгээж үрчлэгчид санал болгох, дээрх хэлбэрээр холбогдсон тохиолдолд үрчлэгч хүүхдийг өөрийн биеэр тандаж ажиглаж, харж шалгаж байгаад, шаардлага хангаж байвал асран хамгаалагчтай нь ямар нэг байдлаар тохиролцоонд хүрч /санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх/, хүүхдээ өөр дээрээ авсны дараа үрчлэлтийн бүртгэл хийлгэж хэвшсэн байна. Үрчлэгч үрчлүүлэгч төрийн эрх бүхий байгууллагад урьдчилан хандалгүйгээр өөр хоорондоо ярилцаж, хүүхэд үрчлэх урьдчилсан бүхий л нөхцөлийг тохиролцсоны дараа төрийн байгууллагаар зөвхөн баталгаажуулалт хийлгэдэг үйл явцыг хувийн үрчлэлт гэнэ. Уг хувийн үрчлэлтийн хэлбэрийг Гаагийн конвенцоор хориглодог. Гаагийн конвенцын 29 дүгээр зүйлд "….үрчлэн авагч эцэг эх болон хүүхдийн эцэг эх буюу асран хамгаалагч бусад этгээд конвенцод заасан шаардлага хангагдах хүртэл буюу хүүхдийг үрчлүүлж болохыг тогтоох хүртэл харилцаатай холбоотой байх ёсгүй" гэж заасан. Энэхүү хувийн үрчлэлтийн хэлбэр нь дараах эрсдэлийг бий болгодог байна. Үүнд:


- Мэдээлэл, бүртгэл, үрчлэлтийн процессын үе шатууд, хяналтын механизм байхгүйгээс шалтгаалан үрчлэлтийн харилцаанд оролцогч талуудын эрхийг хамгаалах, үүргийг хангахад эрсдэл саад учруулдаг.
- Үрчлэлт нэрийн доор хүүхэд үрчлэлтийн зөвшөөрлийг зүй бусаар авах, санхүүгийн болон эд материалын дэмжлэг үзүүлэх зэрэг хууль бус практик тогтох
- Үрчлэлт нэрийн дор хүн худалдаалах гэмт хэрэг явагдах
- Бичиг баримт хуурамчаар үйлдэж төрсөн эцэг эхийн нэрийг хууль бусаар солиулах
- Хил дамнасан хууль бус үрчлэлт явагдах
- Хуулиар хориглосон этгээдүүдэд үрчлэлт хийх

[178] НҮБ-ын ХЭХороо, Хүүхдийн Эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх дүгнэлт, зөвлөмж, УБ, 2010 15 дахь тал

- Хамгийн гол нь хүүхдийн амь нас, амьдрал, ирээдүй бүхлээрээ эрсдэлд ордог бөгөөд эрүүл мэнд, сэтгэл санааны нөхөж баршгүй хохирол учируулдаг тул хувийн үрчлэлтийг дэлхий нийтэд хориглосон болно.

Тухайлбал Монгол Улсаас хамгийн их хүүхэд үрчлэн авсан Америк, Герман, Франц зэрэг улсуудын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд үрчлэлтийн мэдээллийн санд байгаа олон мянган үрчлэгдэх боломжтой хүүхдүүдийг, олон мянган үрчлэгчдийг хооронд нь маш олон үзүүлэлтээр нийцлийн үнэлгээ хийж, үр дүнд нь хамгийн тохиромжтой, хамгийн таатай гэр бүлийг бий болгохыг зорьдог байна. Гэтэл Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар хувийн үрчлэлтийн харилцаа хөгжих, хувийн үрчлэлт зайлшгүй хийх урьдач нөхцөлийг хуулиар бүрдүүлэн өгсөн байна. Өөрөөр хэлбэл Гаагийн конвенцоор хориглосон хувийн үрчлэлтийн хэлбэрийг хуулиар зөвшөөрсөн болно. Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6-д Үрчлэн авахыг хүсэгч нь хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргана. Мөн Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар “Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч “хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл” болон холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргад өөрийн биеэр хандана гэж зохицуулсан. Дээрх 2 хуулийн заалтын агуулга нь хүүхэд үрчлэгч үрчлүүлэгчийг болон үрчлэгдэх хүүхдийг урьдчилан өөрөө олохыг үүрэг болгосон гипотез хэм хэмжээг агуулсан зохицуулалтыг хуулиар бий болгожээ. Уг зохицуулалт нь Гаагийн конвенцын 29 дүгээр зүйлд заасан зохицуулалттай шууд зөрчилдсөн хэм хэмжээ юм. Доорх статистик мэдээллээс харахад асрах төвөөр дамжуулан үрчлэгдсэн хүүхдийн тоо хувиараа үрчлэгдсэн хүүхдийн тоотой харьцуулахад дэлхий нийтэд хориглогдсон хувийн үрчлэлтийн хууль бус практик Монголд түгээмэл голлох хэлбэр болон оршиж байна гэдэг нь харагдаж байна.

Зураг** Error! No text of specified style in document.**-5. Монгол Улсын хэмжээнд 2018-2023 онд үрчлэгдсэн хүүхдүүдийн үрчлэлтийн хэлбэр[179]



Дөрөв. Асрамжийн газраас хүүхэд үрчлэх нь хангалттүй байна.

[179] ҮСХ болон ГБХЗХГ-ын 2022 оны тайлан, мэдээ УБ, 2022, 31 дэх тал

ҮСГ-ын мэдээнээс үзэхэд жилд дунджаар асрамжийн газраас гадаад болон дотоодод маш цөөн тооны хүүхэд үрчлэгдэж байна. МУ-д үйл ажиллагаа явуулж байгаа асрамжийн 21 төв нь 1000 орчим хүүхэдтэй хэдий ч сүүлийн 5 жилийн хугацаанд 23 хүүхэд үрчлэгдсэн байна. Асрамжийн газраас хүүхэд үрчлэх боломжгүй байгаа, эсвэл цөөн тооны хүүхэд үрчлэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг илрүүлэхийг зорилоо. Судалгаанд оролцогч байгууллагуудыг сонгохдоо хамгийн их хүүхэдтэй, дотоод гадаадад хамгийн их хүүхэд үрчилсэн асрамжийн газруудыг сонгосон болно. Тухайлбал сүүлийн 5 жилийн хугацаанд Өнөр бүл /189/ 3, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор /132/ үрчлэлт хийгээгүй, Мана төв /35/ 7, Хүүхдийн төв сувилал нярай 8, Гэрэл төв /32/ 2 /уг төв нь сүүлийн 15 жилд 30 хүүхэд гадаадад үрчилсэн байна/ байна. Судалгаанд хамрагдсан дээрх 6 асрамжийн газрын хувьд сүүлийн 5 жилд 20 хүүхэд үрчлүүлсэн нь нийт үрчлэлтийн 87%-ийг эзэлж байна. Үлдсэн 3 хүүхдийг Итгэл найдвар болон Эрдэм төвүүд үрчлүүлсэн байна. Дээрх дүнгээс үзэхэд нийт 17 асрамжийн төвөөс 6 төв л сүүлийн 5 жилд хүүхэд үрчлүүлсэн байна. Үлдсэн 11 төв нь ямар шалтгаанаар хүүхэд үрчлүүлдэггүй вэ гэдэг нь тодорхойгүй. Цаашид зайлшгүй судлах шаардлагатай гэж үзэж байна. Асрамжийн газруудаас авсан судалгааны хариултаас үзэхэд дараах нийтлэг асуудлуудыг илэрхийлсэн болно. Үүнд: Эцэг эх, төрөл садан нь зөвшөөрдөггүй, эцэг эх, төрөл садан нь олддоггүй учир зөвшөөрөл авах боломжгүй, олдмол учир бичиг баримтгүй, хэн болох нь тодорхойгүй, гэрийн хаяг нь тодорхойгүй, эрүүл мэндийн шалтгаантай буюу ямар нэгэн өвчтэй, удаан хугацаагаар асрамжийн газарт өссөн учир хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт хүүхдүүдийг үрчлүүлэх тусгай журамгүй, нэг айлын олон хүүхэд байдаг учир салгаж үрчлүүлэх боломжгүй, үрчлэгч бага насны хүүхэд үрчлэн авах сонирхолтой байдаг зэргээс шалтгаалж үрчлэгдэх хүүхэд олддоггүй гэсэн хариултууд зонхилж байна. Хүүхдийг асрамжийн газарт байрлуулахаас илүү үрчлэлтээр дамжуулан шинэ гэр бүлтэй болгох нь хүүхдийн сайн сайхан байдал, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, оюун санааны болон нийгмийн хөгжил, ирээдүйд илүү сайн нөлөөтэй гэдэг нь батлагдсан практик юм. Асрамжийн газарт өсөж хүмүүжсээр байгаа эдгээр хүүхдүүд нь үрчлэлтээр дамжуулан шинэ гэр бүлтэй болох боломжтой хүүхдийн тоо юм. Өөрөөр хэлбэл энэ тоо их байх нь сайн зүйл огт биш юм. Дэлхий нийт 2000 оноос эхлэн асрамжийн газарт хүүхэд байлгахаас илүүтэйгээр үрчлэх нь гэр бүлийг орлох хамгийн сайн хувилбарт систем гэдгийг хүлээн зөвшөөрсөн ч Монгол Улсад нөхцөл байдал эсрэгээр байгаа нь хүүхдийн эрхийг хангаж хамгаалж байна гэж үзэхэд учир дутагдалтай юм.


№	Байгууллагын нэр	Хүүхдийн тоо	АСУУЛТ			
			Асрамжийн газрын хүүхдүүдтэй гэр бүл, төрөл садангийн хүмүүсээс хэдэн хувь нь уулзахаар ирдэг вэ?	Хүүхэд үрчлэн авах хүсэлт хэр ирдэг вэ?	Үрчлэлт буцаагдсан тохиолдол байгаа эсэх, шалтгаан үндэслэл нь юу байсан бэ?	Хүүхэд үрчлүүлэхэд тулгамдаж буй асуудал, үрчлэлт хийгдэх боломжгүй шалтгаан юу вэ?
1	Хүүхдийн асрамжийн Өнөр бүл төв	189	• 30-40% • Жилд 1-2 удаа	Жилд 10 орчим хүн ирдэг	• Буцаагдсан тохиолдол 5 • Эрүүл мэндийн шалтгаанаас болж буцаасан • Гэр бүлийн харилцаа • Хүүхдийн зан байдал, төлөвшил	• Нэг айлын хүүхдүүд салгах боломжгүй, ах дүү нар зөвшөөрдөггүй. • Эцэг эх нь олддоггүй учир зөвшөөрөл авах боломжгүй. • Бичиг баримтын зөрчилтэй
2	Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	132	• 90%	Хүүхэд үрчлүүлэх хууль байдаг ч төрийн асрамжид амьдарч буй хүүхдэд зориулсан үрчлэлтийн журам байдаггүй	Үрчлэлт хийгдээгүй	• Хүүхдүүд том болж ухаан суусан хойноо ирдэг. /4 нас/ • Ар гэр нь зөвшөөрдөггүй
3	Хүүхдийн асрамжийн Манаа төв	32	• 30-35%	• Ирсэн хүмүүсийг дүүргийн НХХ явуулдаг. • Тодорхой тоо хэлж мэдэхгүй байна.	Буцаасан тохиолдол байхгүй	• Эцэг эх нь олддоггүй учир зөвшөөрөл авах боломжгүй. • Хөгжлийн хоцрогдолтой
4	Хүүхдийн асрамжийн Гэрэл төв	32	• 20% • Жилд 1-2 удаа	7 хоног бүр 1-2 удаа үрчлэх хүсэлт ирдэг.	Буцаасан тохиолдол байхгүй	• Ар гэр нь зөвшөөрдөггүй • Эцэг эх нь олддоггүй учир зөвшөөрөл авах боломжгүй. • Хөгжлийн хоцрогдолтой эсвэл өвчтэй
5	Монголын хүүхдийн сан	32	• 40% • Жилд 2-3 удаа	Сард 5 орчим хүн ирж уулздаг.	• Үрчлэлт хийгдээгүй • Бүтэн өнчин болон бага насны хүүхэд байхгүй.	• Бүтэн өнчин хүүхэд байхгүй • Бага насны хүүхэд байхгүй • Ар гэр нь зөвшөөрдөггүй • Эцэг эх нь олддоггүй учир зөвшөөрөл авах боломжгүй. • Зөвшөөрөл өгөх этгээд байхгүй.

6	Хүүхдийн төв сувилал	15	• 46.7% - асран хамгаалагчгүй, бүтэн өнчин, эсвэл эцэг эх байхаас татгалзсан (ар гэргүй) • 53.3% - эцэг эх, төрөл садантай (ар гэртэй) • 20% - жилд 1-3 ирдэг. • 33.3% - архины хамааралтай. Жилд 1 ирэхдээ согтуу ирдэг.	0-3 насны хүүхдийг үрчилж авахаар жилд 30-35 орчим хүн ирдэг	• Сүүлийн 5 жилд гадаад 2, дотоод 9 үрчлэлт хийгдсэн. • Буцаасан тохиолдол байхгүй • Үрчлэлтийн шийдвэр гаргах эрхгүй	• Олдож ирсэн хүүхдийн эцэг эхийг тогтоох, үрчлэлтийн зөвшөөрөл авах боломж муутай. • Ихэнх тохиолдолд хаяг, бичиг баримт тодорхойгүй • Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэлтэй, хүүхдээ хаясан хүмүүс хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд байлгадаг ч хүүхдээсээ татгалздаггүй учир зөвшөөрөл өгдөггүй. • Нярай хүүхдүүдийг оношлох боломж муу, эрүүл мэндийн асуудал хожим илрэх эрсдэлтэй. • Удаан хугацаанд асрамжийн газарт байдаг учраас нийгмийн хөгжил, хөгжлийн хоцрогдолтой, хүнд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байдаг. • ГИХАЭА-с Итали улсын гэр бүл ирсэн ч хүүхдийн биеийн байдлаас шалтгаалан үрчлэхээс татгалзсан.

Тав. Бүртгэл мэдээллийн тогтолцоо хангалттай хөгжөөгүйн улмаас хүүхдэд аюултай нөхцөл байдал үүсэж байна.

Монгол Улсын хувьд үрчлэх үрчлүүлэх хэрэгцээ бүхий иргэдэд үйл явцын талаар мэдээлэл өгөх, чиглэл өгөх, өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах, баримт материал бүрдүүлэх, үрчлэлтийн үйл явцын бүртгэл хөтлөх, статистик, тайлан мэдээ гаргах, мэдээллүүдийг хэрэгцээт хэрэглэгчид өгөх гэх мэт олон талбарын олон янзын хэрэглэгчдэд чухал шаардлагатай мэдээллийн нэгдсэн систем дутагдаж байна. Энэ систем нь үрчлэлтийн харилцаанд оролцогч олон янзын хүмүүст цаг хугацаа, эдийн засаг, эд материал, сэтгэл зүйн өртгийг бууруулах, хөдөлмөрийн бүтээмж, процессын үр ашгийг сайжруулах ач тустай юм. Нэг жишээ хэлэхэд хүүхэд үрчлэлтийн чиг үүргийн байгууллагууд нь хуулиар хориглосон этгээдэд хүүхэд үрчлэлт хийж байгаа эсэхээ мэдэх, хянах, эрсдэлтэй нөхцөл байдлаас сэргийлэхтэй холбоотой ямар ч зохицуулалт алга байна. Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2. “эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй”...хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно гэж заасан. Гэтэл дээрх хуулиар эрх нь хасагдсан, хориглогдсон этгээд хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан тохиолдолд баримт материалыг шалгахгүйгээр үрчлэлтийн бүртгэл хийж хэвшсэн нь 9 дүүргийн ГБХЗХХ-ээс авсан судалгаагаар батлагдаж байна.

*Зураг Error! No text of specified style in document.**-6. 2019-2022 оны байдлаар Улсын хэмжээнд үрчлэлтийн материалыг шалгасан байдал*[180]



Тухайлбал: 2019 онд 1667 2020 онд 1519 %, 2021 онд 1261, 2022 онд 1478, 2023 онд 1421 хүүхэд үрчлэлт хийснээс зөвхөн ял шийтгэх лавлагааг л шалгаж авдаг байна. Шүүхээс эцэг, эх байх эрхийг хязгаарласан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн буюу үрчлэлтийг хүчингүйд тооцсон, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон зэрэг тохиолдлуудад иргэний хэргийн шүүхээс гаргасан шийдвэр, магадлал, тогтоол зэрэг баримтыг шалган авах ёстой юм. Хүүхэд үрчлэхэд үрчлэгчээс зөвхөн ял шийтгэлийн лавлагааг л шалгаж авдаг байна. Судлагаанаас үзэхэд 2019-2023 оны материалаас хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн материалыг хүлээн авч шаардлага хангасан эсэхийг хянахдаа дээрх шүүхийн шийдвэрүүдийг холбогдох

[180] НГХЗХГ-ын 2002 оны IV дүгээр улирлын тайлан. УБ, 2023, 21 дэх тал

байгууллагуудаас лавлагаагаар гаргуулан авсан тохиолдол огт байхгүй байна. Дээрх бүртгэлийн баримт бичгүүд дутуу байгаа нь хуулиар хориглосон этгээдэд хүүхдүүдийг үрчилж байх магадлалтай бөгөөд үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалж чадахгүй байгаагийн тод илрэл мөн. Харин эрүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн эсэхтэй холбогдсон материал болох ял шалгах хуудсыг дүүрэг бүр шалгаж хүүхэд үрчлэлтийн материалд хавсаргаж хэвшсэн байна.

Зургаа. Гадаадад үрчлэгдсэн хүүхдийн судалгаа, хяналт, хамгаалал

Хүснэгт** Error! No text of specified style in document.**-3. 2001-2023 оны хооронд гадаадад үрчлэгдсэн хүүхдийн тоон мэдээлэл[181]

Д/д	Улсын нэр	Гаагийн конвенцод нэгдэн орсон улс	Хүүхэд үрчлэллтэй холбоотойхарилцан туслалцаа үзүүлэх гэрээтэй улс	Нийт
1	Америкийн Нэгдсэн Улс	2008-04-01	байгуулагүй	157
2	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	2002-03-01	1969.04.30	35
3	Бүгд Найрамдах Итали Улс	2000-05-01	байгуулагүй	23
4	Бүгд Найрамдах Франц Улс	1998-10-01	байгуулагүй	20
5	Бүгд Найрамдах Солонгос Улс	Ороогүй	байгуулагүй	7
6	Нидерландын Хаант Улс	1998-10-01	байгуулагүй	6
7	Бельгийн Хаант Улс	2005-09-01	байгуулагүй	6
8	Австрали Улс	1998-12-01	байгуулагүй	4
9	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	2003-06-01	байгуулагүй	4
10	Канад Улс	1997-04-01	байгуулагүй	3
11	Япон Улс	Ороогүй	байгуулагүй	2
12	Оросын Холбооны Улс	Гарын үсэг зурсан ч	байгуулагүй	2
13	Румын Улс	1995-05-01	байгуулагүй	2
14	Данийн Хаант Улс	1997-11-01	байгуулагүй	1
15	Испанийн Хаант Улс	1995-11-01	байгуулагүй	1
16	Финлянд Улс	1997-07-01	байгуулагүй	1

[181] ГИХА эрхлэх албаны тайлан, УБ, 2022, 44 дэх тал

17	Шведийн Хаант Улс	197-09-01	байгуулаагүй	1
18	Шинэ Зеланд	1999-01-01	байгуулаагүй	1
	Нийт			276

ГИХАЭА-аас гаргасан тоон мэдээнээс үзэхэд Монгол Улс нь 1999-2023 оныг хүртэлх хугацаанд нийт 18 улсад 277 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн. Нийт үрчлэлтийн 57% нь АНУ, 13% нь ХБНГУ, 9% нь Франц улс, 7% нь Итали улсад хийгдсэн бөгөөд эдгээр 4 улс нийлээд нийт үрчлэлтийн 86%-ийг эзэлж байна.

*Зураг Error! No text of specified style in document.**-7. 2001-2023 оны хооронд гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн тоон мэдээлэл***[182]



Судалгаанаас үзэхэд 2001 оноос гадаад үрчлэлт эхлэхэд эхний 5 жил 100 гаруй хүүхдийг үрчилсэн байна. Хамгийн их үрчлэлт хийсэн жил нь 2003 онд 35 хүүхэд үрчилсэн бол 2021 онд огт үрчлэлт хийгдээгүй байна. 2018 оноос хойш үрчлэлт эрс буурснаар тогтмол 1-2 үрчлэлт хийгдэж байна. МУ-ын хувьд гадаад үрчлэлтийн талаар баримтлах бодлого, журам огт хангалтгүй, үрчлэгдсэн хүүхдүүдийн нөхцөл байдлын судалгаа, хэвийн өсөж бойжиж байгаа эсэх талаарх тандалт судалгаа огт байхгүй байна. Монгол улсаас гадаад улсад үрчлэгдэж байгаа хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаарх зохицуулалт огт байхгүй байна. Тухайлбал: Гадаадад үрчлэгдсэн хүүхдийн үрчлэгч эцэг эх хүнд өвчин тусах, хөдөлмөрийн чадвараа алдах, мансууруулах бодисын хамааралтай болох, сэтгэцийн өвчтэй болох, хүүхэдтэй таарамжгүй харилцаатай болох, гэмт хэрэгт холбогдох, шоронд орох, амь насаа алдах, сураггүй алга болох гэх мэт шалтгаанаар харж хандах боломжгүй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, эсвэл хүүхдэд сэтгэл санаа болон бие махбодын, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, үйлдэхээр завдсан, хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд татан оролцуулсан, аюултай нөхцөл байдалд оруулсан гэх зэргээр хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирсон тохиолдолд, хүүхдийг эх оронд нь буцаах, эрх ашиг сонирхлыг нь хамгаалах асуудлыг огт зохицуулж өгөөгүй байна. Энэ нь Гаагийн конвенцын 21 дүгээр зүйлд заасан “үрчлэн авсан эцэг, эхтэй цаашид хамт байлгахад хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах” зохицуулалтыг бүхэлд нь орхигдуулсан байна.

Долоо. Гадаадын иргэд хүүхэд үрчлэн авахад тулгамдаж буй асуудал

[182] ГИХА эрхлэх албаны тайлан, УБ хот.,2022 44 дэх тал

*Зураг Error! No text of specified style in document.**-8. 1999-2023 оны хооронд Монгол улсаас гадаад үрчлэлтийг хийхэд оролцсон зуучлагч байгууллагуудын тоо***[183]**



Дээрх 9 олон улсын байгууллагын 4 нь байршиж үйл ажиллагаа явуулдаг бол 5 нь Монгол Улсад төлөөлөгч томилуулан ажиллуулдаг байсан байна. АНУ-д харьяалалтай 3 байгууллага, БНИУ-д харьяалалтай 3 байгууллага, ХБНГУ, БНФУ, Нидерландын Хаант Улсын харьяалалтай тус тус нэг байгууллага байна. Дээрх байгууллагуудаас 6 байгууллага нь үйл ажиллагаа явуулахаа больсон байна. 2023 оны байдлаар Монгол Улсад ОУ-ын хүүхэд үрчлэлтийн 3 байгууллага байнгын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- АНУ-ын харьяат Holt international ОУТББ;
- БНИУ-ын харьяат Amici Di Don Bosko,
- I Fiori Semplici Onlus.

Гадаад үрчлэлтийн графикийг харахад 2012 оноос хойш жил ирэх тусам хүүхэд үрчлэлт багассаар сүүлийн 5 жилийн хугацаанд ердөө 7 хүүхэд гадаад улс оронд үрчлэгдсэн байна. МУ-аас гадаад улсад үрчлүүлсэн нийт 277 хүүхдийн 176 нь олон улсын хүүхэд үрчлэлтийн итгэмжлэгдсэн 9 байгууллагаар зуучлуулан үрчлэгдсэн байна. Дээрх 9 байгууллагын хувьд нийт үрчлэлтийн 63.7 хувийг эзэлж байна. Дээрх судалгаануудаас үзэхэд гадаад үрчлэлтийн дийлэнх хэсгийг зуучлалын байгууллагууд бүрдүүлдэг хэдий ч уг байгууллагуудын тоо 3 дахин цөөрснөөр гадаад үрчлэлтийн тоон үзүүлэлтэд шууд нөлөөлж байгаа нэг үндэслэл мөн болно. Дээрх 6 итгэмжлэгдсэн байгууллагаас Монгол Улсад төлөөлөгч томилуулан үйл ажиллагаа эрхлэхээ больсон талаарх мэдээлэл ГИХАЭА байхгүй болно. Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авахад туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагын тоо гурав дахин цөөрсөн нь дараах шалтгаантай гэж судалгаанд оролцсон олон улсын байгууллагууд үзсэн байна. Үүнд: Үрчлэгдэх боломжтой хүүхдүүдийн улсын хэмжээний нэгдсэн судалгаа, жагсаалт байхгүй, тухайн ажлыг хариуцан тогтмол мониторинг хийдэг байгууллага тодорхой бус байгаагаас тухайн гэр бүлд хүүхэд сонгох үйл явц хэт удаан хугацаа шаарддаг. Зарим олон улсын байгууллагаас гаргасан судалгаагаар давхар батлагдаж байна. Мөн дээрх 3 байгууллагаас Улсын асрамжийн газраас Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх процесс хийгдэхгүй байгаа шалтгааныг дараах асуудалтай холбож тайлбарласан байна. Үүнд: Асрамжийн газарт байгаа

[183] “ҮСХ-ны тайлан” УБ, 2022, 103 дахь тал


хүүхдүүдийн дийлэнх нь хагас өнчин буюу эцэг эхийн аль нэг нь байгаа, эсхүл өөр төрөл садангийн хүмүүс нь байдаг. Харин АНУ-ын цагаачлалын албаны журмаар бусад улсаас үрчлэгдсэн хүүхэд нь заавал бүтэн өнчин гэсэн статустай байна. Ийм тохиолдолд тус улсад амьдрах виз олгоно.

Тус газарт хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд тусгай хэрэгцээт хүүхэд байдаг хэрэв ийнхүү хүүхдүүдийг үрчлүүлэхийг зөвшөөрч байгаа бол онцлог журам хэрэгтэй гэж үзсэн байна. Дээрх асуудлыг тодруулах зорилгоор Үрчлэлтийн зөвлөлийн зарим гишүүд болон хүүхдийн асрамжийн газруудтай уулзахад дараах зүйлсийг өгүүлсэн болно. Үүнд:

- Үрчлэлтийн зөвлөлийн гишүүд: Үрчлэлт хийхэд хэт удааширсан тохиолдол өмнө нь гарч байсан талаар хүлээн зөвшөөрч байна. Мөн асрамжийн газруудаас үрчлүүлэх боломжтой хүүхдийн талаарх мэдээлэл хангалтгүй, цөөн тоотой ирдэг хэмээн хэлсэн болно.
- Асрамжийн газрын удирдлагууд: Асрамжийн газарт байгаа хүүхдүүд эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй буцсан, эцэг эх нь олдохгүй учир үрчлүүлэх зөвшөөрөл авах боломжгүй, мөн эцэг эх болон ах дүү нар нь үрчлэлт хийлгэх хүсэлгүй байдаг учир үрчлэлтийн зөвлөлөөс ирүүлсэн албан тоотод үрчлэгдэх боломжтой цөөн тооны хүүхдүүдийн мэдээллийг илгээдэг тухай хэлсэн болно.

Иймд дээрх асуудал нь тулгамдсан бөгөөд эрх зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг **Error! No text of specified style in document.**-9. Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх процессын зураглал



Найм. Үрчлэлтийн нууц ба мэдэх эрхэд тулгамдсан асуудал

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар хүүхэд үрчлэлтийн харилцааг нууцад хамааруулсан болно. Гэр бүлийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Үрчлэлтийн нууцыг мэдэж байгаа албан тушаалтан, бусад этгээд түүнийг хадгалах үүрэгтэй.” Мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “Үрчлэгч болон үрчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үрчлэлтийн нууцыг задруулсан бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Гэр бүлийн тухай хуулиар үрчлэлтийн нууцыг хэн хэзээ ил болгох, эцэг эхээ мэдэх эрхийг хангахтай холбоотой зохицуулалтыг огт тусгаж өгөөгүй. Мөн үрчлэлтийн нууцыг задруулсан тохиолдолд ямар арга хэмжээг хэн авахтай холбоотой зохицуулалт огт байхгүй. Гэр бүлийн тухай хуулиар уг зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой процесс хэм хэмжээг огт тусгаж өгөөгүй. Гэтэл амьдрал дээр зарим чадамжтай буюу 7-гоос дээш настай хүүхдүүд төрсөн эцэг эхээ, гэр бүлийн гишүүдээ санаж бэтгэрэх уулзах хүсэл нь маш их байдаг болно. Гэтэл уг эрхийн талаар тодорхой зохицуулалт Гэр бүлийн тухай хууль болон бусад хуулиар олгож өгөөгүй байна. Учир нь хүүхэд өөрийн эцэг эхээ, биологийн гарал үүслээ мэдснээр өөрийн овог удмаа мэдэх, удамшлын болон бусад өвчний түүхээ мэдэх, ирээдүйд үүсч болох аливаа эрсдэлээс хамгаалуулах боломжийг хуулиар үрчлэлтийн нууц нэрээр хааж халхалж байгааг өөрчлөх шаардлагатай байна. Судалгааны ажилд харьцуулан судалсан Хятад, Америк, Франц, Герман зэрэг улсуудын

эрх зүйн зохицуулалтад эцэг эхээ мэдэх эрх, мэдээллийг ил болгох асуудлыг нээлттэй байлгах тал дээр илүү анхаарч ажиллаж байна. Учир нь үрчлүүлэгчид үрчлэгдсэн хүүхдээ хайх, үрчлэгдэгч хүүхдүүд төрсөн эцэг эхээ хайх, мэдээлэлд хандах эрх, зуучлагч байгууллага мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах зэрэг асуудал нь олон улсын түвшинд шинээр тулгамдаж буй асуудлууд болсоор байна.

Зургаа. Дүгнэлт, санал

Монгол Улс нь олон ургалч үзлийг дээдэлж, Монгол Улсад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноо Үндсэн хуулиар тунхаглан зарласнаар даруй 31 жилийн хугацаа өнгөрсөн байна. Гэр бүлийн тухай шинэ хууль 1999 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс үйлчилж эхэлснээс хойш 2018 онд батлагдсан Иргэний улсын бүртгэлийн тухай хууль үйлчлэх хүртэлх хугацаанд үрчлэн авагчийн өргөдөл холбогдох материалыг үндэслэж үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж байсан болно. Дээрх хууль батлагдсанаар гэр бүл нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Засаг даргаас үрчлэлтийн захирамж гаргах эрхийг олгосноор тодорхой хэмжээнд үрчлэн авагчийн нөхцөл байдлыг таних боломж бүрдсэн хэдий ч өнөөдрийг хүртэлх хугацаанд хүүхэд үрчлэлтийн бодлогод хангалттай ахиц өөрчлөлт гараагүй гэж үзэж болохоор байна.

Нэг. Монгол улс “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” Гаагийн конвенцод нэгдэн орсон тул ОУ-ын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. Түүний тулд МУ-ын нэгдэн орсон ОУ-ын гэрээ конвенцод хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг нийцүүлэх, Гэр бүлийн тухай хуульдаа зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах зүй ёсны шаардлага гарч урган гарч байна. Тухайлбал: МУ-ын нэгдэн орсон Хүүхэд үрчлэлтийн ОУ-ын гэрээ конвенцуудад төрийн хяналтгүй хувийн үрчлэлтийг хориглодог бөгөөд Монголд түгээмэл байгаа энэхүү практик нь ОУ-д хүн худалдаалах гэмт хэрэг, хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, хил дамнуулан хууль бусаар үрчлэх, хуулиар хориглосон этгээдүүдэд үрчлүүлэх зэрэг хүүхдэд онц аюултай үр дүнд хүргэх дамжлага болдог гэж үздэг байна. Тийм учраас хувийн үрчлэлтийн хэлбэрийг хуулиар хориглох шаардлагатай бөгөөд үүнд хяналт тавих механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн нөгөө талаас хувийн үрчлэлтийн энэхүү хэлбэрийн практикт түгээмэл байгаа учир шалтгаан нь нэгдсэн тогтолцоо, журам, мэдээллийн институт байхгүйтэй холбоотой юм. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хэрэгцээ шаардлага нийгэмд байх нь зүй ёсны хэрэг, хэвийн үзэгдэл бөгөөд үүнийг зохицуулах төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх институт, дагаж мөрдөх хууль журам, зохицуулах чиг үүргийн байгууллага, энэхүү үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх мэргэжлийн агентлагийн үйлчилгээ шаардлагатай байдаг. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хэрэгцээ шаардлага бүхий хүмүүст мэдээлэл өгөх, санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авах, баримт бичиг хүлээн авах, цахимаар дамжуулан туслалцаа үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хүүхэд үрчлэлтийн талаарх бүх төрлийн мэдээллийг бүртгэх, хадгалах, зохион байгуулах, нийтлэх гэх мэт чиглэлээр цахим систем байгуулах, түүнийг ГБХЗХГ-ын дэргэдэх Үрчлэлтийн нэгжид харьяалуулах шаардлагатай гэж үзэж байна. Хүүхэд үрчлэлтийн мэдээллийн санг бий болгох, уг санд дараах мэдээлүүдийг оруулж өгөх шаардлагатай байна. Үүнд:

- Үрчлэгдэгч хүүхдийн үнэлгээ
- Үрчлэн авагчдын үнэлгээ

- Үрчлэгч, үрчлэгдэгчдийн нийцлийг тогтоох
- Эмнэлгийн дүгнэлт
- Үрчлэлтийн дараах тайлан
- Ял шийтгэлтэй эсэх лавлагаа, эцэг эх байх эрх нь хасагдсан, хязгаарлуулсан, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй, хязгаарлагдмал чадамжтайд тооцсон шүүхийн шийдвэр
- Үрчлэлтийн хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр
- Хүүхдийн асрамжийн газруудад байгаа үрчлэгдэх хүүхдийн мэдээлэл
- Төрөхөөс авахуулаад үрчлэгдэх хүртэлх хугацааны эрүүл мэндийн түүх, үзлэгийн түүх, өвчлөлийн түүх
- Үрчлэлтийн дараах хяналт тавьсан байдал
- Үрчлэгдсэн хүүхдээс эрх зөрчигдсөн хүүхдүүд
- Үрчлэгдсэн хүүхдийн зөвшөөрөл, холбогдох бүхий л бичиг баримт
- Зөвлөн туслах төрөл бүрийн үйлчилгээ /үрчлэлтийн өмнөх болон дараах/
- Эмнэлгийн болон сэтгэл заслын үйлчилгээнд хамрагдсан байдал
- Үрчлүүлэх боломжтой хүүхдийн нэгдсэн жагсаалт
- Үрчлэгч, үрчлүүлэгчдийн мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах зэрэг цогц мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сантай болох шаардлагатай байна.

Хоёр. Хүүхэд үрчлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хүүхэд үрчлэлтийн практикийг ОУ-ын жишигт хүргэх чиглэлээр шаардлагатай өөрчлөлтийг Гэр бүлийн тухай хуулинд тусгах, түүнд нийцүүлэн журам боловсруулах нь чухал бөгөөд судалгаанаас үзвэл, Гэр бүлийн хуулийн шинэчлэн найруулгын төслийн 63 дугаар зүйлийн 63.5. *”Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан үрчлүүлэх хүүхэд, үрчлэх гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж Зөвлөлд хүргүүлнэ”*. гэж заасан. Гэтэл бодит байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийж, үрчлэгдэгч болон үрчлэгчдийн эрх зүйн байдлыг, сэтгэл зүйн байдлыг, үрчлэх зайлшгүй шаардлагатай эсэхийг тогтоох зэрэг үйл ажиллагааг хийж чадах мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг зохих ажилтанд олгох шаардлагатай. Хүүхэд хамгааллын тухай хуулиар *“нийгмийн ажилтан" гэж баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг* гэж тодорхойлжээ. Мөн Нийгмийн халамж болон Боловсролын ерөнхий хуулиар мөн өөр өөр чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байгаа нь нийгмийн ажилтан дангаар нөхцөл байдлын болон бусад үнэлгээг хийх боломжгүй юм. Иймээс өмнөх бүлэгт хүүхэд үрчлэхэд тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, уг асуудлын хүрээнд хорооны нийгмийн ажилтны зүгээс хүүхдийн хувь заяаг шийдвэрлэх үнэлгээнүүдийг мэргэжлийн өндөр түвшинд олон талаас нь бодитой үнэлж байгаа эсэхэд эргэлзээтэй байна. Энэ нь нөхцөл байдлын үнэлгээг ганцхан мэргэжилтэн тодорхойлох боломжгүй болохыг судалгааны ажлын хүрээнд харьцуулалт хийсэн Хятал, Америк, Герман, Франц зэрэг улсуудын жишээнээс харж болно. Гэр бүийн тухай хуулийн

төслийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл ажиллана” гэж заасан нь хангалтгүй бөгөөд бие даасан хуультай, тодорхой чиг үүрэг бүхий бүтэцтэй /ХГБЗХХ/ байгууллагатай атлаа хүүхэд үрчлэлтийн асуудлыг Засаг даргын чиг үүргээр хязгаарласан нь үр дүнгүй байна. Судалгаанаас үзэхэд Нийслэлийн 9 дүүргийн ХГБЗХХ болон ЗДТГ-ын дэргэдэх нийгмийн хөгжлийн хэлтсүүд үрчлэлтийн нөхцөл байдлын үнэлгээ дүүрэг бүрт харилцан адилгүй гаргаж байгааг өмнөх бүлэгт харуулсан болно. ХГБЗХГ дангаараа хүүхэд үрчлэлтийн үйл ажиллагааг хариуцан ажиллахад хамгийн оновчтой болохыг олон улсуудын туршлагаас харагдаж байна. Иймд судлаачийн зүгээс хүүхэд үрчлэлтийн асуудлыг ХГБЗХГ-т хариуцуулах хэрэгтэй бөгөөд дараах үйл ажиллагааны процесс шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Гадаад болон дотоод үрчлэлтийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх,
- Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хуулинд тусгах талаар санал боловсруулах, хүүхэд үрчлэлтийн хуулийн хэрэгжилтийг хангах, журам батлах, хэрэгжүүлэх
- Үрчлэлтийн үе шатыг тодорхойлох, түүний биелэлтийг хангах
- Дотоодын болон улс хоорондын үрчлэлтийн талаарх бүх төрлийн мэдээллийг бүртгэх /иубтх-д заасан чиг үүргээс бусад/, хадгалах, зохион байгуулах, нийтлэх, үрчлэлтийн мэдээллийн нэгдсэн цахим систем байгуулж ажиллуулах
- Үрчлэх гэр бүл болон үрчлэгдэх хүүхдийн талаар эрсдлийн, нөхцөл байдлын, гэр бүлийн орчны гэх мэт бие даасан, хараат бус үнэлгээ гаргах,
- Үрчлэлтийн өмнөх болон дараах үнэлгээ, оношилгоо хийх, түүнд шаардлагатай бичиг баримт, арга хэрэгслүүдийг боловсруулах,
- Үрчлэгч, үрчлэгдэгч болон үрчлүүлэгчийн талаарх нэгдсэн судалгаа хийх, үрчлэлтийн дараах тандалт судалгаа хийх,
- Үрчлэлтийн өмнөх болон дараах зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх
- Үрчлэлтийн шийдвэр гаргах, үрчлэлтийг цуцлах санал гаргах,
- Үрчлэлтийн дараах хяналт, болон дэмжлэг
- Хүүхэд үрчлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, мэргэжилтнүүдэд сургалт зөвлөгөө явуулах, хяналт тавих
- Хориглосон этгээдэд хүүхэд үрчлүүлэхээс хамгаалах, хяналт тавих
- Хүүхдийн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн талаар холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулах, хяналт тавих
- Эрх нь зөрчигдсөн хүүхдийг хамгаалах талаар арга хэмжээ авах,
- Дотоодын асрамж халамжийн газруудын үйл ажиллагаанд хяналт тавих, харьяалагдаж буй хүүхдүүдийн мэдээллийг нэгтгэх
- Асрамжийн газарт байгаа хүүхдийг гадаад болон дотоодод үрчлүүлэх асуудлаар шийдвэр гаргах,
- Хүүхэд үрчлэлтийн шийдвэр гаргах дээд хугацааг оноож өгөх

Гурав. Хүүхэд үрчлэлтийн ОУ-ын сайн практикийг Монголд нэвтрүүлэх, дотоодын практикийг сайжруулах хүрээнд хүүхэд үрчлэлтийн **үе шатыг** дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Үрчлэлтийн хүсэлт хүлээн авах үе шат. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хүсэлтэй эцэг эхчүүд чиг үүргийн байгууллагад хүүхэд үрчлэх болон үрчлүүлэх хүсэлт гаргана.
- Бэлтгэл ба мэдээллийн үе шат. Хүүхэд үрчилж авахаар хүсэлт гаргасан эцэг эхчүүдэд үрчлэлтийн үе шатны мэдээлэл өгөх, үрчлэлтийн журам, хууль эрх зүйн асуудал, шаардлагатай бэлтгэл ажил, үрчлэлтийн үйл явцад тулгарах бэрхшээл зэрэг асуудлаар мэдээлэл өгч, сургалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.
- Хүүхдийг үрчилж болох эсэхийг урьдчилан тогтоох үе шат. Эхлээд үрчлэгдэгч хүүхэд болон үрчлэн авагч эцэг эхийн хооронд тохирол нийцлийг шалгадаг. Энэ нь үрчилж авах эцэг эхийн хүсэл шаардлага, шинж чанар, хүүдийн эрх ашгийг харгалзан үздэг бөгөөд тохирол нийцэл сайн байх нь үрчлэлтийн дараах сөрөг үр дагаврыг бууруулдаг. Мөн хүүхэд үрчлүүлэхээс өмнөх эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээг үрчлэгдэгч болон үрчлэгч дээр хийнэ.
- Эцэг эх болон хүүхдийн уулзалтын үе шат. Үрчлэн авах хүсэлт гаргасан эцэг эхчүүд хүүхэдтэй уулзаж танилцах, өөрийн биеэр харж шалгах боломжийг олгодог.
- Үрчлэх, үрчлүүлэх үе шат. Энд өмнөх үе шатны дүгнэлтэд үндэслэн шүүх эсвэл чиг үүргийн байгууллага шийдвэр гаргана. Энэ үе шатаар үрчлэлтийн шийдвэр хууль ёсны болдог бөгөөд эцэг эх байх, хүүхэд байх эрх шилждэг.
- Үрчлэгдсэн хүүхдийг үрчилж авсан эцэг эх болон тухайн улс хооронд шилжүүлэх үе шат. Хууль ёсны шийдвэр гарсны дараа хүүхдийг эцэг эхэд шилжүүлэн өгнө.
- Үрчлэлтийн дараах хяналт, судалгаа, зөвлөн туслах үйлчилгээ, дэмжлэгийн үе шат. Хүүхэд шинэ гэр бүлдээ хэрхэн дасан зохицож байгаа эсэх, эцэг эхийн холбоо хэр үүсч байгаа эсэх, хүүхэд эрүүл аюулгүй өсч бойжиж байгаа эсэх дээр хяналт тавина. Шаардлагатай бол боловсролын зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө, санхүүгийн туслалцаа үзүүлнэ. Харин эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийг хамгаалах бүх төрлийн арга хэмжээг эхлүүлнэ.

Дөрөв. Докторын судалгааны ажилд харьцуулан судалсан Хятад, Америк, Франц, Герман зэрэг улсуудын эрх зүйн зохицуулалтад эцэг, эхэд тавигдах шаардлагыг илүү нарийвчлан тусгасан байна. Иймд эдгээр улсуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үр дүнд Гэр бүлийн тухай хуульд дараах зүйлийг зайлшгүй тусгах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн болон сэтгэцийн хувьд, санхүүгийн чадвар болон эзэмшсэн боловсролын хувьд, үрчлэгчийн түүх намтрын хувьд болон бусад шалтгааны улмаас хүүхдийг хэвийн асарч хүмүүжүүлэх боломжгүй этгээдэд хүүхэд үрчлэхийг хориглох
- Монгол улстай үрчлэлтийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй, Гаагийн конвенцод нэгдэж ороогүй, дайны болон онц байдал

зарласан, сүүлийн 10 жилийн дотор дайны байдалтай байсан, бусад амьдран суух болон өсөж торниход хүүхдэд аюултай эрсдэлтэй нийгэм, нөхцөл байдал бүхий улс оронд хүүхдийг үрчлүүлэхгүй байх

- Үрчлэлтийн хүсэлт гаргаснаас хойш шийдвэр гарах хүртэлх хугацааг зааж өгөх
- Хүүхдийн эрх ашгийн төлөө бус, өөр зорилгоор үрчлэлт хийгдэж байгааг хязгаарлах, хориглох
- Хүүхэд үрчлэлтийн бүхий л үйл явц хүүхдийн дээд эрх ашгийг эхэнд тавьж, хүүхдийн эрхийг хангах хамгаалах болон бүхий л эрсдэлтэй нөхцөл байдлаас сэргийлэхэд чиглэгдсэн байх

Тав. Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлтийг шийдвэрлэж байгаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар хуулийн хэрэглээ болон хүүхдийн эрх зөрчигдөж байгаа шалтгааныг олж тогтоохоор 2013-2023 оны хооронд шийдвэрлэсэн 332 хэргээс 55 хэргийг түүвэрлэж үрчлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцсон онцлогийг харгалзан 5 хэргийг сонгож авсан. Судлаачийн зүгээс дээрх хэргүүдээс сонголт хийж, хүсэлтийг хангасан болон хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлүүдийг шалгуур болгон дүн шинжилгээ хийхэд хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийн дээд ашиг сонирхолд харшилсан, хохирол учрах эрсдэлтэй нөхцөл байдлаас үүдэн үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай хүсэлт гаргахад, хүсэлтийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг шүүх гаргаж байна. Уг шийдвэр нь хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж байхад хуулийн зохицуулалт алга гэдгээр эрхийг нь хамгаалахгүйгээр эрх зөрчигчтэй үлдээж байгаа асуудал нь хүүхэд үрчлэлтийн гол зорилго болох хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах гэдгийг умартсан хэрэг юм. Иймд уг асуудалтай холбоотойгоор холбогдох санал дүгнэлтийг судалгаанд тулгуурлан боловсруулсан болно.

Зургаа. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил хангалтгүйн улмаас гадаад улс оронд үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Монгол улсаас хэрхэх ямар арга хэмжээ авах, үрчлэгдсэн хүүхдэд хэрхэн хяналт тавих зэрэг зохицуулалт тодорхойгүй байна. Иймд НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөж болон Гаагийн конвенцын хэрэгжилтийг хангах үүднээс дараах зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Үүнд, Үрчлэгдсэн хүүхдийн хяналтыг Монгол улсад суух элчин сайдын яам, Гадаад улсад суух Монгол улсын элчин сайдын яамаар дамжуулан тухайн улсын мэргэжлийн чиг үүргийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гадаад улс оронд үрчлэгдсэн хүүхдийг үрчилж авсан эцэг эх хүнд өвчин тусах, хөдөлмөрийн чадвараа алдах, мансууруулах бодисын хамааралтай болох, сэтгэцийн өвчтэй болох, хүүхэдтэй тараамжгүй харилцаатай болох, гэмт хэрэгт холбогдох, шоронд орох, амь насаа алдах гэх мэт харж хандах боломжгүй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, хүүхдэд сэтгэл санаа болон бие махбодын, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, үйлдэхээр завдсан, хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд татан оролцуулсан гэх мэт хүүхдийг аюултай нөхцөл байдалд оруулсан нь тогтоогдсон тохиолдолд хүүхдийн эрхийг

хамгаалах, буцаахтай холбогдсон тодорхой зохицуулалтыг Гэр бүлийн хууль болон холбогдох журмаар зохицуулах шаардлага тулгарч байна.

Долоо. ГИХАЭА-нд гадаад улсад хүүхдээ үрчлүүлэхдээ олон улсын байгууллага болон зуулчлалын агентлагуудын үнэлгээний журмуудыг шууд ашиглаж хэвшсэнийг үгүйсгэх аргагүй юм. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улс нь өөрийн гэсэн үнэлгээний мэдэгдэл, тайлан гаргахтай холбоотой журам батлан гаргаж байгаагүй учир судлаачийн зүгээс дараах тайлангийн загварыг орчуулан хавсаргаснаа санал болгож байна. Уг Тайлангийн загварууд нь Хүүхдийн эрхийн олон улсын Гаагийн конвенцын хүрээнд боловсруулагдсан жишиг загварууд болно. Үүнд:

Улс хоорондын үрчлэлтийг зөвшөөрсөн хүүхдийн мэдэгдэл

- Улс хоорондын үрчлэлтийн эмнэлгийн тайлан
- Улс хоорондын үрчлэлтийн хүүхдийн талаарх тайлан
- Улс хоорондын үрчлэлтийн үрчлэгч эцэг эхчүүдийн тайланг
- Улс хоорондын үрчлэлтийн дараах тайлан зэрэг болно.

Найм. Гэр бүлийн тухай болон бусад хуулиар үрчлэлтийн нууцыг хэн хэзээ ил болгох, эцэг эхээ мэдэх эрхийг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгахад шаардлагатай. Учир нь хүүхэд өөрийн эцэг эхээ биологийн гарал үүслийг мэдсэнээр өөрийн удам судраа мэдэх, удамшилын болон бусад өвчиний түүхээ мэдсэнээр өөрийгөө эмчлэх ирээдүйд үүсч болох аливаа эрсдэлээс хамгаалуулах боломжийг нээж өгөх ач холбогдолтой. Ийнхүү нээлттэй болгосноор цус ойртох, холилдохоос урьдчилан сэргийлэх, цаашлаад генийн удмын сангийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц элдэв сөрөг асуудлаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ. Иймд биологийн гарал үүслийг мэдэх эрхийг баталгаажуулахтай холбоотой зохицуулалтыг гэр бүлийн болон бусад хуулиар хуульчлах нь зүйтэй. Харин хэзээ, ямар нөхцөлд нээлттэй байлгах, ямар эрхийг хангаж өгөх зэрэг нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй байна. Иймд Гэр бүлийн тухай хуулиар 7 наснаас дээш үрчлэгдсэн хүмүүс үрчлэгдсэний дараа 18 насанд хүрсэн бол өөрийн үрчлэлттэй холбоотой хувийн мэдээлэлд хандах эрхийн асуудал, төрсөн эцэг эхийн нэр, холбогдох бүртгэлтэй танилцах эрхтэй эсэх асуудал, үрчлүүлэгч эцэг эх нь зөвшөөрсөн тохиолдолд үрчлэгдэгчийн хүсэлтийн дагуу хувийн бус мэдээллийг задруулж болох эсэх, үрчлэгдэгч зөвшөөрсөн тохиолдолд өөрийн мэдээлэлд хандах эрхийг төрсөн эцэг эхэд олгох эрх, үрчлэгдэгч хүүхэд болон үрчлэн авагч нар нь эрүүл мэндийн хэрэгцээнд үрчлүүлэгч нарын хувийн мэдээллийг олж авах эрхтэй байхаар, үрчлэгдэгч зөвшөөрөөгүй тохиолдолд үрчлүүлэгч эх хүүхдээ эрж хайх гэх мэт эрхийг олгох асуудлыг хуульчлах шаардлагатай юм.

Ес. Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөлд одоо дагаж мөрдөж байгаа гэр бүлийн хуулинд тусгагдаагүй шинээр нэмэгдэж орсон онцлох дараагийн зохицуулалт бол Зөвлөлийн саналыг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг Шүүхэд олгосон болно. Шүүхэд хүүхэд үрчлэх бүрэн эрхийг олгож байгаа нь хэр оновчтой

эсэх талаар чиг үүргийн байгуулагуудын мэргэжилтнүүдийн болон судлаачдын санал зөвлөгөөг анхаарч үзэх нь зүйтэй.

Найм. Эх сурвалж

Нэг. Монгол Улсын хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол улсын гэр бүлийн тухай хууль 1999 он
3. Монгол Улсын иргэний хууль 2002 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 он
6. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
7. Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
8. Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль, тогтоомж заавар журам УБ хот., 2002 он
9. БНМАУ-ын Иргэний хууль1926 он
10. БНМАУ-ын Гэр бүл асрамж тэтгэмжийн тухай хууль1956 он
11. Гэр бүлийн тухай хууль1973 он

Хоёр. Гадаад орнуудын хууль эрх зүйн акт

1. 中华人民共和国收养法1998
2. 中华人民共和国人口与计划生育法 2001
3. The Guarantee of Adopted Children's Rights and Interests by Intensive Protection Measures, 2011
4. 外国人在中华人民共和国收养子女登记办法 1993 он
5. 中国公民收养子女登记办法 1999
6. 外国人申请收养中国儿童应提交的材料 2017
7. Documents to be submitted when a foreigner applies to adopt a child from China 2017 он
8. Requirements for Intercountry Adoption Agencies in China 2017 он
9. Францын Иргэний хууль (Civil code)-ийн Үрчлэн авах тухай" бүлэг нэмсэн өөрчлөлт 2004 он
10. Төрийн асрамжийн газарт хүүхэд үрчлэн авах зөвшөөрөл хүссэн өргөдлийг үнэлэх журам 1998 он
11. Конвенцын де Ла Хай-тай "тохируулах" дүрэм 1993, 2001
12. Conseil national pour l'accès aux origines personalles (CNAOP) комиссын дүрэм. 2002 он
13. Үрчлэгчид үзүүлэх дэмжлэгийг сайжруулах зорилгоор үрчлэлтийн агентлагийн 744 тоот дүрэм, 2005 он
14. ХБНГУ-ын Иргэний хууль (*Gesetzbuch*)он 2021
15. ХБНГУ- ын Гэр бүлийн асуудлаарх журам 2009 он
16. Үрчлэлтийн зуучлалын тухай хууль 1976
17. Хүүхэд залуучуудын үйлчилгээний тухай хууль 1991 он
18. Хүүхэд залуучуудын үйлчилгээний тухай хууль (Kinder und Jugendhilfegesetz) 1998 он
19. Эцэг эхийн тухай хуулийн шинэчлэлийн тухай хууль 1997 он

20. Асран хамгаалагчийн тухай хууль 1997 он
21. Итали улсын Насанд хүрээгүй хүүхдийг үрчлэн авах тухай хуулийг 1983, 2001
22. Итали улсын Насанд хүрээгүй хүүхдүүдийг гадаад улсаас үрчлэн авсан эцэг эхийн тухай хууль 1983 он
23. Итали улсын Үрчлүүлэх, амлалт өгөх тухай хууль 2001 он
24. Итали улсын Гадаад улсаас үрчилж авсан эцэг эхийн тухай 2003 он
25. Итали улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 1992 он
26. Итали улсын Улс хоорондын үрчлэлтийн комиссын 184 тоот журам 2012

Гурав. Олон улсын гэрээ, конвенц

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1990 он
2. Хүүхдийг хамгаалах болон Улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц 1993 он
3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц 1999 он
4. "Хүүхэд хамгааллын тухай" конвенц 1996 он
5. НҮБ-ын ХЭХороо, Хүүхдийн Эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаархи дүгнэлт, зөвлөмж, УБ хот, 2010 он
6. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо, Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт зөвлөмж, УБ хот., 2017 он
7. Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл (504 тал) VI боть (1971-1985.IV сар)

Дөрөв. Монгол хэл дээрх нэг сэдэвт бүтээл болон сурах бичиг

1. Авирмэд Э. бусад "Монгол хууль", УБ, 1997
2. Амарсанаа Ж. "Хүний эрх-олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал, УБ., 2009 он
3. Амарсанаа Ж. Хүүхдийн эрхийн нэр томьёоны товч тайлбар толь, УБ хот., 2001 он
4. Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. 1 боть УБ, 2010 он
5. Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл III боть УБ. 2010 он
6. Амарсанаа Б нар БНХАУ-ын Иргэний хууль. УБ, 2021
7. Алтанцэцэг Ц. Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй УБ хот, 2007, 2011 он
8. Адьяасүрэн Ч. "Монгол ёс заншлын их тайлбар толь" УБ., 1992, 2000 он
9. Амарсайхан 0 Отгонтуяа О. Монгол Улсын Гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт. УБ 2009
10. Баярсайхан Б. Доктор "Монгол цаазын бичиг", УБ хот., 2001
11. Баярсайхан Д. Ромын эрх зүй. УБ., 2000 он
12. Баярсайхан Б. "Монгол цаазын бичиг", УБ хот, 2001, 2004
13. Батбаатар А. "Монгол Улсын Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал", УБхот 2005, 2007, 2021 он
14. Байгаль. Э."Олон улсын хувийн эрх зүй",УБ., 2012 249 дэх тал

15. Болдбаатар Ж., Лүндээжанцан Т. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал, УБ.,1997 он
16. Баттөмөр Б. Монгол Улсын иргэний эрх зүйн зарим асуудал. Уб, 2005
17. Батцэнгэл Г. Бандихүү Б. Гэр бүлийн сэтгэл судлал Уб., 2012.
18. Гаадамба Ш. "Монголын нууц товчоо" УБ хот 1990 он
19. Дугармаа А. "Монгол Улсын гэр бүлийн эрх зүй", Уб хот, 2005, 2007, 2017
20. Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. Уб., 1997 он
21. Кают Е. Иргэний хуулийн тайлбар. Уб, 2005.
22. Мөнхжаргал Т. "Гэр бүлийн эрх зүй" УБ хот., 2005
23. Ням-Осор Н. "Мөнх тэнгэрээс соёрхсон Чингис хааны их засаг хуулийн тайлбар" УБ хот.,2003 он
24. Намжил Т. Монгол гэр бүл судлал 1. Уб., 2006
25. Отгонбаяр Ч. "Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй" УБ хот, 2007
26. Оюунтунгалаг Ж. Харьцуулсан иргэний эрх зүй 6, 2013
27. Сэнгэдорж Т. "Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй". УБ., 2014
28. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь, УБ хот, 2000 62 дахь тал
29. Хууль зүйн үндэсний хүрээлэн. "Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй", УБ хот., 2018 он
30. Хүүхдийн эрхийн нэр томьёоны тайлбар толь, (УБ, 2011), х-44.
31. Хүний эрх, үр нөлөөтэй удирдлага сурвалж бичиг, УБ., 2011 он
32. Цэцэгмаа Ж.Гадаад орнуудын төр эрх зүйн түүх.УБ хот 2015 он
33. Буянхишиг Ж. Үүргийн эрх зүй. УБ., 2016 он

Тав. Гадаад хэл дээрх нэг сэдэвт бүтээл болон сурах бичиг

1. Barbara A. Moe-"Contemporary world issues", Adoption 2007
2. Kerry O'Halloran-"The Politics of Adoption International Perspectives on Law, Policy and Practice Fourth Edition" 2021
3. Edited by Gretchen Miller Wrobel, Emily Helder, and Elisha Marr-"THE ROUTLEDGE HANDBOOK OF ADOPTION" 2020
4. Brette McWhorter Sember-" The Adoption Answer Book: Your Compete Guide to a Successful Adoption (Parenting Answer Book) 2007
5. Judge F. A. Stockdale Sir William Houghton Departmental Committee on the Adoption of Children 21 July 1969 HMSO, 1972.
6. Benet, MK, The Character of Adoption , Jonathan Cape Ltd,, London, 1976
7. x22. Мөн Goody,E., Contexts of Kinship, Cambridge University Press, London, 1973
8. Gilligan, R., Irish Child Care Services: Policy, Practice and Provision, Institute of Public Administration, Dublin, 1991.
9. Middleton, N., When Family Failed, Victor Gollancz, London, 1971..
10. Druliolle, V., 'The Struggle for Recognition of the Stolen Children and the Politics of Victimhood in Spain', in Druliolle, V. and Brett, R. (eds.), The Politics of Victimhood in Post-conflict Societies: Comparative and Analytical Perspectives, London, Palgrave Macmillan, 2018..
11. Bean and Melville, Lost Children of the Empire , Unwin Hyman, London, 1989
12. United Nations Treaty Collection Conversion on the Rights of the Chald status, accessed April 14, 2018

13. Frank., R., 'Germany: Parentage Law Reformed', Bainham, A. (ed), The International Survey of Family Law , Martinus Nijhoff, The Hague, 1997, pp. 167–182, at p. 167.

Зургаа. Судалгааны бүтээл, өгүүлэл, нийтлэл, тайлан

1. Тайван А. “Монгол улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын асуудал” бакалаврын ажил. УБ хот., 2017
2. Янжинлхам Г. “Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтад тулгамдсан асуудал” 2017
3. Батзориг Б. “Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”
4. Maria i. Kuznetsova докторын диссертаци “Зүүн Европоос хүүхэд үрчилж авсан гэр бүлийн зохицуулалт” 2017
5. Саделва Гузель Миназымовна “Некоторые вопросы совершенствования законодательного регулирования и применения условий усыновления в России “Вестник Саратовской государственной юридической академии, область наук право” .,2015
6. Virginia Commonwealth University - A dissertation submitted in partial fulfillment of the requirements for the degree of Doctor of Adjustment of Families with Children Adopted, 2011 from Eastern Europe
7. Кепова Н.Г ”Эцэг, эхийн асрамжгүй хоцорсон хүүхдийн амьдралын асуудлыг шийдвэрлэх тогтолцоо дахь үрчлэлт”, дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл, М., 2012,
8. Ситкова О.Ю. “Олон улсын үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт”, дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл, М., 2012,
9. Тринченко К.О. Хил дамнасан үрчлэлт: эрх зүйн зохицуулалтын асуудал, хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Москва., 2021.
10. Пухарт А.А. ОХУ дахь үрчлэлтийн харилцааны эрх зүйн зохицуулалт, дэд докторын зэрэг горилсон бүтээл, Москва, 2013
11. “Үрчлэлт ба Хүүхдийн эрх”, ХЭҮК-ийн Хүний эрхийн цуврал нийтлэл (2014),
12. Хүний эрхийг хангах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц: хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо. Уб., 2011
13. ГИХА эрхлэх албаны тайлан, УБ хот.,2022,
14. Хүүхэд хамгааллын тайлан УБ хот.,2017
15. Үндэсний статистикийн хорооны тайлан УБ хот.,2022 он
16. ХГБХГ-ын 2022 оны тайлан, мэдээ УБ хот.,2022
17. Гадаад болон дотоод үрчлэлийн асуудалд дүн шинжилгээ хийх бодлогын зөвлөмж УБ хүт.,2013 он
18. Хүүхэд үрчлэлтийн харилцаа-хүүхэд хамгааллын бодлогын зарим асуудал түргэвчилсэн үнэлгээний тайлан 2014 он
19. ХГБХГ захиалга Бүтэн өнчин хүүхдийн судалгаа. УБ хот.,2022 он

Долоо. Сонин, сэтгүүл

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл:1992 №1
2. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1995 №13
3. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл.1999 №12,
4. “Төрийн мэдээлэл тусгай” дугаар эмхэтгэл 1-р боть 2004
5. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2010 №17
6. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2018 №07
7. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002 №20

8. МУҮСХ-ны IV улирлын тайлан, УБ хот, 2022
9. Ц.Алтанцэцэг, “Хүүхэд хамгаалал-гадаадын иргэн Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэх асуудлын эрх зүйн зохицуулалт ", Хүний эрх сэтгүүл Дугаар №1. (2008).
10. Ч.Алтангэрэл орчуулга, "Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх-Ерөнхий зөвлөмж" Хүний эрх сэтгүүл, Дугаар №2 (2014),
11. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл., УБ хот ХЭҮК, 2014 он